



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН СУДАЛГАА

ЦУВРАЛ 8

Улаанбаатар, 2022

ННА 67.3
ДАА 340.009
Ш-978



ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН СУДАЛГАА ЦУВРАЛ 8

СУДЛААЧИД:

1. Б.Хонгорзул, Ж.Содномдаржаа
2. С.Сүхчулуун

Дугаар хариуцсан редактор Н.Отгончимэг

© Нээлттэй Нийгэм Форум, 2022.

Энэхүү цувралд багтсан судалгаануудын дүгнэлт, санал нь судалгааг хийж гүйцэтгэсэн судлаачдын байр суурь, үзэл бодол бөгөөд Нээлттэй Нийгэм Форумын албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

ISBN 978-9919-9926-4-4

Шүүхийн шийдвэрийн судалгаа

ЦУВРАЛ 8



1

ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭР
ГҮЙЦЭТГЭЛТЭЙ ХОЛБООТОЙ МАРГААНЫГ ИРГЭНИЙ
ХЭРГИЙН ШҮҮХ ХЯНАН ШИЙДВЭРЛЭЖ БҮЙ БАЙДАЛ

9

2

ЗАХИРГААНЫ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ
ТУХАЙ ХУУЛИЙН «ХАНГАЛТТАЙ СОНИРХОЛ
ИЛЭРХИЙЛСЭН БАЙХ» ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭРЭГЛЭЭ

87

ӨМНӨХ ҮГ

Шүүхийн шийдвэрийн судалгаа цувралын энэхүү дугаарт захиргааны шүүхийн шийдвэртэй холбоотой хоёр тайланг танилцуулж байна.

Судлаач С.Сүхчулуун нь ННФ-ын тэтгэлгээр байгаль орчны бохирдолтой холбоотой нийтийн эрх ашгийн маргаан шийдвэрлэж байгаа шүүхийн практикийг судлан нийтэлж байсан бөгөөд энэ удаад тус судалгаанаас улбаалан захиргааны хэргийн шүүхэд төлөөлөх эрхийн хүрээнд “хангалттай сонирхол илэрхийлэх” зохицуулалтыг гүнзгийрүүлэн судалжээ. Энэхүү судалгаа нь иргэний нийгмийн байгууллагууд тэр дундаа нийтийн эрх ашгийг шүүхэд нэхэмжлэн хамгаалах процесст оролцогч талуудад чухал ач холбогдолтой эх сурвалж болно хэмээн найдаж байна.

Судлаач Б.Хонгорзул, Б.Содномдаржаа нар хамтран захиргааны шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн байдлыг судалж, шийдвэрийн биелэлтийг хангах талаарх маргаан иргэний шүүхийн харьяалалд байгаа нь захиргааны шүүхийн шийдвэр гүйцэтгэлд нөлөөлж байгааг тодорхой шийдвэрүүдэд үндэслэн дүгнэжээ.

Шүүхийн шийдвэрийн судалгааг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулан дагнасан судалгаа хийж буй судлаачид, шүүмж өгөх, хянан тохиолдуулах зэргээр судалгааны тайланг боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлсэн редактор Н.Отгончимэг нарт гүн талархал илэрхийлье.

ННФ-ын хэвлэн нийтэлсэн судалгаа, шинжилгээний тайлан, мэдээллийг www.forum.mn цахим хуудаснаас авч танилцах болон бусдад түгээх боломжтой.

ННФ-ын Гүйцэтгэх захирал
П.Эрдэнэжаргал

РЕДАКЦЫН ЗУРВАС

“Шүүхийн шийдвэрийн судалгаа” эмхэтгэлийн энэ удаагийн цувралд “Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлтэй холбоотой маргааныг иргэний хэргийн шүүх хянан шийдвэрлэж буй байдал”, “ЗХШХШТХ-ийн “хангалттай сонирхол илэрхийлсэн байх” зохицуулалтын хэрэглээ” сэдвээр захиргааны болон иргэний хэргийн шүүхийн шийдвэрүүдийг сонгон судалж, анализ шинжилгээ хийсэн судалгааг толилуулж байна.

Харилцан тэнцвэргүй эрх зүйн байдалтайгаар эрх зүйн харилцаанд оролцож байгаа захиргааны байгууллага ба иргэн, байгууллага хоорондын маргааныг шийдвэрлэх үүрэгтэй дагнасан шүүх байгуулагдаад 18 жил болж байгаа боловч тус шүүхээс гарсан шийдвэрийн биелэлт хүлээлтийн хэмжээнд хүрэхгүй байгаа нь санаа зовних асуудал болоод байна.

Судлаач Ж.Содномдаржаа, Б.Хонгорзул нар энэ асуудалд анхаарал хандуулж захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлтэй холбоотой маргааны практикийг судалжээ. Тус судалгаагаар захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн биелэлт сүүлийн 3 жилд 35-47 хувьтай байгаа нь тогтоогдсон. Гэвч сонирхолтой нь, шийдвэр биелүүлэхтэй холбоотой маргаан сүүлийн 10 жилд ердөө 8 гарчээ. Энэхүү судалгаанд газрын, төрийн албаны, нийтийн эзэмшлийн талбайн ашиглалттай холбоотой хэргийн шийдвэр гүйцэтгэлийн маргааныг хамруулсан ба ингэхдээ иргэний хэргийн шүүх шийдвэр гүйцэтгэлийн маргааныг шийдвэрлэх явцдаа захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн

агуулгыг хэрхэн авч үзэж байгаа талаар сонирхолтой ажиглалт хийж, дүгнэсэнтэй та бүхэн энэ цувралаас танилцах боломжтой.

Захиргааны хэргийн шүүхээр эрхээ хамгаалуулах, сэргээлгэх онцлог механизм Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 52 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт тусгагдсан байдаг. Тодруулбал, “Энэ хуулийн 52.2.4-т заасан нэхэмжлэлийн шаардлага, түүний үндэслэлд дараах зүйл хамаарна: 52.5.5. нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргаж байгаа этгээдийн хувьд маргаж байгаа асуудлын талаар хангалттай сонирхол илэрхийлсэн байх бөгөөд нийтийн ямар ашиг сонирхол хэрхэн зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй” гэсэн заалт бий.

Судлаач С.Сүхчулуун энэхүү “хангалттай сонирхол илэрхийлсэн байх” зохицуулалтын талаарх хууль тогтоогчийн үзэл санаа болон шүүхийн шийдвэр дэх тус зохицуулалтын хэрэглээ хоорондын харилцан хамаарлыг илрүүлэх зорилгоор холбогдох шүүхийн шийдвэрийг судалжээ. Энэ асуудлын хүрээнд “иргэн нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй эсэх буюу заавал төрийн бус байгууллага байх ёстой эсэх”, “хангалттай сонирхол илэрхийлсэн байх зохицуулалтыг хэлбэрийн төдий үнэлж, эсхүл огт үнэлэхгүй байгаа хэрэг”, “хангалттай сонирхол илэрхийлсэн байх зохицуулалтыг “нийтийн ямар ашиг сонирхол хэрхэн зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй” гэсэн ойлголттой хамтад нь үнэлж буй тохиолдол” зэрэг чиглэлээр асуудлын агуулгыг нэлээд гүнзгий судалж, сонирхолтой дүгнэлт хийсэн байна.

Энэхүү цувралд тусгагдсан судлаачдын дүн шинжилгээ нь хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангахад шүүгч, хуульчдад мэдээллийн суурь дата болж, цаашид хуулийг зөв, зохистой тайлбарлан хэрэглэх, нэгдмэл практик тогтооход тодорхой хувь нэмэр болно гэдэгт итгэж байна.

Дугаар эрхэлсэн редактор
Н.Отгончимэг

1

ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛТЭЙ ХОЛБООТОЙ МАРГААНЫГ ИРГЭНИЙ ХЭРГИЙН ШҮҮХ ХЯНАН ШИЙДВЭРЛЭЖ БҮЙ БАЙДАЛ

СУДЛААЧДЫН ТАНИЛЦУУЛГА



БУЯНЖАРГАЛЫН ХОНГОРЗУЛ

Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн захиргааны сургалт, судалгааны төвийн судлаач

2008-2013 онд МУИС-ийн Хууль зүйн сургуулийг эрх зүйн бакалавр, 2013-2015 онд Япон Улсын Нагояагийн Их сургуулийн Хууль зүйн сургуулийг хууль зүйн магистр, 2015-2018 онд мөн сургуулийн докторантурын хөтөлбөрт суралцсан. Иргэний процессын эрх зүй, шүүхийн бүс аргаар маргаан шийдвэрлэх эрх зүйг сонирхон судалдаг.



ЖАРГАЛСАЙХАНЫ СОДНОМДАРЖАА

МУИС-ийн Хууль зүйн сургуулийг бакалаврын зэрэгтэй төгссөн. 2015 оноос хойш өмгөөллийн үйл ажиллагааг эрхэлж буй.

Судлаачид:
Б.Хонгорзул (LL.M)
Ж.Содномдаржаа
(LL.B)

АГУУЛГА

ТАЛАРХАЛ.....	12
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ.....	13
УДИРТГАЛ.....	14

НЭГ. ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНЫ ЯВЦАД ҮҮССЭН МАРГААН.16

1.1. Харьяалал.....	16
1.2. Шүүхийн практик.....	21

ХОЁР. ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ 25

2.1. Нэхэмжлэгчийн эзэмшлийн газрын хэмжээг багасгаж, нэхэмжлэгчийн эрх, ашгийг зөрчсөн хэрэг.....	25
2.2. Нэхэмжлэгчийг урьд эрхэлж байсан ажил, албан тушаалд нь эгүүлэн тогтоосон шүүхийн шийдвэрийг үл биелүүлж, нэхэмжлэгчийн эрх, ашгийг хохироосон хэрэг.....	30
2.3. Нэхэмжлэгчийн албан тушаал, цолыг бууруулсан шийдвэр гаргаж, нэхэмжлэгчийг цаг хугацаа, эдийн засгаар хохироосон хэрэг.....	35
2.4. Нэхэмжлэгчийн албан тушаалыг бууруулсан шийдвэр гаргаж, нэхэмжлэгчийг цаг хугацаа, эдийн засгаар хохироосон хэрэг.....	38

2.5. Нийтийн эзэмшлийн талбайд хууль бусаар барилга барьж, нийтийн эрх ашигт халдсан хэрэг.....	41
ГУРАВ. ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙГ БИЕЛҮҮЛЭЭГҮЙ ЭТГЭЭДЭД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА.....	46
3.1. Одоогийн хуулийн зохицуулалт.....	46
3.2. Одоогийн хууль зүйн практик.....	49
3.3. Өмнөх хуулийн зохицуулалт	52
ДӨРӨВ. ХАРЬЦУУЛСАН ЭРХ ЗҮЙН СУДАЛГАА	54
4.1. Япон улсын зохицуулалт	54
4.2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой хууль тогтоомж	55
4.3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага.....	56
4.4. Захиргааны хэргийг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг биелүүлэхтэй холбоотой зарим зохицуулалт	59
4.5. Шүүхийн шийдвэрийн судалгаа	63
4.6. Захиргааны актыг хүчингүй болгосон шүүхийн шийдвэрийн хууль зүйн хүчин чадал, түүний үр нөлөө.....	73
ДҮГНЭЛТ, САНАЛ.....	76
АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ.....	81

ТАЛАРХАЛ

Сүүлийн жилүүдэд эрчимтэй өрнөж буй эрх зүйн шинэчлэлд судлаачдын санал, үзэл бодлыг тусгах боломжийг олгож, энэхүү судалгааг гүйцэтгэхэд бүхий л талын дэмжлэг үзүүлсэн Нээлттэй Нийгэм Форумын хамт олонд талархал илэрхийлье.

Түүнчлэн судалгааг гүйцэтгэхэд шаардлагатай тоон мэдээлэл болон бусад баримт, материалаар хангаж, хамтарч ажилласан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх газрын удирдлага болон шийдвэр гүйцэтгэгч нарт талархсанаа илэрхийлье.

Судалгааны баг

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АШГ	Ахлах шийдвэр гүйцэтгэгч
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
ЗХШХШТХ	Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
ЗХХШТХ	Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль
ЗХТХ	Захиргааны хариуцлагын тухай хууль
ЗШШТХ	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль
ИХШХШТХ	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
ИХШШГТХ	Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль (Япон)
НЗД	Нийслэлийн засаг дарга
НШГА	Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх алба
УДШ	Улсын Дээд шүүх
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ШГА	Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
ШШГТХ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль
ЭХ	Эрүүгийн хууль

УДИРТГАЛ

Эрх зүйт төрийг байгуулах, хүний эрхийг хамгаалахад захиргааны хэргийн шүүхийн ач холбогдол өндөр бөгөөд шүүхийн шийдвэр гарцаагүй биелэгддэг байх зайлшгүй шаардлагатай. Захиргааны хэргийн шүүх нь захиргааны хууль бус үйл ажиллагаанаас иргэний эрхийг хамгаалах, захиргааны байгууллага хууль ёсыг сахих хөшүүрэг буюу объектив эрхийн хамгаалалтыг бий болгоход оршдог.¹

Гэвч бодит байдал дээр захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн биелэлт хангалтгүй буюу НШГА-наас авсан сүүлийн гурван жилийн статистик мэдээгээр шүүхийн шийдвэр гүйцэтгэл дунджаар 40 хувьтай байна.

Хүснэгт 1. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн биелэлтийн хувь

№	Огноо	Биелүүлбэл зохих	Биелүүлсэн	Үлдэгдэл	Биелэгдсэн хувь
1	2019.12	280	134	146	47.8 %
2	2020.12	247	88	159	35.6 %
3	2021.11	267	97	170	36.3 %

Энэхүү судалгааны хүрээнд захиргааны хэргийн шүүхийн

¹ Г.Банзрагч, Эрх зүйт төр буюу захиргааны шүүх, Шүүх эрх мэдэл сэтгүүл, УБ., 2014/02, 32 дахь тал.

шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой маргааныг иргэний хэргийн шүүхээс хянасан байдал, тус шүүхээс гаргасан шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх замаар захиргааны хэргийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны эрх зүйн зохицуулалт, тулгамдаж буй асуудлыг тодруулахыг зорилоо.

Тус зорилгын хүрээнд шүүхийн шийдвэрийн цахим сангаас сүүлийн арван жилийн хугацаанд (2011-2019) захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлтэй холбоотой маргааныг иргэний хэргийн шүүх хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг хайхад найман хэргийн шүүхийн шийдвэр олдсон. Тэдгээр хэргийн шүүхийн шийдвэрийн агуулга болон шийдвэр гүйцэтгэлийн хувийн хэрэгтэй танилцаж, судалгааны сэдэвт хамааралтай, ач холбогдол бүхий гэж үзсэн таван хэргийн шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийсэн болно.

Судалгааг гүйцэтгэхдээ зөвхөн иргэний хэргийн шүүхийн шийдвэрээр хязгаарлахгүй тухайн хэрэгт бүхэлд нь дүн шинжилгээ хийх зорилт тавив. Тодруулбал захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн орчин, шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй захиргааны байгууллага, албан тушаалтанд хүлээлгэх хариуцлага, маргааны харьяалал зэргийг судалсан болно.

Шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ, өмнөх ба одоогийн холбогдох хууль зүйн зохицуулалт, түүний практик хэрэглээ зэргийг судалж, товч харьцуулсан судалгаа хийх замаар тулгамдсан асуудлыг тодорхойлох, шийдвэрлэх гарц, шийдэл дэвшүүлэхэд уг судалгааны зорилго, ач холбогдол оршино.

НЭГ. ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНЫ ЯВЦАД ҮҮССЭН МАРГААН

1.1. ХАРЬАЛАЛ

2002 онд батлагдсан ЗХХШтХ-д шүүхийн шийдвэр гүйцэтгэлтэй холбоотой дараах зохицуулалтууд байв.

93.1-т “Захиргааны хэргийн шүүхийн хуулийн хүчин төгөлдөр болсон шийдвэр (шийдвэр, магадлал, тогтоол, шүүгчийн захирамж)-ийг сайн дураар биелүүлээгүй тохиолдолд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 183-188 дугаар зүйл, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасны дагуу албадан биелүүлнэ”,

78 дугаар зүйлийн 78.1-т “Хэргийн оролцогчид Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн биелүүлэх үүрэгтэй”,

78.2-т “Захиргааны хэргийн шүүх шийдвэрээ биелүүлэх арга, журмыг гаргасан шийдвэртээ тодорхойлно”

Ийнхүү тус хуулийн 93 дугаар зүйлд заасны дагуу шүүхийн шийдвэр гүйцэтгэлтэй холбоо бүхий харилцааг ИХШХШтХ-иар зохицуулахаар заасан. 2002 оны ШШГтХ-д захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой

тусгайлсан зохицуулалт байгаагүй. Үүнийг УДШ-ээс тайлбар гаргах замаар шийдвэрлэсэн.

Тухайлбал, УДШ-ийн 2003.05.05-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор ШШГТХ-ийн зарим зүйл, хэсэг, заалтыг тайлбарлахдаа “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1-д “Иргэний хэргийн талаар гаргасан шийдвэр” гэдэгт захиргааны хэрэг шийдвэрлэсэн анхан шатны шүүхийн шийдвэр, давж заалдах шатны шүүхийн магадлал, хяналтын шатны шүүхийн тогтоол хамаарна...”, мөн 2007.11.29-ний өдрийн 43 дугаар тогтоолоор ШШГТХ-ийн зарим зүйл, хэсэг, заалтыг тайлбарлахдаа “10.1.1-д заасан **“иргэний хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр”** гэдэгт иргэний болон захиргааны хэргийн талаар гарсан анхан болон давж заалдах, хяналтын шатны шүүхийн шийдвэр, магадлал, тогтоол хамаарна” хэмээн адил тайлбар хийжээ.

2007.03.04-ний өдөр ШШГТХ-ийн 4.1 дэх заалтад “захиргааны” гэж нэмэлт өөрчлөлт оруулжээ. Өөрөөр хэлбэл, ШШГТХ-д захиргааны хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг тусгайлан зохицуулаагүй ч захиргааны хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хамааруулж ойлгохоор УДШ-ээс тайлбарласан тул иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай адил журмаар 2017 оныг хүртэл явж ирсэн.²

Гэвч иргэний болон захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг адилтган авч үзэх боломжгүй бөгөөд хоорондоо дараах хэдэн шинжээр ялгагдана:³

² ХЗҮХ, ШЭЗШ төсөл, Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн үр дагавар, УБ., 2005, 66 дахь тал.

³ Шүүгч Д.Батбаатарын танилцуулга, Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх ажиллагаа, <http://resource3.sodonvision.com/> 2021.12.07-ны өдөр хандав.

Хүснэгт 2. Ялгагдах шинж

Иргэний маргаан	Ялгагдах шинж	Захиргааны маргаан
Хувийн эрх зүй хүрээ	Эрх зүйн салбар	Нийтийн эрх зүй хүрээ
Нэг тал нь заавал захиргааны байгууллага, албан тушаалтан байхыг шаардахгүй.	Оролцогч	Нэг тал нь заавал захиргааны байгууллага, албан тушаалтан байдаг.
Эрх тэгш талуудын хооронд үүсдэг.	Талуудын байдал	Тэнцвэргүй талуудын хооронд үүсдэг.
Ихэвчлэн төлбөр төлөгч болон төлбөр авагчийн хооронд үүссэн харилцаа байдаг.	Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тал	Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах хүсэлт гаргагч - эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдсөн иргэн, хуулийн этгээд байдаг. Шийдвэр гүйцэтгэх тал нь захиргааны байгууллага, албан тушаалтан байдаг.
Төлөөлөн гүйцэтгэх боломжтой шийдвэр гардаг.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэл ⁴	Дийлэнх хэсэг нь төлөөлөн гүйцэтгэх боломжгүй бөгөөд захиргааны байгууллага, албан тушаалтан өөрөө гүйцэтгэх шийдвэр байдаг. Цөөн тооны төлөөлөн гүйцэтгэх боломжтой шийдвэр гардаг.

⁴ А.Эрдэнэцогт “Монгол Улсын Захиргааны процессын эрх зүй” УБ хот, 2006 он, 304 дэх тал.

Иргэний болон захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн адил тал нь иргэн, хуулийн этгээдийн зөрчигдсөн эрхийг сэргээхэд оршдог.⁵

2008 онд шүүхийн шийдвэр гүйцэтгэгч нараас авсан социологийн судалгаагаар “Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр биелүүлэх эрх зүйн зохицуулалт дутагдалтай бөгөөд шүүгчид шийдвэртээ тухайн шийдвэрийг биелүүлэх арга, замыг заах үүргээ биелүүлдэггүй гэж шүүмжилсэн” байдаг.⁶ УДШ-ийн 2006.07.03-ны өдрийн 37 дугаар тогтоолоор ЗХШХШТХ-ийн зарим зүйл, заалтыг тайлбарлахдаа “Хуулийн 78 дугаар зүйлийн 78.2-т заасан “Захиргааны хэргийн шүүх шийдвэрээ биелүүлэх арга, журмыг гаргасан шийдвэртээ тодорхойлно” гэдэгт Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр, магадлал, тогтоол, шүүгчийн захирамжийн тогтоох хэсгийн заалтыг хэн, хэзээ, яаж, хэрхэн биелүүлэх, биелэлтийг нь хэрхэн тооцох талаар тогтоох хэсэгт тодорхой тусгахыг ойлгоно” гэж тайлбарласан байдаг.

2002 оны ЗХШХШТХ-ийн 78.2-т заасан тус зохицуулалт бодит байдал дээр хангалттай сайн хэрэгжиж чадалгүй 2016 оны ЗХШХШТХ-аас хасагдсан. Зарим судлаачийн зүгээс ЗХШХШТХ-ийн 78.2 дахь зохицуулалтыг төлөөлөн гүйцэтгэж болохгүй буюу захиргааны байгууллага, албан тушаалтны өөрөө тухайн шийдвэрийг биелүүлэх арга, журмыг тодорхойлоход зориулагдсан зохицуулалт хэмээн үздэг.⁷

2016 онд батлагдсан ЗХШХШТХ-аар шүүхийн шийдвэр гүйцэтгэлтэй холбогдох харилцааг тусгай бүлэг болгон зохицуулсан ч хэрэгжилтийг ШШГТХ-аар нарийвчлан зохицуулахаар шилжүүлжээ.

⁵ Д.Лхагвасүрэн, Д.Энхтуяа, Захиргааны хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, УБ., 2016, 59 дэх тал.

⁶ Дэлхийн банк, ХЗҮХ, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны төлөвшил (судалгааны тайлан), хүрээнд УБ., 2008, 66-67 дахь тал.

⁷ А.Эрдэнэцогт, Монгол Улсын Захиргааны процессын эрх зүй, УБ., 2006, 305 дахь тал.

135 дугаар зүйл. Шүүхийн шийдвэрийг биелүүлэх

135.1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэхтэй холбоотой ажиллагааг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн дагуу явуулна.

136 дугаар зүйл. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх үндэслэл

136.1. Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх үндэслэл нь шүүхийн шийдвэр болон түүний үндсэн дээр олгогдох гүйцэтгэх хуудас байна.

2017 онд ШШГТХ-ийг шинэчлэн найруулсан бөгөөд өмнөх хуулиас ялгаатай давуу тал нь захиргааны хэргийн шүүхийн гүйцэтгэх ажиллагааны талаар 14 дүгээр бүлэгт тусгайлан зохицуулсан нь өмнөх хуулиас дэвшилттэй ч тухайн харилцааг бүрэн зохицуулсан гэж үзэхгүй хэмээн судлаачид өөрсдийн байр сууриа илэрхийлсэн байдаг.⁸ Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн хувь жил ирэх тусам буурсан, Төрийн албаны тухай хуульд заасны дагуу шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй албан тушаалтанд сахилгын хариуцлага тооцох, олон нийтэд мэдээлэх зэрэг арга хэмжээ авах боломжтой ч шүүхийн шийдвэрийг биелүүлэх хөшүүрэг болж чадахгүй байна. ШШГТХ-аар шүүхэд хандаж болох үндэслэлийг зохицуулжээ. Үүнд:

131.1. Ахлах шийдвэр гүйцэтгэгч дараах үндэслэлээр захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагааг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн дуусгавар болсонд тооцож, захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хувийн хэргийг хаана:

131.1.1. Гүйцэтгэх баримт бичиг, эсхүл түүний үндэслэл болох шийдвэрийг хүчингүйд тооцох тухай ШҮҮХ, бусад байгууллага, албан тушаалтны шийдвэр гарсан;

⁸ Ц.Цогт, Монгол Улсын Захиргааны хэргийн шүүхийн эрх зүйн орчин, дүн шинжилгээ, УБ., 2017, 18 дахь тал.

Шийдвэр гүйцэтгэх баримт бичиг, эсхүл түүний үндэслэл болох шийдвэрийг хүчингүйд тооцохтой холбоотой маргааныг шүүхээр шийдвэрлүүлэхээр зохицуулсан.

Гэвч ШШГТХ-д аль шүүхээр хянан шийдвэрлүүлэх талаар тодорхой зохицуулалт байхгүй. Захиргааны хэргийн шүүхэд захиргааны акт, захиргааны гэрээ, захиргааны хэм хэмжээний акттай холбоотой маргааныг хянан шийдвэрлэдэг тул ИХШХШТХ-ийн 12 дугаар зүйлийн 1.4-т “Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлд зааснаас бусад байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа болон тэдгээрийн гаргасан захиргааны актын талаар гаргасан гомдол”-д иргэний хэрэг үүсгэж болно гэсэн ерөнхий харьяаллын дагуу шийдвэрлэж байна.

1.2. ШҮҮХИЙН ПРАКТИК

Дүн шинжилгээ хийсэн таван хэргийн шүүхийн шийдвэрийн талаар товч танилцуулъя.

Хүснэгт 3. Шүүхийн шийдвэрийн товч танилцуулга

№	Шүүхийн шийдвэрийн дугаар, огноо	Нэхэмжлэлийн шаардлага	Шийдсэн байдал
1	Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2011.12.20-ны өдрийн 13 дугаар шийдвэр	Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгосон шийдвэр гүйцэтгэчийн шийдвэрийг хүчингүй болгох.	Нэхэмжлэлийн шаардлагыг хангасан.
2	Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2015.11.17-ны өдрийн 7809 дугаар шийдвэр	Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгосон шийдвэр гүйцэтгэчийн шийдвэрийг хүчингүй болгох.	Нэхэмжлэлийн шаардлагыг хангасан.

3	Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 101/ШШ2016/03595 дугаар шийдвэр Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2016.06.20-ны өдрийн 1192 дугаар магадлал Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүгчийн 2016.08.30-ны өдрийн 579 дугаар захирамж	Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгосон, шийдвэр гүйцэтгэгчийн шийдвэрийг хүчингүй болгох.	Нэхэмжлэлээсээ татгалзаж, хэргийг хэрэгсэхгүй болгосон.
4	Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 181/ШШ2016/01002 дугаар шийдвэр Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017.01.27-ны өдрийн 290 дүгээр магадлал УДШ-ийн (иргэний танхим) 2017.04.18-ны өдрийн 461 дүгээр тогтоол	Хариуцагч шийдвэр гүйцэтгэсэнд тооцуулж, шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг дуусгавар болгох шаардлага гаргасан.	Нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангасан.
5	Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017.07.26-ны өдрийн 2030 дугаар шийдвэр	Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явуулахыг даалгах шаардлага гаргасан.	Нэхэмжлэлээсээ татгалзаж, хэргийг хэрэгсэхгүй болгосон.

6	Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018.03.30-ны өдрийн 628 дугаар шийдвэр Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018.06.08-ны өдрийн 1347 дугаар магадлал УДШ-ийн (иргэний танхим) 2018.11.01-ний өдрийн 1541 дүгээр тогтоол	Хариуцагч шүүхийн шийдвэрийг гүйцэтгэсэнд тооцуулж, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг дуусгавар болгох шаардлага гаргасан.	Нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгосон.
7	Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2019.07.22-ны өдрийн 1566 дугаар шийдвэр	Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгосон шийдвэр гүйцэтгэчийн шийдвэрийг хүчингүй болгох.	Нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгосон.
8	Төв аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2019.10.15-ны өдрийн 1052 дугаар шийдвэр	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үндэслэлгүйгээр дуусгавар болгож, шийдвэр гүйцэтгэлийн баримтыг буцаасан гэх үндэслэлээр маргасан.	Нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэсэн.

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбогдох маргааны тав нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үндэслэлгүй дуусгавар болгосонтой холбоотой, хоёр маргаан нь хариуцагч шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болсонд тооцуулах, нэг маргаан нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулахыг даалгах нэхэмжлэлийг тус тус гаргажээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь эрүү, иргэн, захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг гүйцэтгэдэг. Эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоо бүхий хэргийг прокурор, эрүүгийн хэргийн шүүх, иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой маргааныг иргэний хэргийн шүүх харьяалан шийдвэрлэдэг.

Харин захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоо бүхий маргааныг иргэний хэргийн шүүх харьяалан шийдвэрлэж буй. Хууль зүйн зохицуулалтын хувьд хангалтгүй бөгөөд ерөнхий харьяаллын дагуу хянан шийдвэрлэдэг.

ХОЁР. ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ

2.1 НЭХЭМЖЛЭГЧИЙН ЭЗЭМШЛИЙН ГАЗРЫН ХЭМЖЭЭГ БАГАСГАЖ, НЭХЭМЖЛЭГЧИЙН ЭРХ, АШГИЙГ ЗӨРЧСӨН ХЭРЭГ

Маргааны үйл баримт

Нэхэмжлэгч ... ХХК нь 2011 оноос Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт 452 м.кв газрыг эзэмшдэг, газар эзэмших гэрчилгээг таван жилийн хугацаатайгаар олгосон. 2016 оны 06 дугаар сард газар эзэмших гэрчилгээний хугацаа дуусгавар болж буйтай холбогдуулан хугацааг сунгуулах хүсэлт гаргасан ч НГА-аас “танай компанийн эзэмшиж буй нэгж талбар нь Улаанбаатар хотын газрын мэдээллийн санд алдаатай бүртгэгдсэн байх тул уг зөрчлийг арилгаж барилгын сууриар кадастрын зургийг дахин хийлгэж ирүүлэх шаардлагатай” гэж мэдэгджээ.

Нэхэмжлэгч үүнийг эс зөвшөөрч шүүхэд хандсан байна. Нэхэмжлэгч ... ХХК нь НЗД, НГА-д тус тус холбогдуулан “Нэхэмжлэгч ... ХХК-ийн газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгахыг хүссэн 2016 оны хүсэлтийг шийдвэрлэхгүй байгаа НГА-ны эс үйлдэхүй хууль бус болохыг тогтоолгож, гэрчилгээний хугацааг сунгахыг НЗД-д даалгуулах” шаардлагатай нэхэмжлэл гаргаж, хэргийг шийдвэрлүүлсэн.⁹

⁹ Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2017.11.29-ний өдрийн 0887 дугаар шийдвэр.

Захиргааны хэргийн шүүхээс нэхэмжлэгч ... ХХК-ийн газар эзэмших эрхийн гэрчилгээ эзэмших ямар нөхцөлийг зөрчсөн болохыг тодорхой заагаагүй, нэхэмжлэгч ... ХХК-ийн шилжүүлэн авч эзэмшиж буй газрын эргэлтийн цэг өөрчлөгдөөгүй байхад нэхэмжлэгчийн эрх бүхий газрын хэмжээг багасган, байшингийн сууриар зураг хийлгэх шаардлага тавьсан хариуцагч НГА-ны үндэслэл тодорхойгүй бөгөөд хууль бус болжээ. Иймд нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж, нэхэмжлэгч ... ХХК-ийн газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа сунгуулах хүсэлтийг шийдвэрлэхгүй байгаа НГА-ны эс үйлдэхүй хууль бус болохыг тогтоож, гэрчилгээний хугацааг сунгахыг НЗД-д даалгаж шийдвэрлэсэн байна. Гэсэн ч шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдаж НШГА-ны АШГ нь шийдвэр гүйцэтгэх ажиллагаа дуусгавар болгох тухай тогтоол гаргажээ.

Иргэний хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах болсон үндэслэл

Нэхэмжлэгч ... ХХК-аас НШГА-ны АШГ Ө-д холбогдуулан шийдвэр гүйцэтгэх ажиллагаа дуусгавар болсон тухай тогтоолыг хүчингүй болгуулах нэхэмжлэл гаргасан байна. Учир нь НШГГ-ын АШГ нь НГА-ны дэргэдэх Газар эзэмших, ашиглах эрхийг хянан шийдвэрлэх зөвлөлийн 2018.02.22-ны өдрийн хурлаар оруулж, НЗД-ын 2018.03.27-ны өдрийн А/255 дугаар захирамжаар газар эзэмших эрхийг 15 жилийн хугацаагаар эзэмшүүлэхээр шийдвэрлэж, шүүхийн шийдвэрийг биелүүлсэн хэмээн мэдэгджээ.

Гэтэл НЗД-ын 2018.03.27-ны өдрийн А/255 дугаар захирамжаар нэхэмжлэгч ... ХХК-ийн газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа сунгахдаа 452 м.кв талбайн хэмжээг бууруулж 390 м.кв болгож газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгасан учир нэхэмжлэгч эс зөвшөөрч иргэний хэргийн шүүхээр шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгох үндэслэлгүй хэмээн маргасан байдаг.

Хариуцагч НШГА-ны АШГ Д.Ө нь НГА-ны эс үйлдэхүйг хууль бус болохыг тогтоож, гэрчилгээний хугацааг сунгахыг НЗД-д даалгаж шийдвэрлэснийг хариуцагч биелүүлсэн байх тул ШШГТХ-ийн 29.1.5-д заасны дагуу гүйцэтгэх баримт бичгийг хааж, хэргийг дуусгавар болгосон гэж тайлбарладаг.

Шүүхийн шийдвэрлэсэн байдал

Анхан шатны шүүх¹⁰

Нэхэмжлэгч ШШГТХ-ийн 133.2-т “Захиргааны байгууллага, албан тушаалтан шүүхийн шийдвэрийг биелүүлэх үйлдэл, эс үйлдэхүйг гүйцэтгэсэн боловч шүүхээс хууль бус болохыг нь тогтоосон шийдвэрийг дахин гаргах зорилгоор өөрийн бүрэн эрхэд хамаарах эрх зүйн акт, албан тушаалд тавигдах нийтлэг шаардлага, шалгуур үзүүлэлтийг өөрчилж, нэхэмжлэгчийн эрхийг дахин зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг шүүхийн шийдвэрийг биелүүлсэнд тооцохгүй” гэж заасан ба НЗД хэдийгээр газар эзэмших эрхийг сунгасан шийдвэр гаргасан ч эрх зүйн актын шалгуур үзүүлэлтийг өөрчилж, газрын хэмжээг багасгаж, нэхэмжлэгч ... ХХК-ийн эрхийг зөрчсөн үйлдэл гаргасан. Иймийн тул шүүхийн шийдвэрийг биелүүлсэн гэж үзэхгүй гэж маргасан.

Гэвч шүүхээс нэхэмжлэгчийн шаардлагыг НШГА-ны шийдвэр гүйцэтгэгч хүлээн авч гүйцэтгэх хууль зүйн үндэслэлгүй гэж үзээд нэхэмжлэгч ... ХХК-ийн тус шүүхэд гаргасан нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байдаг.

¹⁰ Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2019.07.22-ны өдрийн 1566 дугаар шийдвэр.

Дүн шинжилгээ

Шүүхийн шийдвэрт дурдсан ШШГТХ-иар шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулах арга, журам, дарааллыг нарийвчлан тогтоож, тусгайлан зохицуулсан заалтыг хэрэгжүүлэх нь гагцхүү шийдвэр гүйцэтгэх байгууллагын болон шийдвэр гүйцэтгэгчийн үүрэг гэж дүгнээд, АШГ-ийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгосон шийдвэрийн талаар тодорхой дүгнэлт өгөлгүй зайлсхийсэн нь үндэслэлгүй юм. Учир нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад АШГ-ийн гаргасан шийдвэр нь захиргааны хэргийн шүүхээр хянагдах боломжгүй тул иргэний хэргийн шүүх ШШГТХ-д заасан журмын дагуу шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулсан уу, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгосон шийдвэр нь үндэслэлтэй эсэхийг хянан шийдвэрлэх ёстой.

Хэрвээ иргэний хэргийн шүүх АШГ-ийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгосон шийдвэрийг хянах үндэслэлгүй гэж үзсэн нөхцөлд өөр ямар шүүх хянах боломжтой вэ гэдгийг тодорхой зохицуулах хэрэгтэй. Мөн ШШГТХ-ийн 133.2-т заасан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэсэнд тооцохгүй нөхцөлд яагаад хамаарахгүй талаар шүүх тодорхой дүгнэлт өгөлгүйгээр хүлээн авах үндэслэлгүй хэмээн орхигдуулсан байна.

Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2017.11.29-ний өдрийн 0887 дугаар шийдвэрийн тогтоох хэсэгт нэхэмжлэгч ... ХХК-ийн газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгахдаа 452 мкв хэмжээтэйгээр сунгах талаар тусгаагүй. 2016 онд газрын эрхийн гэрчилгээний хугацаа сунгуулах хүсэлт гаргахдаа газрын хэмжээг хэвээр буюу 452 мкв байхаар сунгуулах хүсэлт гаргасан. Шүүхээс “нэхэмжлэгч ... ХХК-ийн шилжүүлэн авч эзэмшиж байгаа газрын эргэлтийн цэг өөрчлөгдөөгүй байхад нэхэмжлэгчийн эрх бүхий газрын хэмжээг багасган, байшингийн сууриар зураг хийлгэх шаардлага тавьсан хариуцагч Нийслэлийн газрын албаны

үндэслэл тодорхойгүй бөгөөд хууль бус болжээ” гэж дүгнэсэн.

Өөрөөр хэлбэл, 2017 онд захиргааны хэргийн шүүхээс эс үйлдэхүй гаргахдаа газрын хэмжээг бууруулах шаардлага нь хууль бус гэдгийг нэгэнт тогтоосон байхад шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад хариуцагч нар нь газрын хэмжээг бууруулж шүүхийн шийдвэрийг биелүүлсэн байдалд АШГ, иргэний хэргийн шүүхээс “Захиргааны хэргийн шүүхийн тодорхойлох хэсэгт 452 мкв хэмжээтэйгээр сунгах” гэж тусгагдаагүй, зөвхөн газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгах гэж заасан, ямар хэмжээтэйгээр сунгах нь шийдвэр гүйцэтгэлд хамааралгүй, иргэний хэргийн шүүх хянах үндэслэлгүй гэж дүгнэж буй нь шүүхийн шийдвэр заавал биелэгдэх, шийдвэрийн хууль зүйн хүчин чадлыг үгүйсгэсэн шийдвэр болжээ. Дээрх иргэний хэргийн шүүхийн шийдвэрээс шалтгаалж, нэхэмжлэгч ... ХХК нь уг маргааныг дахин захиргааны хэргийн шүүхээр хянан шийдвэрлүүлсэн байна.

Захиргааны байгууллага албан тушаалтны шийдвэрийг захиргааны хэргийн шүүхээс хууль зөрчсөн гэдгийг тогтоож хүчингүй болгосон байхад дахин алдаатай шийдвэрийг удаа дараа гаргаж иргэн, хуулийн этгээдийн эрх хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөөр буй нь захиргааны хэргийн шүүхэд хянан хэлэлцэгдэж буй маргааны төрөл, тоо баримт, дээрх тохиолдлоос харагдаж байна.¹¹

Удаа дараа хууль бус, алдаатай захиргааны акт гаргаж буй захиргааны байгууллага, албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх, иргэд, хуулийн этгээдийн хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх шаардлага захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд үгүйлэгдэж байна.

¹¹ Ц.Цогт, Захиргааны шинэтгэл ба захиргааны хэргийн шүүх, Хүний эрх сэтгүүл, 2012.01.

2.2 НЭХЭМЖЛЭГЧИЙГ УРЬД ЭРХЭЛЖ БАЙСАН АЖИЛ, АЛБАН ТУШААЛД НЬ ЭГҮҮЛЭН ТОГТООСОН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙГ ҮЛ БИЕЛҮҮЛЖ, НЭХЭМЖЛЭГЧИЙН ЭРХ, АШГИЙГ ХОХИРООСОН ХЭРЭГ

Маргааны үйл баримт

НЗД-ын дэргэдэх Цагдаагийн хэв журмын хэлтсийн уулзалт, байцаалтын хэсгийн даргаар ажиллаж байсан нэхэмжлэгчийг цэргийн байнгын тэтгэвэрт гаргаж, 35 сарын цалин хөлстэй тэнцэх нэг удаагийн тэтгэмжийг олгохоор шийдвэрлэсэн. Нэхэмжлэгч нь ЦЕГ-ын даргын 2007.01.29-ний өдрийн 40, мөн оны 03.07-ны өдрийн 89 дүгээр тушаалуудын өөрт холбогдох хэсгийг эс зөвшөөрч Нийслэлийн Захиргааны хэргийн шүүхэд 2007 оны 05 дугаар сард нэхэмжлэл гаргажээ.

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээс нэхэмжлэгчийг урьд эрхэлж байсан үүрэгт ажилд эгүүлэн тогтоох, ажилгүй байсан хугацааны цалин буюу 2007.03.16-ны өдрөөс 2007.07.30-ны өдрийг хүртэл тооцож нэхэмжлэгчид олгохыг ЦЕГ-ын даргад даалгаж шийдвэрлэсэн.¹² ЦЕГ-ын даргын 2007 оны 40 дүгээр тушаалаар нэхэмжлэгчийг 2007.01.26-ны өдрөөр тасалбар болгон тэтгэвэрт гаргах үед 54 нас 11 сар 25 хоногтой байсан бөгөөд давж заалдах шатны шүүх түүнийг 55 нас хүрээгүй байхад ажлаас чөлөөлсөн нь хууль зөрчсөн гэж дүгнэсэн байна.

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн дагуу ЦЕГ-ын даргын 2007 оны 40, 89 дүгээр тушаалууд хууль бус болохыг тогтоосон тул ЦЕГ-ын дарга 2008.03.12-ны өдрийн 127 дугаар

¹² Нийслэлийн Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2007.07.30-ны өдрийн 191 дүгээр шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2007 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн 167 дугаар магадлал, УДШ-ийн хяналтын шатны Захиргааны хэргийн шүүхийн 2007.11.12-ны өдрийн 111 дүгээр тогтоол, УДШ-ийн 2008.02.04-ний өдрийн 07 дугаар тогтоолоор тус тус эцэслэн шийдвэрлэсэн.

тушаалаар хүчингүй болгож, Монгол Улсын Иргэний цэргийн үүргийн болон цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 13.1.2, Цэргийн албан хаагчийн тэтгэврийн тухай хуулийн 8.1, 19.1-д заасныг тус тус баримтлан 2007.07.30-ны өдрөөс тасалбар болгон ажлаас чөлөөлж 35 сарын цалин хөлстэй тэнцэх хэмжээний тэтгэмжийг нэг удаа тогтоож алба хаах насны дээд хязгаарт хүрсэн тул тэтгэвэрт гаргахаар шийдвэрлэжээ.

Иргэний хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах болсон үндэслэл

Захиргааны хэргийн шүүхээс “ЦЕГ-ын даргын 2007 оны 40, 89 дүгээр тушаалуудын нэхэмжлэгчид холбогдох хэсгийг хүчингүй болгож, нэхэмжлэгчийг НЗД-ын дэргэдэх Цагдаагийн газрын хэв журмын хэлтсийн уулзалт, байцаалтын хэлтсийн даргын үүрэгт ажилд нь эгүүлэн тогтоосугай” гэж шийдвэрлэсэн.

Нэхэмжлэгч нь шүүхийн шийдвэрийг албадан биелүүлэх ажиллагаа эхэлсэн боловч ажилд эгүүлэн тогтоох шийдвэр биелэгдээгүй тул шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгох үндэслэлгүй гэж маргадаг.

ЦЕГ-аас 2016 онд “Нийслэлийн Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2007.07.30-ны өдрийн 191 дүгээр шийдвэрийн дагуу шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа биелэгдэж дуусгавар болсонд тооцуулах тухай” нэхэмжлэлийн шаардлагыг НШГА-д холбогдуулан гаргасан. Бие даасан шаардлага гаргаагүй гуравдагч этгээдээр нэхэмжлэгч тус хэрэгт оролцсон байна.

Шүүхийн шийдвэрлэсэн байдал

*Анхан шатны шүүх*¹³

ЦЕГ нь шүүхийн шийдвэрийн зарим хэсгийг биелүүлж, нэхэмжлэгчийг үүрэгт ажилд эгүүлэн томилох хэсгийг биелүүлээгүй болох нь шүүхийн шийдвэр биелүүлэх албаны тайлбар, ЦЕГ-т удаа дараа хүргүүлж байсан мэдэгдлүүд болон хэрэгт авагдсан нотлох баримтуудаар тогтоогдож байна.

ЦЕГ нь нэхэмжлэгчийг ажлаас нь чөлөөлсөн шийдвэрээ 2008.03.12-ны өдрийн 127 дугаар тушаалаар хүчингүй болгосон боловч түүнийг урьд эрхэлж байсан ажил, албан тушаалд нь эгүүлэн тогтоосон тушаал, шийдвэр гаргаагүй байх тул шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа биелэгдэж, дуусгавар болсонд тооцох үндэсгүй гэж үзээд ЦЕГ-аас гаргасан нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.

*Давж заалдах шатны шүүх*¹⁴

ЦЕГ-ын даргын 2008.03.12-ны өдрийн 127 тоот тушаалаар хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг биелүүлж өмнө гаргасан тушаалын нэхэмжлэгчид холбогдох хэсгийг хүчингүй болгосон байх бөгөөд уг тушаалаар түүнийг дахин үүрэгт ажлаас нь чөлөөлж, тэтгэмж олгохоор шийдвэрлэсэн байх боловч тэрээр уг тушаалын үндэслэлд эрх бүхий этгээдэд гомдол гаргаж шийдвэрлүүлээгүй болох нь хэрэгт авагдсан баримт болон талуудын тайлбараар тогтоогдож байна. Гэтэл анхан шатны шүүх ажилтныг үүрэгт ажилд нь эгүүлэн томилоогүй тул шүүхийн шийдвэр биелэгдээгүй гэж дүгнэсэн нь үндэслэлгүй болжээ.

¹³ Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016.10.18-ны өдрийн 181/ШШ2016/01002 дугаар шийдвэр.

¹⁴ Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017.01.27-ны өдрийн 290 дугаар магадлал.

Тодруулбал хариуцагч байгууллага нь 2008 оны 127 дугаар тушаалаараа 40, 89 дүгээр тушаалуудын нэхэмжлэгчид холбогдох хэсгийг хүчингүй болгож, 35 сарын цалин хөлстэй тэнцэх хэмжээний тэтгэмжийг нэг удаа тогтоож, ажилгүй байсан хугацааны цалинг 2007.03.16-07.30-ны өдөр хүртэл бодож олгохоор шийдвэрлэсэн нь ШШГТХ-ийн 67 дугаар зүйлийн 67.3-т зааснаар шүүхийн шийдвэр биелэгдсэнд тооцох үндэслэл болж байна. Иймд ЦЕГ нь ШШГТХ-ийн 67 дугаар зүйлийн 67.3-т заасны дагуу хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг биелүүлсэн гэж үзнэ.

Анхан шатны шүүхийн шийдвэр тогтоох хэсгийн 1 дэх заалтын “шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа биелэгдэж дуусгавар болсонд тооцуулах тухай ЦЕГ-ын нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосугай” гэснийг “шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа биелэгдсэн болохыг тогтоосугай” гэж өөрчлөн, шийдвэрийн бусад заалтыг хэвээр үлдээсэн буюу нэхэмжлэлийг бүхэлд нь хангаж, шүүхийн шийдвэр биелэгдсэнд тооцсон.

*Хяналтын шатны шүүх*¹⁵

Давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэсэн байна.

Дүн шинжилгээ

Иргэний хэргийн давж заалдах, хяналтын шатны шүүхээс захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн “НЗД-ын дэргэдэх Цагдаагийн газрын хэв журмын хэлтсийн уулзалт, байцаалтын хэлтсийн даргын үүрэгт ажилд нь эгүүлэн тогтоосугай” гэх шийдвэрийг биелэгдээгүй гэдгийг хүлээн зөвшөөрсөн.

Гэвч ЦЕГ-ын даргын 2008 оны 127 дугаар тушаалаар

¹⁵ УДШ-ийн (иргэний танхим) 2017.04.18-ны өдрийн 461 дүгээр тогтоол.

нэхэмжлэгчийг дахин үүрэгт ажлаас чөлөөлсөн шийдвэрт эрх бүхий байгууллага (Захиргааны хэргийн шүүх)-д хандаж маргаагүй, хүлээн зөвшөөрсөн гэж дүгнэсэн. Мөн ШШГТХ-ийн 67.3 дахь хэсгийг давж заалдах, хяналтын шатны шүүхээс биелүүлсэн гэж дүгнэсэн ч хуульд заасан “хариуцагч урьд гаргасан шийдвэрээ хүчингүй болгож, тухайн ажилтныг урьдах ажилд нь эгүүлэн тогтоосноор шийдвэр биелэгдсэнд тооцно” гэх нөхцөлийг хэрхэн биелүүлсэн гэдэгт тодорхой дүгнэлт өгөлгүй, ямар учраас биелэгдсэнд тооцож байгаагаа хууль зүйн хувьд баталж, тайлбарлалгүйгээр шийдвэрлэсэн байна. Энэ нь иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийн хууль зүйн үндэслэлийг үгүйсгэсэн тайлбар хийлгүйгээр нэхэмжлэлийг хангаж, анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулж, хэргийг шийдвэрлэсэн гэсэн үг юм.

Мөн давж заалдах, хяналтын шатны шүүхээс шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад шийдвэрт заасан нөхцөлийг биелүүлэхгүй, өөр хэлбэрээр, биелүүлсэн нөхцөлд эрх бүхий байгууллагад гомдол гаргах, дахин захиргааны хэргийн шүүхээр шийдвэрлүүлэх ёстой байсан, маргаагүй учир захиргааны байгууллагын шийдвэрийг хүлээн зөвшөөрсөнд тооцож дүгнэлт гаргасан нь үндэслэлгүй юм.

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй, биелүүлсэн нөхцөлд шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үргэлжлүүлэхгүй, дахин захиргааны хэргийн шүүхэд хандаж шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны явцад гарсан захиргааны акттай маргах ёстой байсан мэтээр тайлбарлаж шийдвэрлэсэн нь захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн заавал биелэгдэх шинжийг үгүйсгэсэн шийдвэр болсон байна.

2.3. НЭХЭМЖЛЭГЧИЙН АЛБАН ТУШААЛ, ЦОЛЫГ БУУРУУЛСАН ШИЙДВЭР ГАРГАЖ, НЭХЭМЖЛЭГЧИЙГ ЦАГ ХУГАЦАА, ЭДИЙН ЗАСГААР ХОХИРООСОН ХЭРЭГ

Маргааны үйл баримт

Нэхэмжлэгч нь ЦЕГ-ын даргын 2013.11.25-ны өдрийн 669 дугаар тушаалын өөрт холбогдох хэсгийг хүчингүй болгуулах, эрхэлж байсан ажилд эргүүлэн томилуулах, ажилгүй байсан хугацааны цалин хөлстэй тэнцэх хэмжээний нөхөн олговор олгуулах, нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын шимтгэл нөхөн төлүүлж, дэвтэрт бичилт хийлгэх шаардлага бүхий нэхэмжлэл гаргасан.¹⁶

Нэхэмжлэгч нь Мөрдөн байцаах газрын Хүнд гэмт хэрэг мөрдөх хэлтсийн чиглэлийн ахлах мөрдөн байцаагчаар ажиллаж байгаад 2013 оны ээлжийн амралтаа 10 сарын 14-ний өдрөөс Мөрдөн байцаах газрын даргаар батлуулан амарсан ч амарч байх хугацаанд нь Чингэлтэй дүүрэг дэх цагдаагийн нэгдүгээр хэлтэст чиглэлийн ахлах мөрдөн байцаагчаар томилж, улмаар дахин ажлаас чөлөөлсөн байна. ЦЕГ-ын дарга нэхэмжлэлийн шаардлагыг эс зөвшөөрч “шилжүүлэн томилсон тушаал нь нэхэмжлэгчийг албан үүргээ гүйцэтгэж байх үед баталгаажсан, албан тушаалын цол, цалингийн зэрэглэлийг бууруулаагүй” гэж маргадаг.

Нэхэмжлэгчийг шилжүүлэн ажиллуулахаар болсон албан тушаалаас чөлөөлсөн нь илт хууль бус болсныг ЦЕГ-ын дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөл тогтоосон хэдий ч анхнаасаа “албан ажлын зайлшгүй шаардлага”-д маргаан бүхий захиргааны акт үндэслэсэн болох нь тогтоогдоогүй, захиргааны акт тухайн зорилгодоо нийцээгүй байна гэж үзээд нэхэмжлэлийг бүхэлд нь хангаж шийдвэрлэжээ.

¹⁶ Захиргааны хэргийн анхан шатны 20 дугаар шүүхийн 2014.07.17-ны өдрийн 336 дугаар шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2014.09.25-ны өдрийн 388 дугаар магадлал, УДШ-ийн 2014.11.17-ны өдрийн 265 дугаар тогтоолоор тус тус шийдвэрлэсэн.

Иргэний хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах болсон үндэслэл

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг биелүүлэхээр НШГА-д хандаж 124 дүгээр тойргийн шийдвэр гүйцэтгэгч Ч.Э шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж 2015.06.15-ны өдрийн “Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болсон тухай тогтоолыг” гаргаж шүүхийн шийдвэр биелэгдсэнд тооцсон. Үүнийг эс зөвшөөрч иргэний хэргийн шүүхэд гомдол гаргаж шийдвэрлүүлсэн.¹⁷

Маргах болсон шалтгаан нь нэхэмжлэгч дэд хурандаа цолтой байсан ч хошууч цолтой албан тушаалд эгүүлэн томилох шийдвэр гаргасан явдал юм. Шүүхээс захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн цалин, хөлстэй холбогдох хэсгийг гүйцэтгэсэн ч эгүүлэн томилохдоо шүүхийн шийдвэрт заасан албан тушаалд томилоогүй буюу шийдвэрийг биелүүлээгүй тул нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэх үндэслэлтэй гэж дүгнэсэн. Мөн нэхэмжлэгч нь ЦЕГ-т холбогдуулан нэхэмжлэл гаргаж 2014.07.17-ны өдрөөс 2016.02.17-ны өдрийг хүртэлх хугацааны цалин хөлс 11,972,204 төгрөгийг гаргуулахаар шийдвэрлэсэн байна.¹⁸

Шүүхийн шийдвэрлэсэн байдал

Анхан шатны шүүх¹⁹

Нэхэмжлэгч нь 2017.05.30-ны өдөр НШГА-д хандаж гомдол гаргасан ба ЦЕГ нэхэмжлэгчийг ажилд томилохдоо ажилтны урьд ажиллаж байсан ажлын байр, албан тушаал нь цомхотгогдсон бол ажил олгогч ажилтантай тохиролцсоны

¹⁷ Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2015.11.17-ны өдрийн 7809 дугаар шийдвэр.

¹⁸ Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016.05.05-ны өдрийн 4034 дугаар шийдвэр.

¹⁹ Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018.03.30-ны өдрийн 628 дугаар шийдвэр.

үндсэн дээр урьдах ажил, албан тушаалтай дүйцэхүйц өөр ажил, албан тушаалд ажиллуулах хуульд заасан үүргээ биелүүлэхгүйгээр шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгосон нь хууль зөрчсөн тул хүчингүйд тооцсон. ЦЕГ-ын нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.

Давж заалдах шатны шүүх²⁰

Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийн тогтоох хэсгийн хууль зүйн үндэслэлийг өөрчилж, шийдвэрийн бусад хэсгийг хэвээр үлдээсэн.

Хяналтын шатны шүүх²¹

ЦЕГ-ын гомдлыг хэрэгсэхгүй болгож, анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэсэн.

Дүн шинжилгээ

2002 оны ШШГТХ 67.6, 2017 оны ШШГТХ-ийн 103.5-д урьд ажиллаж байсан ажлын байр, албан тушаал нь цомхотгогдсон бол ажил олгогч ажилтантай тохиролцсоны үндсэн дээр урьд эрхэлж байсан ажил, албан тушаалтай дүйцэх өөр ажил, албан тушаалд ажиллуулах үүрэгтэй гэж тодорхой зохицуулсан байдаг.

Нэхэмжлэгч нь 2014 онд захиргааны хэргийн гурван шатны шүүхээр хэргээ шийдвэрлүүлсэн ч шүүхийн шийдвэрийг гүйцэтгүүлэхийн тулд дахин иргэний гурван өөр төрлийн маргаанд (цалин хөлсөө нэмж гаргуулах, ШГА-г дуусгавар болгох тогтоолыг хүчингүй болгох, ЦЕГ-ын шийдвэр гүйцэтгэгдсэн тооцуулах нэхэмжлэлтэй иргэний хэрэг) нэхэмжлэгч, гуравдагч этгээдээр оролцсоны эцэст дөрвөн жилийн дараа шүүхийн шийдвэр биелэгдсэн байна.

²⁰ Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018.06.08-ны өдрийн 1347 дугаар магадлал.

²¹ УДШ-ийн хяналтын шатны 2018.11.01-ний өдрийн 1541 дүгээр тогтоол.

ЦЕГ-аас нэхэмжлэгчийг дүйцэхүйц ажил, албан тушаалд томилох ямар ч боломжгүй, “цагдаагийн хошууч” цол олгох боломжтой гэж дөрвөн жилийн хугацаанд мэдэгдэж, шүүхэд нэхэмжлэл гаргасан ч 2018 онд ЦЕГ-аас нэхэмжлэгчийг “цагдаагийн дэд хурандаа” цолтойгоор урьд эрхэлж байсан ажил, албан тушаалтай дүйцэхүйц албан тушаалд томилсноор шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа дуусгавар болсон юм.

2.4 НЭХЭМЖЛЭГЧИЙН АЛБАН ТУШААЛЫГ БУУРУУЛСАН ШИЙДВЭР ГАРГАЖ, НЭХЭМЖЛЭГЧИЙГ ЦАГ ХУГАЦАА, ЭДИЙН ЗАСГААР ХОХИРООСОН ХЭРЭГ

Маргааны үйл баримт

БОАЖЯ-ны төрийн нарийн бичгийн даргын 2010.09.29-ний өдрийн тушаалаар нэхэмжлэгчийг БОАЖЯ-ны захиргааны удирдлагын газрын даргын албан тушаалаас чөлөөлсөн. Үүнийг эс зөвшөөрч захиргааны хэргийн шүүхэд хандсан бөгөөд захиргааны хэргийн шүүхээс нэхэмжлэгчийг тус яамны захиргааны удирдлагын газрын даргын албан тушаалд эгүүлэн тогтоож шийдвэрлэсэн.²² Шүүхийн шийдвэрийг хариуцагч сайн дураар биелүүлээгүй тул албадан гүйцэтгүүлэх болсон. НШГА нь 2011.08.15-ны өдрийн 1/7207 тоот албан бичгээр шүүхийн шийдвэр биелүүлэхийг мэдэгдсэн.

Иргэний хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах болсон үндэслэл

Хариуцагч БОАЖЯ-ны төрийн нарийн бичгийн дарга тушаал гаргаж, олговрыг дансанд шилжүүлж, мэргэжилтнээр ажилла-

²² Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүхэд хандаж 2011-01-28-ны өдрийн 42 тоот шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2011.03.23-ны өдрийн 110 дугаар магадлал, УДШ-ийн 2011.05.30-ны өдрийн 120 дугаар тогтоолоор тус тус эцэслэн шийдвэрлэсэн.

хыг санал болгосон. Харин нэхэмжлэгч мэргэжилтэн хийхийг зөвшөөрөөгүй. Гэтэл шийдвэр гүйцэтгэх байгууллагаас ШГА-г дуусгавар болгосон тул үүнийг эс зөвшөөрч иргэний шүүхэд хандсан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага “БОАЖЯ-ны төрийн нарийн бичгийн даргад албан тоот явуулсан. Төрийн нарийн бичгийн дарга 2011.08.23-ны өдрийн тушаалаар нэхэмжлэгчийг ажилд нь томилж, олговрыг олгосон байсан. Нэхэмжлэгчийг мэргэжилтнээр томилсон тушаал байсан. ШШГТХ-ийн 67-р зүйлийн 67.3-т зааснаар шийдвэр гүйцэтгэх ажиллагаа дуусгавар болсон” гэх тайлбарыг өгсөн байдаг.

Шүүхийн шийдвэрлэсэн байдал

Анхан шатны шүүх²³

Нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааг НШГА явуулсан байна. БОАЖЯ-ны төрийн нарийн бичгийн дарга 2011.08.23-ны өдрийн тушаалаар нэхэмжлэгчийг ажилд нь томилж, 3,102,254 төгрөгийн олговрыг олгохоор заасан. Гэсэн хэдий ч зөвхөн мөнгийг шилжүүлж, нэхэмжлэгчийг уг ажилд ажиллуулаагүй, мэргэжилтэн хий гэж шаардсан болох нь талуудын тайлбараар тогтоогдож байна. Нэхэмжлэгч шийдвэрийг бодитой гүйцэтгээгүй тухай АШГ-д гомдол гаргасан ч шийдвэр гүйцэтгэх ажиллагаа дуусгавар болсон гэх үндэслэлээр гомдлыг хангахгүй орхижээ.

БОАЖЯ-ны төрийн нарийн бичгийн дарга нэхэмжлэгчийг урьд ажилд нь томилсон тушаал гаргасан хэдий ч уг ажилд ажиллуулаагүй, мэргэжилтнээр ажиллахыг шаардсан зэргийг мэдсээр байж НШГА, шийдвэр гүйцэтгэгч тодорхой ажиллагаа хийлгүй тушаалыг үндэслэн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа

²³ Сүхбаатар дүүргийн шүүхийн Иргэний хэргийн шүүх хуралдаанаас 2011.12.20-ны өдрийн 13 дугаар шийдвэр.

дуусгавар болсон гэж үзсэн нь буруу юм. Иймд нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэсэн.

Дүн шинжилгээ

БОАЖЯ-ны төрийн нарийн бичгийн дарга тушаал гаргаж, шүүхийн шийдвэрийг биелүүлсэн мэт боловч бодит байдал дээр захиргааны хэргийн шүүхээс тогтоосон БОАЖЯ-ны Захиргааны удирдлагын газрын даргын албан тушаалд бус мэргэжилтнээр ажиллахыг хүссэн нь шийдвэрийг бодитоор биелүүлсэн гэж үзэхгүй гэж шүүх үзжээ.

Шийдвэр гүйцэтгэлийн баримттай танилцахад нэхэмжлэгч нь 2018.02.26-ны өдөр НШГА-ны шийдвэр гүйцэтгэгчид хандаж шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгох тухай хүсэлт гаргасан. Үүндээ “2017.12.11-ний өдөр 3,102,254 төгрөгийг гаргаж өгсөн, ажилд томилох саналаас татгалзаж буй тул шийдвэр гүйцэтгэх баримт бичгийг дуусгавар болгож өгнө үү, гомдол гаргахгүй” гэх хүсэлтийг үндэслэн АШГ шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгосон байна.

Захиргааны хэргийн шүүхийн 2011 онд гаргасан шийдвэрийг 2018 оныг хүртэл хугацаанд гүйцэтгэж чадаагүй. Нэхэмжлэгч найман жилийн хугацаанд захиргааны хэргийн шүүхийн шийдвэр биелээгүй тул арга мухардаж, өөрөө хүсэлт гаргаж, шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг дуусгавар болгожээ.

2.5. НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ТАЛБАЙД ХУУЛЬ БУСААР БАРИЛГА БАРЬЖ, НИЙТИЙН ЭРХ АШИГТ ХАЛДСАН ХЭРЭГ

Маргааны үйл баримт

НЗД-ын 2002.12.27-ны өдрийн захирамжаар иргэн Р.Б-д 490 мкв газрыг контор, зочид буудлын зориулалтаар олгосныг 2004.10.04-ний өдрийн газар ашиглуулах эрхийг баталгаажуулах тухай захирамжаар өөрчилж, иргэн Х.А, Л.Ч нарт Хан-Уул дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 1320 мкв газар эзэмших эрхийг баталгаажуулж, гэрчилгээ олгосон байна. Нэхэмжлэгч нь байрны урд талын нийтийн эзэмшлийн зам талбай байх ёстой газарт НЗД захирамжаар бусдад газар эзэмшүүлэн, улмаар 12 давхар болон хоёр давхар барилга барьснаар энэхүү маргаан эхэлсэн гэж тайлбарладаг. НЗД-ын захирамжийн иргэн Х.А, Л.Ч нарт холбогдох хэсэг нь Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийг зөрчсөн гэдгийг Захиргааны хэргийн шүүхээс тогтоосон.²⁴

Нэхэмжлэгч нь НЗД газар чөлөөлөх мэдэгдэл гаргахгүй байгаа явдал нь хууль бус болохыг тогтоож, шаардлагатай захиргааны акт гаргахыг даалгаж өгөхийг хүссэн шаардлага гаргасан. НЗД нь гаргасан шийдвэрийнхээ биелэлтийг хангах талаар хяналт тавих үүргээ хэрэгжүүлээгүй газар чөлөөлүүлэх мэдэгдэл өгөлгүй Газрын тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.3-д “Зохих зөвшөөрөлгүйгээр газар дээр барилга, байгууламж барьсан, эсхүл бусад хэлбэрээр түүнийг дур мэдэн эзэмшсэн бол аймаг, нийслэлийн Засаг дарга уг газрыг чөлөөлөх тухай хугацаатай мэдэгдэл өгнө” гэж заасныг зөрчсөн болох нь тогтоогдож буй тул шүүхээс нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэжээ.²⁵

²⁴ Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2009.01.23-ны өдрийн 49 дүгээр шийдвэр, УДШ-ийн захиргааны хэргийн давж заалдах шатны 2009 оны 105 дугаар магадлал, УДШ-ийн хяналтын шатны 115 дугаар тогтоол.

²⁵ Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2010.04.16-ны өдрийн 180

Иргэний хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах болсон үндэслэл

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж газар чөлөөлөхөөр шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр бүрэн биелэгдээгүй, өөрөөр хэлбэл хоёр давхар барилгын суурь үлдсэн, 12 давхар барилга бүтнээрээ байсаар байхад НШГА-ны шийдвэр гүйцэтгэгчийн 2015.04.21-ний өдрийн ШГА-г дуусгавар болгосон тухай тогтоол гаргасныг хүлээн зөвшөөрөөгүй. НШГА-ны ШГ-ийн тогтоолд урьдчилан шийдвэрлэх журмын дагуу ахлах шийдвэр гүйцэтгэгчид гомдол гаргасан боловч хүлээн авч, хүчингүй болгоогүй учир иргэний хэргийн шүүхэд хандсан байна.

Шүүхийн шийдвэрлэсэн байдал

Анхан шатны шүүх²⁶

Нэхэмжлэгч талын зүгээс маргаан бүхий газар дээр баригдсан хоёр давхар барилгын суурь, 12 давхар барилга бүтнээрээ байгаа учир шийдвэр бүрэн биелээгүй гэж маргадаг. Хариуцагч НШГА болон гуравдагч этгээд НЗД-ын итгэмжлэгдсэн төлөөлөгч, АП ХХК нарын зүгээс УДШ-ийн 2010.06.21-ний өдрийн 173 дугаар тогтоол, түүнийг үндэслэж НЗД-ын 2011.01.17-ны өдрийн 33 дугаар захирамж гарсан бөгөөд Хан-Уул дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах 14, 15 дугаар байрны дунд байрлах зочид буудлын барилгын С блокийг албадан буулгаж, газар чөлөөлүүлэх шийдвэр гаргасан. АП ХХК нь 2015.04.15-ны өдөр С блокийг буулгаж газар чөлөөлсөн учир шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг дуусгавар болгох нь үндэслэлтэй гэж маргадаг. Анхан шатны шүүхээс нэхэмжлэлийг хангаж, НШГА-ны АШГ-ийн тогтоолыг хүчингүй болгож шийдвэрлэсэн.

дугаар шийдвэр, УДШ-ийн (захиргааны танхим) 2010.06.21-ний өдрийн 173 дугаар тогтоолоор тус тус шийдвэрлэсэн.

²⁶ Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 101/ШШ2016/03595 дугаар шийдвэр.

Давж заалдах шатны шүүх²⁷

Нэхэмжлэгч нь хариуцагч НШГА-д холбогдуулан шийдвэр гүйцэтгэх ажиллагаа дуусгавар болсон тухай 2015.04.21-ний өдрийн тогтоолыг хүчингүй болгуулахыг шаардсаныг хариуцагч “шүүхийн шийдвэрийг бүрэн биелүүлсэн АП ХХК гэрээний дагуу буулгалтын ажлыг хийж дуусгасан” гэж маргасан байна.

Нэхэмжлэгч нэхэмжлэлийн шаардлагын үндэслэлээ Нийслэлийн Захиргааны хэргийн шүүхийн 2010.04.16-ны өдрийн 180 дугаар шийдвэрийг бүрэн биелүүлээгүй, хоёр давхар барилгын суурь, 12 давхар барилга бүтнээрээ байгаа гэж тайлбарласан.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч татгалзлаа нотлох үүргээ хэрэгжүүлэхээр ИХШХШТХ-ийн 25 дугаар зүйлийн 25.2.2, 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсэгт зааснаар НЗД-ын 2011.01.17-ны өдрийн 33 тоот захирамж, Өмч харилцааны газрын 2014.01.20-ны өдрийн 5-275 тоот албан бичиг, 2014.04.02-ны өдрийн 8/1952 тоот албан бичгийн хариу, 2014.02.12-ны өдрийн хамтарсан хурлын тэмдэглэл зэргийг нотлох баримтаар гаргуулах хүсэлт гаргасныг шүүх ... дугаар захирамжаар хангаж шийдвэрлэсэн байна.

Гэвч уг захирамжийн биелэлт хангагдаагүй байхад хэргийг шүүх хуралдаанаар эцэслэн шийдвэрлэсэн нь ИХШХШТХ-ийн 168 дугаар зүйлийн 168.1.7-д заасан нотлох баримтыг дутуу бүрдүүлж хэргийг шийдвэрлэсэн зөрчил гаргасан гэж үзээд анхан шатны шүүх рүү хэргийг буцаах шийдвэр гаргасан.

²⁷ Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2016.06.20-ний өдрийн 1192 дугаар магадлал.

*Анхан шатны шүүх*²⁸

Нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзаж хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.

Дүн шинжилгээ

НЗД-ын 2009.03.01-ний өдрийн 80 дугаар захирамжаар газрыг бүхэлд нь хүчингүй болгосон бөгөөд тухайн газрыг чөлөөлөх хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхийг даалгаж шийдвэрлэсэн. Гэвч шүүхийн шийдвэр хэрэгжих явцад НЗД-аас газрын захирамжийн тодорхой хэсэгт өөрчлөлт оруулж, газрын хэмжээг өөрчилсөн гэдэг асуудал хөндөгддөг. Шүүхийн шийдвэр гарах үед баригдсан байсан зочид буудлын 12 давхар барилга, хоёр давхар С блокуудыг яаж нураах, газрыг хэрхэн чөлөөлөх талаар тодорхой дурдаагүй, зөвхөн Газрын тухай хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхийг даалгасан. Энэхүү маргаан нь тодорхойгүй байдлаар нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсанаар дуусгавар болсон бөгөөд НШГА-ны ШГ-ийн тогтоолын хууль зүйн үндэслэлд дүгнэлт хийсэн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр байхгүй.

Шийдвэр гүйцэтгэлийн баримт, шүүхийн шийдвэрүүдийг судалж үзэхэд Монгол Улсад баригдаж дууссан барилга байгууламжтай холбогдох шүүхийн шийдвэрийг хэрхэн гүйцэтгэх, биелүүлэх талаар хууль эрх зүйн болон бодитоор гүйцэтгэх материаллаг нөөц бололцоо байхгүй нь ажиглагддаг. Тухайлбал, шүүхээс НЗД-д даалгаж шийдвэрлэсэн, мөн шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэж буй атал тухайн барилгыг барьсан АП ХХК-тай гэрээ байгуулж барилгыг нураах үүргийг шилжүүлсэн. Энэ нь Монгол Улсад барилга, байгууламж нурааж чөлөөлсөн, захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд

²⁸ Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүгчийн 2016.08.30-ны өдрийн 579 дугаар захирамж.

бусдаар төлөөлүүлэн гүйцэтгэх боломжтой цөөхөн тохиолдлын нэгд тооцогддог.

Барилга нураах болон газартай холбоотой шүүхийн шийдвэрийг биелүүлэхэд шийдвэр гүйцэтгэгч нарт албадлагын зохицуулалт байхгүй тул мэдэгдэл хүргэх, газартай холбоо бүхий өмчлөх, эзэмших эрхэд нь хаалт хийх зэрэг байдлаар л ажлаа явуулдаг ажээ.²⁹

²⁹ Д.Сандаг, ШШГЕГ-ын албан сургалт, дадлагын хэлтсийн мэргэжилтэн, дэслэгч “Газартай холбоотой шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт” Газартай холбоотой хүний эрхийн асуудал онол, практикийн бага хурлын илтгэлүүдийн эмхэтгэл, УБ., 2015, 48 дахь тал, https://www.amnesty.mn/~amnestym/images/2020/05/AIM_online_book_final.pdf

ГУРАВ. ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙГ БИЕЛҮҮЛЭЭГҮЙ ЭТГЭЭДЭД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

3.1 ОДООГИЙН ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ

Зөрчлийн тухай хууль

ЗтХ-ийн 15.27-д шүүхийн шийдвэрийг үл биелүүлэх тухай зөрчлийг хуульчилсан. Гэвч тус зүйлд захиргааны байгууллага, албан тушаалтан шүүхийн шийдвэрийг үл биелүүлсэн тохиолдолд ямар хариуцлага ногдуулах талаар тодорхой зохицуулалт тусгагдаагүй. Харин ЗтХ-ийн 15.2-д Төрийн албан тушаалтны шийдвэрийг үл биелүүлэх, үйл ажиллагаанд саад учруулах, тэр дундаа хууль сахиулах чиг үүрэг хэрэгжүүлж байгаа төрийн албан хаагчийн хувьд дараах зохицуулалт бий. Үүнд:

- 2.1. төрийн албан хаагчаас тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй, эсхүл биелүүлэхгүй байхыг уриалсан;
- 2.2. төрийн албан хаагчийн үйл ажиллагаанд нь саад учруулсан;
- 2.3. төрийн албан хаагчийг хүч хэрэглэхгүйгээр эсэргүүцсэн, эсхүл доромжилсон бол хүнийг хоёр зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно³⁰.

³⁰ Тайлбар: Энэ хуульд заасан “хууль сахиулах чиг үүрэг” гэж цагдаа, тагнуул, гааль,

Хэрэв шүүхийн шийдвэр гүйцэтгэгчийн тавьсан шаардлагыг захиргааны байгууллага, түүний холбогдох албан тушаалтан биелүүлээгүй, шийдвэр гүйцэтгэгчийн үйл ажиллагаанд саад учруулсан, хүч хэрэглэхгүйгээр эсэргүүцсэн, эсхүл доромжилсон нөхцөлд тухайн зөрчилд холбогдуулан шалгаж, хариуцлага тооцох боломжтой.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль

ШШГТХ-ийн 132 дугаар зүйлд захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх ажиллагааны талаар 132.1-т “Хариуцагч шүүхийн мэдэгдэлд заасан хугацаанд шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй бол ахлах шийдвэр гүйцэтгэгч энэ тухай олон нийтэд мэдээлж, шаардлагатай бол биелүүлэх хугацааг 14 хүртэл хоногоор сунгаж болно”, мөн хуулийн 132.2-т “Шийдвэр гүйцэтгэгч шүүхийн мэдэгдэлд заасан хугацаа, эсхүл энэ хуулийн 132.1-д заасны дагуу нэмэлт хугацаа тогтоосон бол тухайн хугацаа дуусмагц шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй захиргааны байгууллага, албан тушаалтны дээд шатны байгууллага, албан тушаалтанд шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй албан тушаалтанд Төрийн албаны тухай хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулах, шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангах арга хэмжээ авахыг даалгасан мэдэгдэл хүргүүлнэ” гэж заасан.

Эрүүгийн хууль

ЭХ-ийн 21.7 дугаар зүйлд шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулах, зайлсхийх гэмт хэргийг зохицуулсан байна. Үүнд 1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулах зорилгоор хөрөнгийн мэдүүлгээ зориуд буруу гаргасан, эд хөрөнгөө нуун дарагдуулсан, бусдад шилжүүлсэн,

шүүхийн шийдвэр гүйцэтгэх, төрийн тусгай хамгаалалтын албаны болон авлигатай тэмцэх, хил хамгаалах, гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн байгууллагын алба хаагчийн хуульд заасан чиг үүргийг ойлгоно.

үрэгдүүлсэн, оршин суух хаягаа өөрчилсөн, дүр эсгэн биелүүлсэн, битүүмжилсэн, барьцаалсан, хураан авсан хөрөнгийг дур мэдэн захиран зарцуулсан, дүр үзүүлсэн гэрээ байгуулсан бол хоёр мянга долоон зуун нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ гэж заасан.

ЭХ-ийн энэхүү зохицуулалт нь захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хамаарахгүй. Учир нь тус зүйлд тусгагдсан нөхцөлүүд нь ихэвчлэн иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа буюу төлбөр гаргуулах харилцаанд хамаарах юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулсан шийдвэрийг биелүүлэхгүй санаатай зайлсхийсэн байгууллага, албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагын хэмжээг илүү үр нөлөөтэй болгох, мэдэгдэхүйц хэмжээгээр нэмэгдүүлэх, шаардлагатай. Захиргааны хэргийн хувьд төлөөлүүлэн гүйцэтгэж болохгүй шүүхийн шийдвэрийг “сүрдүүлгийн дор”³¹ буюу захиргааны журмаар ногдуулах торгуулийн хэмжээг одоогийнхоос хэд дахин нэмэгдүүлэх, мөн хариуцлага хүлээлгэдэг, хариуцлагаас чөлөөлөх зохицуулалтыг хүчингүй болгох шаардлагатай.

³¹ А.Эрдэнэцогт, Монгол Улсын Захиргааны процессын эрх зүй, УБ., 2006, 312 дахь тал.

3.2 ОДООГИЙН ХУУЛЬ ЗҮЙН ПРАКТИК

НШШГГ-аас авсан мэдээгээр 2020 онд нийт 265 зөрчлийн хэрэг үүсгэн шалгаснаас төрийн байгууллага, албан тушаалтан хариуцагчаар татагдсан нийт найман хэрэг байна. Дараах байгууллагууд хариуцагчаар татагдсан байна. Үүнд:

- Гэр бүл, хүүхэд, залуучуудын газар;
- Нийгмийн даатгалын ерөнхий газар;
- Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан;
- Сүхбаатар дүүргийн тамгын газар;
- Нийслэлийн эрүүл мэндийн газар;
- Төмөр зам гэсэн байгууллагууд багтжээ.

2021 онд 86 зөрчлийн хэрэг үүсгэн шалгаж байгаагаас төрийн байгууллага, албан тушаалтантай холбогдох зөрчил байхгүй гэжээ. ЗтХ-ийн 2.3-т Шийтгэлээс чөлөөлөх үндэслэлийн дөрөвт “Төрийн албан хаагчийн хуулиар хүлээсэн албаны чиг үүргээ хэрэгжүүлсэн үйлдэл, эс үйлдэхүй нь энэ хуульд заасан зөрчлийн шинжтэй бол түүнд холбогдох хууль тогтоомжид заасан сахилгын шийтгэл хүлээлгэнэ. Төрийн албан хаагчийн албаны чиг үүргээ хэрэгжүүлсэн үйлдэл, эс үйлдэхүйтэй холбоогүй зөрчилд энэ хуульд заасан нийтлэг журмаар шийтгэл оногдуулж, албадлагын арга хэмжээ хэрэглэнэ” хэмээн зохицуулсан.

Ингэснээр төрийн байгууллага, албан тушаалтан захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг биелүүлэх талаар шийдвэр гүйцэтгэгчийн шаардлага, мэдэгдлийг биелүүлээгүй тохиолдолд ЗтХ-д заасан зөрчил үйлдсэн эсэхийг тогтоох боловч, хариуцлагаас чөлөөлөгддөг. Өөрөөр хэлбэл, шүүхийн шийдвэр гүйцэтгэгч нь захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг биелүүлэхийн

тулд төрийн байгууллага, албан тушаалтанд зөрчлийн хэрэг үүсгэж, “зөрчлийг тогтоодог” ч ЗтХ-ийн 2.3.4-т заасны дагуу төрийн албан хаагчийн хуулиар хүлээсэн албаны чиг үүргээ хэрэгжүүлсэн үйлдэл, эс үйлдэхүй нь энэ хуульд заасан зөрчлийн шинжтэй бол зөрчлийн шийтгэлээс чөлөөлж, төрийн албаны сахилгын шийтгэл ногдуулах саналыг дээд шатны байгууллага, албан тушаалтанд хүргүүлэхээс өөр арга хэмжээ авч хариуцлага хүлээлгэж чаддаггүй.

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны дагуу ЭХ-аар эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн тухай тодорхой мэдээлэл байхгүй байна. Цагдаагийн байгууллагад эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр шилжүүлсэн хэргийг эрүүгийн гэмт хэргийн бүрэлдэхүүн байхгүй гэдэг шалтгаанаар хэрэгсэхгүй болгож, эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалздаг талаар практикт ажилладаг шийдвэр гүйцэтгэгчид тодорхой дурдсан байдаг.³²

ШШГтХ-ийн 132 дугаар зүйлд заасны дагуу олон нийтэд захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй байгаа албан тушаалтнуудын талаар мэдээлэх, дээд шатны байгууллага, албан тушаалтанд сахилгын хариуцлага тооцуулах мэдэгдэл хүргэх арга хэмжээ авах боломжтой. Гэтэл ШШГтХ-ийн дагуу хэдэн албан тушаалтны талаар олон нийтэд мэдээлсэн, хэдэн албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулсан, үүний үр дүн болон захиргааны хэргийн шүүхийн шийдвэр биелэгдсэн талаар тодорхой мэдээлэл байхгүй байна.

Дээр дурдсаны дагуу хуулийн оновчгүй, тодорхойгүй, хангалтгүй зохицуулалтын улмаас захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн биелэлт хангалтгүй байгаагаас гадна шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо, эрх зүйн

³² Л.Өлзийжаргал, Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн хэрэгжилт, тулгамдсан асуудал, <http://www.niislel.cd.gov.mn/content/9100.shtml?sel=257>

байдал нь шийдвэр гүйцэтгэгч ажил үүргээ үр нөлөөтэй гүйцэтгэхэд саад болох тохиолдол байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын даргыг Хууль зүйн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүний санал болгосноор томилж, чөлөөлдөг.³³ Засгийн газар буюу гүйцэтгэх эрх мэдлийн харьяа агентлаг (Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар) нь шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх чиг үүргийг хэрэгжүүлж буй нь захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэл хангалтгүй байхад нөлөөлж байна гэж судлаачид үздэг.³⁴ Практикт ажиллаж буй шийдвэр гүйцэтгэгч нараас захиргааны шүүхийн шийдвэрийг биелүүлэхэд тулгамдаж буй хамгийн хүндрэлтэй асуудлыг тодруулахад “Захиргааны байгууллага, албан тушаалтан нь шийдвэр гүйцэтгэгчийн шаардлагыг тоодоггүй, үл хэрэгсдэг. Захиргааны байгууллага албан тушаалтнаас дарамт шахалт ирдэг”, “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцооноос шалтгаалдаг” гэж хариулсан байна. Өөрөөр хэлбэл, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, шийдвэр гүйцэтгэгч нь шийдвэр биелүүлэгч төрийн захиргааны байгууллага, албан тушаалтнаас хараат байдаг учир шүүхийн шийдвэр биелүүлэх талаар шаардлага тавьсан ч биелүүлдэггүй. ШШГЕГ нь ХЗДХЯ-ны харьяа агентлаг, НШГА нь НЗД-ын хэрэгжүүлэгч агентлаг байдаг учир дээд шатны байгууллагад шүүхийн шийдвэр биелүүлэх шаардлага тавихад хүндрэлтэй байдаг” талаар дурдсан байна.³⁵ Шүүхийн шийдвэрийг биелүүлдэггүй захиргааны байгууллага, албан тушаалтнуудыг жагсаахад нийслэл, аймаг, сум, дүүргийн Засаг дарга нар эхний байранд жагсдаг байна.³⁶

³³ ШШГТХ-ийн 261.2 дахь зүйл.

³⁴ Э.Мөнхдаваа, МУИС-ийн ХЗС-ийн Нийтийн эрх зүйн тэнхимийн багш, Захиргааны шүүхийн шийдвэр гүйцэтгэлд анхаарах асуудал, Шүүх эрх мэдэл, УБ., 2017/03, 60 дахь тал.

³⁵ Л.Өлзийжаргал, Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн хэрэгжилт, тулгамдсан асуудал, <http://www.niislel.cd.gov.mn/content/9100.shtml?sel=257>

³⁶ Т.Азжаргал, Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэл, тулгамдсан асуудал, УБ., 2019, <https://legaldata.mn/buteel/pdf?id=1131>

3.3 ӨМНӨХ ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ

1992 оны Захиргааны хариуцлагын тухай хууль

1992-2017 оныг хүртэл хугацаанд үйлчилж байсан ЗХтХ-ийн 30⁴ дүгээр зүйлд шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны ажилтны хууль ёсны шаардлагыг үл биелүүлэх, заналхийлсэн бол дараах хариуцлагыг хүлээлгэхээр заасан байна. Үүнд:

1. Шийдвэр гүйцэтгэлийн албанд дуудагдсан этгээд хүрэлцэн ирэхээс зориуд зайлсхийсэн, хүрэлцэн ирэхэд нь саад учруулсан бол 200-5,000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.
2. Албан үүргээ гүйцэтгэхэд нь санаатайгаар саад учруулсан, эсэргүүцсэн, албан үүрэгтэй нь холбогдуулан доромжилсон, гүтгэсэн заналхийлсэн, хүч хэрэглэсэн, эд хөрөнгийн тухай мэдүүлэг өгөхөөс татгалзсан, зайлсхийсэн, уг мэдүүлгийг тогтоосон хугацаанд өгөөгүй, худал мэдүүлсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол 5,000-25,000 төгрөгөөр торгох, эсхүл 7-14 хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл ногдуулна.
3. Шийдвэр биелүүлэхээс санаатайгаар зайлсхийсэн, хуурамч гэрээ хийж, эд хөрөнгөө бусдад шилжүүлсэн, нуусан, битүүмжилсэн эд хөрөнгийг санаатайгаар үрэгдүүлсэн бол 5,000-10,000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.
4. Төлбөр төлөгчийн цалин орлогоос суутгал хийгээгүй, дутуу суутгасан, суутгасан мөнгийг хуульд заасан хугацаанд олгоогүй буюу шилжүүлээгүй, төлбөр, тэтгэлэг төлөгчийг ажлаас халагдсаныг мэдэгдээгүй бол 1,000-15,000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.

ЗХтХ-ийн хариуцлага үр нөлөө багатай, зохицуулалт хангалтгүй зэрэг үндэслэлээр тус хуулийг хүчингүй болгож,

ЗтХ-ийг баталсан. Гэвч шүүхийн шийдвэрийг санаатайгаар биелүүлээгүй этгээдэд хүлээлгэх хариуцлагын зохицуулалт нь одоогийн ЗтХ-тай харьцуулахад илүү ойлгомжтой, тодорхой байсан нь харагдаж байна. Одоогийн ЗтХ-ийн дагуу шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй байгаа албан тушаалтанд арга хэмжээ авхуулахаар дүүргийн шүүхэд хандахад “зөрчил гаргасан хүнээ авчир” гэдэг шаардлагыг тавьдгаас шийдвэр гүйцэтгэгч нар захиргааны арга хэмжээ авхуулж чаддаггүй байна.³⁷

2002 оны Эрүүгийн хууль

ЭХ-ийн 258 дугаар зүйлийн 258.1-д “Хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийтгэх тогтоол, шийдвэр, магадлал, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжийг санаатай биелүүлээгүй, эсхүл зориуд саад учруулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, нэг зуугаас хоёр зуун тавин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ” гэж заасан бөгөөд энэ зүйлд заасан гэмт хэрэгт сэжигтнээр тооцогдсон, яллагдагчаар татагдсан, ял шийтгэгдсэн этгээд шүүхийн шийдвэрийг биелүүлсэн бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө гэсэн тайлбартай байсан. Өөрөөр хэлбэл, одоогийн ЭХ-ийн 21.7-оос илүү өргөн хүрээтэй, хүчин төгөлдөр бүх шүүхийн шийдвэрийг санаатай биелүүлээгүй, биелүүлэхэд зориуд саад учруулсан үйлдлийг гэмт хэрэгт тооцдог байв.

³⁷ Д.Сандаг, ШШГЕГ-ын албан сургалт, дадлагын хэлтсийн мэргэжилтэн, дэслэгч “Газартай холбоотой шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт” Газартай холбоотой хүний эрхийн асуудал онол, практикийн бага хурлын илтгэлүүдийн эмхэтгэл, УБ., 2015, 48 дахь тал, https://www.amnesty.mn/~amnestym/images/2020/05/AIM_online_book_final.pdf

ДӨРӨВ. ХАРЬЦУУЛСАН ЭРХ ЗҮЙН СУДАЛГАА

4.1. ЯПОН УЛСЫН ЗОХИЦУУЛАЛТ

Харьцуулсан эрх зүйн судалгааны хүрээнд холимог эрх зүйн бүлд хамаарах, эрх зүй өндөр хөгжсөн, Ази тивийн томоохон төлөөлөл болох Япон Улсыг сонгож, тус улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо, эрх зүйн зохицуулалт, холбогдох шүүхийн шийдвэр, онолын тайлбар зэргийг судалж, танилцуулах нь хөгжиж буй Монгол Улсын хууль тогтоомжийг шинэчлэх, сайжруулах ажилд бага ч атугай тус дөхөм үзүүлнэ гэж үзлээ.

Дараах хэсэгт тус улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбогдох хууль тогтоомж, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо, захиргааны хэргийг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг гүйцэтгэхтэй холбоотой онцлог зохицуулалт зэргийг танилцуулна. Үүний дараа захиргааны хэргийг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг гүйцэтгэхэд үүссэн бөгөөд одоог хүртэл олон жилийн туршид үргэлжилж буй нэгэн маргааны талаар товч танилцуулж, уг маргааныг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг гүйцэтгэхэд авсан хууль зүйн арга хэмжээ, түүнтэй холбоотой гарсан онолын тайлбар зэргийг авч үзнэ.

4.2 ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ ХУУЛЬ ТОГТООМЖ

Тус улс нь Монгол Улстай адил захиргааны хэргийн дагнасан шүүхгүй бөгөөд иргэний хэргийн шүүх нь иргэн болон захиргааны хэргийг хянан шийдвэрлэдэг. Уг шүүхээс гаргасан шийдвэрийг хэрхэн гүйцэтгэх тухай асуудлыг Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар (ИХШШГтХ) зохицуулдаг. Уг хуулиар 1. Шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх, 2. Барьцаа хөрөнгийг дуудлага худалдаагаар худалдах, 3. Иргэний хууль, Арилжааны хууль болон бусад хуульд зааснаар эд хөрөнгийн үнэлгээг тогтоох зорилготой дуудлага худалдаа (хэлбэр төдий дуудлага худалдаа гэж нэрлэдэг), 4. Үүрэг гүйцэтгэгчийн эд хөрөнгийг ил болгох гэсэн 4 төрлийн ажиллагааг зохицуулсан байна (ИХШШГтХ-ийн 1-р зүйл).

1980 оноос өмнө дээр дурдсан ажиллагааны дотроос шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх ажиллагаа нь хуучин иргэний процессын хуулиар зохицуулагдаж байсан бол барьцаа хөрөнгийн эрхийг хэрэгжүүлэх болон эд хөрөнгийн үнэлгээ тогтоох зорилготой дуудлага худалдаа нь Дуудлага худалдааны тухай хуулиар зохицуулагдаж байв. Гэсэн хэдий ч шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг сайжруулж, боловсронгуй болгох шаардлагын дагуу хууль тогтоомжийн шинэчлэл хийгдэж, эдгээр ажиллагааг ИХШШГтХ-аар нэгтгэн зохицуулах болжээ. Энэхүү хууль хэрэгжиж эхэлснээр Дуудлага худалдааны тухай хууль хүчингүй болсон юм.

Тус хууль нь Монгол Улсын ШШГтХ-аас ялгаатай нь захиргааны хэргийг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар тусгайлан зохицуулсан бүлэг байхгүй юм. Гэсэн хэдий ч захиргааны хэргийг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаатай холбоо бүхий зарим зохицуулалт тусгагдсан байна. Иймд доорх хэсэгт

эхлээд тус улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцооны талаар товч танилцуулсны дараа захиргааны хэргийг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг гүйцэтгэхтэй холбоотой зарим зохицуулалтыг дэлгэрэнгүй авч үзье.

4.3 ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГА

Тус улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь Монгол Улсаас ялгаатай нь гүйцэтгэх эрх мэдлийн дор харьяалагдах, агентлаг хэлбэрээр орших бус шүүх эрх мэдлийн дор шууд харьяалагддаг байна. Тус улсад шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хариуцах бөгөөд уг байгууллага нь ИХШШГТХ-д зааснаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх шүүх болон шүүхийн шийдвэр гүйцэтгэгчид байдаг. Энэхүү хоёр субъектийг хамтад нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага гэж нэрлэдэг (ИХШШГТХ-ийн 2 болон 3-р зүйл).

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үүсгэх тухай хүсэлт гаргаснаар эхлэх бөгөөд хэргийг эцэслэн шийдсэн шүүх нь уг хүсэлтийг хүлээн авснаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг удирдан зохион байгуулна гэсэн үг биш юм. Харин шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үр нөлөөтэй, шуурхай явуулахын тулд “шүүн таслах ажиллагаа болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг салгаж авч үзнэ” гэсэн зарчмыг баримталдагтай холбоотой бөгөөд шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хариуцах байгууллага нь хэргийг эцэслэн шийдсэн шүүхээс өөр байж болно гэсэн үг.³⁸ Гэхдээ мөнгөн дүнгийн бус шаардлагыг гүй-

³⁸ 和田吉弘『基礎からわかる民事執行法・民事保全法【第2版】』（弘文堂、2010年），Вада Ёшихиро “Үндэс сууриас нь ойлгох Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тухай хууль, Иргэний хэргийн шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээний тухай хууль, хоёр дахь хэвлэл”, 2010, 54 дэх тал.

цэтгэхтэй холбоотой зарим тохиолдолд тухайн шаардах эрхийг судлах болон шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх ажиллагаа хоорондын нягт уялдаатай байдал зэргийг харгалзан тухайн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үндэслэл болох шүүхийн шийдвэрийг гаргасан шүүхтэй ойролцоо шатны шүүх нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх шүүх болох тохиолдол бий (ИХШШГТХ-ийн 171.2).³⁹

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх шүүх

ИХШШГТХ-д зааснаар 1. Шүүхээс хэрэгжүүлэх иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тухайд тус хуульд зааснаар шүүхийн шийдвэр гүйцэтгэлтэй холбоотой арга хэмжээ авахаар хуульчлагдсан шүүх нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх шүүх болох бөгөөд 2. Шийдвэр гүйцэтгэгчээс хэрэгжүүлэх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тухайд тус шийдвэр гүйцэтгэгчийн харьяалагддаг орон нутгийн шүүх нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх шүүх болно гэж заажээ (ИХШШГТХ-ийн 3-р зүйл).

Шүүхийн шийдвэр гүйцэтгэгч

Шийдвэр гүйцэтгэгч нь Шийдвэр гүйцэтгэгчийн тухай хуульд зааснаар 1. Шүүхийн бүтэц дотор харьяалагдаж, 2. Төлбөр авагчаас (нэхэмжлэгч) шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг үүсгэх тухай хүсэлт гаргаснаар шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь шийдвэр гүйцэтгэгчид санамсаргүйгээр хуваарилагддаг. Шийдвэр гүйцэтгэгч нь төрийн албан хаагч боловч шийдвэр гүйцэтгэх ажиллагаанаас тодорхой хувь хэмжээний урамшуулал авах нь хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн бөгөөд өөрөөр хэлбэл төлбөр авагчийн (нэхэмжлэгч) төлсөн хураамжаас орлого олох боломжтой гэсэн үг юм. Энэхүү урамшуулал нь тодорхой хэмжээний мөнгөн дүнд хүрээгүй тохиолдолд улсаас шийдвэр гүйцэтгэгчид нөхөн олговор олгох зохицуулалттай байна.⁴⁰

³⁹ Мөн тэнд.

⁴⁰ Мөн тэнд, 54-55 дахь тал.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын чиг үүрэг

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг шүүх, эсхүл шийдвэр гүйцэтгэгчийн аль нь хэрэгжүүлэх вэ гэдгийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны төрлөөс хамаарч шийднэ.⁴¹ Тухайлбал

Хүснэгт 4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын чиг үүрэг

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага	Голлох чиг үүрэг	Хамтын ажиллагаа, хяналтын чиг үүрэг
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх шүүх	Үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой шийдвэр гүйцэтгэл (ИХШШГТХ-ийн 43-р зүйл), Шаардах эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой шийдвэр гүйцэтгэл (ИХШШГТХ-ийн 143-р зүйл)	Албадан дуудлага худалдаа явуулахдаа шийдвэр гүйцэтгэгчид нөхцөл байдлыг судлах захирамж гаргадаг (ИХШШГТХ-ийн 57-р зүйл).
Шийдвэр гүйцэтгэгч	Хөдлөх хөрөнгөтэй холбоотой шийдвэр гүйцэтгэл (ИХШШГТХ-ийн 122-р зүйл), Үл хөдлөх эд хөрөнгийг шилжүүлэх, чөлөөлөхтэй холбоотой шийдвэр гүйцэтгэл (ИХШШГТХ-ийн 168-р зүйл)	Амралтын өдөр болон шөнө оройн цагаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хэрэгжүүлэхэд шийдвэр гүйцэтгэх шүүхийн зөвшөөрөл шаардлагатай (ИХШШГТХ-ийн 8-р зүйл). Шийдвэр гүйцэтгэгчийн хууль зөрчсөн үйлдэлтэй холбоотой гомдлыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх шүүх хянан шийдвэрлэнэ (ИХШШГТХ-ийн 11-р зүйл).

⁴¹ Мөн тэнд, 55 дахь тал.

4.4 ЗАХИРГААНЫ ХЭРГИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭСЭН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙГ БИЕЛҮҮЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ ЗАРИМ ЗОХИЦУУЛАЛТ

ИХШШГТХ-аар шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь 1. Мөнгөн дүнтэй холбоотой шүүхийн шийдвэр гүйцэтгэл, 2. Мөнгөн дүнтэй холбоотой бус шүүхийн шийдвэр гүйцэтгэл гэсэн үндсэн хоёр төрөлд хуваагдана.

Мөнгөн дүнтэй холбоотой шүүхийн шийдвэр гүйцэтгэл нь төлбөр төлөгчийн бэлэн мөнгө, цалингийн болон бусад орлого, хадгаламж зэргийг хураан авч, төлбөр авагчид шилжүүлж, хохирлыг нь барагдуулах ажиллагаа бөгөөд хэрвээ төлбөр төлөгчийн мөнгө нь төлбөр авагчийн хохирлыг барагдуулж хүрэлцэхгүй байгаа тохиолдолд төлбөр төлөгчийн хөрөнгийг хураан авч, борлуулаад олсон орлогыг төлбөр авагчид шилжүүлэх ажиллагаа юм. Энэхүү ажиллагаанд 1. Үл хөдлөх эд хөрөнгө, 2. Усан онгоц, 3. Хөдлөх хөрөнгө, 4. Шаардах эрхийг хэрэгжүүлэх (хөдлөх хөрөнгийг шилжүүлэхтэй холбоотой, бусад хөрөнгийн эрхтэй холбоотой, бага үнийн дүнтэй хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэл хамаарна), 5. Тэжээн тэтгэх үүрэгтэй холбоотой мөнгөн дүнгийн шаардлагыг албадан гүйцэтгэхтэй холбоотой тусгайлсан зохицуулалт гэсэн зохицуулалтууд хамаардаг.

Мөнгөн дүнтэй холбоотой бус шүүхийн шийдвэр гүйцэтгэл нь дотроо 1. Эд зүйлийг шилжүүлэх, чөлөөлөхтэй холбоотой албадлага, 2. Үйлдэл, эс үйлдэхүйтэй холбоотой албадлага, 3. Хүсэл зоригийн илэрхийлэлтэй холбоотой албадлага гэсэн гурван төрөлд хуваагдана.⁴² Эдгээрийн дотроос хоёр буюу үйлдэл, эс үйлдэхүйтэй холбоотой албадлага нь энэхүү судалгааны сэдэвт хамаарах тул дор дэлгэрүүлэн авч үзье.

⁴² Мөн тэнд, 171 дэх тал.

Үйлдэл, эс үйлдэхүйг албадан гүйцэтгэнэ гэдэг нь 1. Гуравдагч этгээдээс төлбөр төлөгчийг (хариуцагч) төлөөлж, үүргийн гүйцэтгэлийг биелүүлэх болон 2. Гагцхүү төлбөр төлөгч (хариуцагч) л биелүүлэх боломжтой, төлөөлөн гүйцэтгэж болохгүй гэсэн хоёр хэлбэртэй. Эхний тохиолдолд төлөөлөн гүйцэтгүүлэх үү, эсхүл шууд бус албадлагын арга хэмжээ хэрэглэх үү гэсэн хоёр сонголт бий. Төлөөлөн гүйцэтгүүлэх тохиолдолд бусад этгээд үүргийн гүйцэтгэлийг биелүүлмэгц түүнд зарцуулсан зардлыг төлбөр авагч (нэхэмжлэгч) нь төлбөр төлөгчөөс (хариуцагч) шаардах эрхтэй. Харин хоёр дахь тохиолдолд шууд бусаар албадах арга хэмжээг хэрэгжүүлэхээс өөр аргагүй юм.⁴³

Төлөөлөн гүйцэтгэж болох үйлдлийг албадан гүйцэтгэх

Иргэний хуулийн 414.2-т “Үүргийн шинж чанараас хамааран албадлага хэрэгжүүлэх боломжгүй тохиолдолд тухайн үүрэг нь үйлдэл хийхийг шаардсан агуулгатай бол үүрэг гүйцэтгүүлэгч нь үүрэг гүйцэтгэгчийн зардлаар гуравдагч этгээдээр тухайн үүргийг төлөөлөн гүйцэтгүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргаж болно” гэж заасан. Энэ нь үүрэг гүйцэтгүүлэгчээс бусад гуравдагч этгээд ч мөн адил үүргийн гүйцэтгэлд чиглэсэн үйлдлийг хийх боломжтой буюу төлөөлөн гүйцэтгэж болох үүргийг илэрхийлсэн гэж тайлбарладаг. Тухайлбал эд зүйл тээвэрлэх, барилга нураах, буулгах, сонинд уучлал гуйсан агуулгыг нийтлүүлэх зэрэг үүрэг хамаарна.

Мөн хуулийн дээрх заалтын 412.3-т “Эс үйлдэхүйг шаардсан үүргийн тухайд үүрэг гүйцэтгэгчийн зардлаар үүрэг гүйцэтгэгчийн үйлдсэн үйлдлийн үр дагаврыг арилгах, эсхүл ирээдүйд зохистой арга хэмжээ авах талаар шүүхэд нэхэмжлэл гаргаж болно” гэж заасан бөгөөд энэ нь эс үйлдэхүйг шаардсан үүрэг нь өөрөө төлөөлөн гүйцэтгүүлэх боломжгүй зүйл байсан

⁴³ Мөн тэнд, 172 дахь тал.

ч хэрвээ энэхүү үүргийг зөрчсөн бол зөрчсөнөөс үүссэн үр дагаврыг арилгах, ирээдүйд зохистой арга хэмжээ авахыг гуравдагч этгээд ч хэрэгжүүлэх боломжтой учраас төлөөлөн гүйцэтгүүлэх боломжтой үйлдлийг шаардсан үүргийн нэгэн адил шүүхэд шаардлага гаргаж болно гэж заажээ.

ИХШШГТХ-ийн 171.1-т “Иргэний хуулийн 414.2 болон 414.3-т заасан шаардлагыг биелүүлэхдээ шүүхийн шийдвэр гүйцэтгэх шүүх нь Иргэний хуулийн заалтад үндэслэж, шийдвэр гаргах зарчмаар хэрэгжүүлнэ” гэж заасан. Энэхүү шүүхийн шийдвэр нь үүрэг гүйцэтгэгчийн зардлаар үүрэг гүйцэтгүүлэгч нь үүрэг гүйцэтгэгчийг төлөөлөн үүрэг гүйцэтгүүлэхээр эрх олгож буй зохицуулалт юм. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх шүүхээс үүргийн гүйцэтгэлийг төлөөлөн гүйцэтгүүлэх шийдвэр гаргахдаа үүрэг гүйцэтгэгчээс тайлбар авах шаардлагатай (ИХШШГТХ-ийн 171.3). Үүрэг гүйцэтгэгч нь зардлыг урьдчилан үүрэг гүйцэтгүүлэгчид төлөхийг захирамжилж болно (ИХШШГТХ-ийн 171.4). Төлөөлөн гүйцэтгүүлэх хүсэлтийг шийдвэрлэх болон урьдчилан зардал төлөх талаар шүүхээс захирамж гаргуулахыг шаардсан хүсэлттэй холбоотой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гомдол гаргаж болно (ИХШШГТХ-ийн 171.5).

Төлөөлүүлэн гүйцэтгэж болохгүй үйлдэл, эс үйлдэхүйг албадан гүйцэтгэх

Үйлдэл, эс үйлдэхүйг шаардсан үүргийн гүйцэтгэлийг төлөөлөн гүйцэтгүүлэх боломжгүй тохиолдолд шууд бус албадлагын арга хэмжээг хэрэглэнэ (ИХШШГТХ-ийн 172-р зүйл).

Шууд бус албадлагын арга хэмжээ гэдэг нь “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх шүүхээс үүрэг гүйцэтгэгчид чиглүүлж шүүхийн шийдвэрийн биелэлтийг хожимдуулсан хугацаанд нь нийцүүлж, эсхүл зохистой гэж үзэж, тогтоосон тодорхой хугацааны дотор шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй бол

тэр даруйд нь үүргийн гүйцэтгэлийг хангуулахын тулд зохистой гэж үзэхүйц тодорхой хэмжээний мөнгөн дүнг үүрэг гүйцэтгүүлэгчид төлүүлэхээр захирамжлах арга юм” (ИХШШГТХ-ийн 172.1). Нөхцөл байдал өөрчлөгдсөн тохиолдолд талуудын хүсэлтээр дээрх захирамжийг өөрчилж болно (ИХШШГТХ-ийн 172.1).

Дээрх зохицуулалт нь 2003 оны хуулийн нэмэлт өөрчлөлтийн дагуу үл хөдлөх эд хөрөнгийг шилжүүлэх, чөлөөлөх зэрэг мөнгөн дүнгийн бус шаардлагыг хэрэгжүүлэхэд хэрэглэгдэхээр (ИХШШГТХ-ийн 173-р зүйл) болсон бөгөөд 2004 оны хуулийн нэмэлт өөрчлөлтөөр тэжээн тэтгэх үүрэгтэй холбоотой мөнгөн дүнгийн шаардлагыг албадан гүйцэтгэхэд шууд бус албадлагын арга хэмжээг хэрэглэхээр болсон юм (ИХШШГТХ-ийн 167.15-р зүйл).

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх шүүх нь зарчмын хувьд анхан шатны шүүх байх бөгөөд тус шүүх нь шууд бус албадлагын арга хэмжээг хэрэглэх шийдвэрийг гаргахдаа үүрэг гүйцэтгэгчээс тайлбар авах шаардлагатай (ИХШШГТХ-ийн 172.3-р зүйл). Шууд бус албадлагын арга хэмжээг хэрэглэх тухай хүсэлтийг шийдвэрлэх ажиллагаанд гомдол гаргаж болдог (ИХШШГТХ-ийн 172.5-р зүйл). Үүргийн гүйцэтгэлийг үл биелүүлснээс үүсэх хохирлын хэмжээ нь шууд бус албадлагын арга хэмжээний дагуу төлсөн мөнгөн дүнгээс хэтэрсэн тохиолдолд үүрэг гүйцэтгүүлэгч нь тухайн хэтэрсэн үнийн дүнгээр хохирол барагдуулахыг шаардахад саад болохгүй ИХШШГТХ-ийн 172.4-р зүйл).

Энэхүү зохицуулалт нь захиргааны хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн биелэлтийг дэмжихэд ямар чиг үүрэг гүйцэтгэдэг талаар тодорхой кэйс дээр тулгуурлан дэлгэрүүлэн авч үзье.

4.5. ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН СУДАЛГАА

Исахая тэнгисийн буланг газар тариалангийн зориулалттай газар болгохтой холбоотой үүссэн маргаан

Хэргийн товч агуулга⁴⁴

Нагасаки, Сага, Фүкүока, Күмомото гэсэн 4 мужийн нутаг дэвсгэрийг хамарсан Кюүшү бүс нутгийн хамгийн том тэнгисийн булан нь Ариаке тэнгис юм. Тус тэнгисийн өмнө, хойд хэсгээс Нагасаки муж тал руу гүнзгий нэвтрэн орсон хэсэг нь Исакхая булан юм. Тус тэнгисийн буланг газар тариалангийн зориулалттай газар болгох үйл явц эрт үеэс (Эдогийн үе) эхлэлтэй. Далан байгуулж, бага багаар тэнгисийн усыг хааснаар газар тариалангийн зориулалттай том талбай бий болж, Нагасаки муждаа хамгийн томд тооцогдох газар тариалангийн газар болсон боловч тус нутгийн цаг уурын онцлогоос шалтгаалж, аадар бороо ихээр орж, үерийн аюул байнга нүүрлэдгийн улмаас хот усанд автаж, ургац алдах хохирол их гардаг байв. Нутгийн иргэдийн зүгээс тэнгисийн далан байгуулж, хотыг үер усны аюулаас хамгаалах шаардлага хүргүүлж байсан тул тус нутгийн засаг дарга 1997 онд нийт урт нь 7 км үргэлжлэх даланг байгуулж, 2008 онд бүтээн байгуулалтын ажлыг дуусгавар болгов.

Ийнхүү тариаланчдын эрх ашиг тодорхой хэмжээнд хамгаалагдсан хэдий ч нөгөө талаас Ариаке тэнгист ургуулдаг далайн байцайны өнгө хувирч, ургацын чанар эрс муудаж, загасны аж ахуй эрхлэгчдэд томоохон хохирол учрах болов. Ингээд Сага, Фүкүока, Күмомото гурван мужийн загасны аж ахуй эрхлэгчид далангийн хаалгыг нээж, байгаль орчны нөлөөллийн судалгаа хийхийг төрөөс шаардав. Гэтэл нөгөө

⁴⁴ Япон Улсын “Эдийн засаг” сонины 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн “Исахая тэнгисийн буланг газар тариалангийн зориулалттай газар болгохтой холбоотой үүссэн маргааныг эхнээс нь сайн ойлгох нь” гарчигтай нийтлэлээс хураангуйлан оруулав.

талаас Нагасаки мужийнхан хаалгыг нээснээр газар тариалангийн газарт далайн ус нэвтэрч, ургац алдах хохиролтой тул нээхийг эсэргүүцсэн юм.

2002 онд Засгийн газраас нэг сар орчим далангийн хаалгыг нээж, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг судалсан боловч Ариаке тэнгисийн байгаль орчин сайжирч, өөрчлөлт ажиглагдаагүй тул шалтгаант холбоо байхгүй гэж дүгнэв. Мөн 2006 онд Засгийн газраас “Цаашид энэ төрлийн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн судалгааг дахин хийхгүй” гэсэн чиглэлтэй байгаагаа мэдэгдэв.

Шүүхийн шийдвэрлэсэн байдал⁴⁵

Засгийн газрын шийдвэрийг эсэргүүцсэн 2500 орчим загасны аж ахуй эрхлэгчид 2002 оны 11 дүгээр сард төрийг хариуцагчаар татаж, далангийн бүтээн байгуулалтын ажлыг зогсоох шаардлагыг Сага мужийн орон нутгийн шүүхэд гаргав. Тус орон нутгийн шүүх нь 2008 онд хэсэг бүлэг загасны аж ахуй эрхлэгчдэд хохирол учирсан болохыг тогтоож, гурван жилийн дотор даланг нээж, таван жилийн туршид далангийн хаалгыг нээх эсэх судалгааг гүйцэтгэж, Ариаке тэнгисийн байгаль орчинд өөрчлөлт гарсан эсэхийг судлахыг төрд даалгаж шийдвэрлэв. Хохирол учирсан эсэх нь шүүхээр тогтоогдоогүй хэсэг бүлэг загасны аж ахуй эрхлэгчид Фүкүока мужийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргасан юм. Тус шүүхээс 2010 оны 12 дугаар сард анхан шатны шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрч, далангийн хаалгыг нээхийг төрд даалгаж шийдвэрлэв. Ингээд дээрх шүүхийн шийдвэрийг биелүүлэх эцсийн хугацаа 2013 оны 12 дугаар сарын 20-ноор дуусгавар болсон боловч төр шүүхийн шийдвэрийг үл биелүүлж, далангийн хаалгыг нээгээгүй юм.

⁴⁵ 1-р эшлэлтэй адил, мөн нийтлэлээс хураангуйлан оруулав.

Мөн Нагасаки мужийн шүүх нь 2013 оны 11 дүгээр сард газар тариалан эрхлэгчдийн зүгээс гаргасан хүсэлтийн дагуу далангийн хаалгыг нээхийг зогсоох тухай шийдвэр гаргахыг төрд даалгасан түр арга хэмжээг захирамжилсан шийдвэр гаргав. Энэхүү шийдвэрийн дагуу газар тариалан эрхлэгчид далангийн хаалгыг нээсэн тохиолдолд төрд шууд бус албадлагын арга хэмжээ авах тухай хүсэлтийг тус шүүхэд гаргав. Тус орон нутгийн шүүх болон Фүкүока мужийн давж заалдах шатны шүүхээс 2015 онд өдөрт 490,000 иений (иений одоогийн ханшаар 12,250,000 орчим төгрөгийн торгууль) шууд бус албадлагын арга хэмжээний мөнгийг төрөөр төлүүлэх шийдвэр гаргав.

Нөгөө талаас загасны аж ахуй эрхлэгчид 2010 оны шүүхийн шийдвэрийг биелүүлэх эцсийн хугацаа өнгөрсний дараа буюу 2013 оны 12 дугаар сарын 24-нд тус шүүхийн шийдвэрт үндэслэж, далангийн хаалгыг нээх хүртэл шууд бус албадлагын арга хэмжээ авах тухай хүсэлтийг Сага мужийн орон нутгийн шүүхэд гаргав. 2014 оны тус орон нутгийн шүүх болон Фүкүока мужийн давж заалдах шатны шүүхээс төрд өдөрт 490,000 иений шууд бус албадлагын арга хэмжээ авах тухай шийдвэр гаргав.

Ингэснээр төр далангийн хаалгыг нээсэн ч нээгээгүй ч шууд бус албадлагын арга хэмжээний мөнгийг төлөх үүрэгтэй болж, өвөрмөц нөхцөл байдал үүсэв. Төр дээрх шүүхийн шийдвэрүүдийг эсэргүүцэн гомдол гаргасан боловч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд алдаа зөрчил гараагүй гэдэг үндэслэлээр Дээд шүүх өмнөх шатны шүүхийн шийдвэрүүдийг хүлээн зөвшөөрч, гомдлыг хүлээн аваагүй байна.

Ингээд 2016 онд төрийн зүгээс эвлэрлийн санал гаргав. Эвлэрлийн саналд далангийн хаалгыг нээхгүй боловч Ариаке тэнгисийн байгаль орчны нөлөөллийн судалгааг гүйцэтгэх болон загасны нөөцийг нөхөн сэргээх 100 тэрбум иений сан байгуулах тухай дурдсан байв. Энэхүү эвлэрлийн санал нь далангийн

хаалгыг нээхийг үүрэг болгосон 2010 оны шүүхийн шийдвэртэй зөрчилдөх боловч төрийн зүгээс “Тухайн үетэй харьцуулахад Ариаке тэнгисийн байгаль орчны нөхцөл байдал өөрчлөгдсөн” гэж тайлбарласан юм. Мөн төрөөс шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хүчингүй болгохыг шаардсан нэхэмжлэлийг шүүхэд гаргасан байна. Энэхүү маргаантай холбоотойгоор Сага мужийн орон нутгийн шүүх 2014 онд төрөөс гаргасан нэхэмжлэлийн шаардлагыг хангаагүй бол, 2018 онд Фүкүока мужийн давж заалдах шатны шүүх төрийн гаргасан эвлэрлийн саналд тулгуурлаж, эвлэрлийн санал гаргасан нь загасны аж ахуй эрхлэгчдийн зүгээс “Шүүх өөрөө шийдвэр гаргаж чадахгүй засгийн газрын хэлснийг дагалаа” хэмээн тэдний эсэргүүцэлтэй тулсан юм. Гэвч тус шүүхээс төрийн гаргасан шаардлагыг хангаж шийдвэрлэв.

Дээрх шүүхийн шийдвэрийн үндэслэлд Загасны аж ахуй эрхлэх тухай хуульд зааснаар загасны аж ахуй эрхлэх тусгай зөвшөөрөл нь арван жилийн хугацаатай бөгөөд давж заалдах шатны шүүхээс 2010 оны шүүхийн шийдвэрийг танилцуулах үед хэрэгжиж байсан загасны аж ахуй эрхлэх тусгай зөвшөөрөл нь 2013 оны 8 дугаар сард дуусгавар болсон байна. Тэгэхээр шаардлагын гол үндэслэл болох “Загасны аж ахуй эрхлэх тусгай зөвшөөрөл дуусгавар болсон тул загасчдын зүгээс далангийн хаалгыг нээх шаардлагыг тавих боломжгүй” гэж үзжээ. Загасчдын зүгээс “Загасны аж ахуй эрхлэх тусгай зөвшөөрлийг дахин сэргээснээр загасны аж ахуй эрхлэх эрх үргэлжилж буй” хэмээн хариу тайлбар гаргасан боловч давж заалдах шатны шүүхээс тусгай зөвшөөрөл дуусгавар болохын өмнөх загасны аж ахуй эрхлэх эрхийн тухайд энэ нь тусдаа асуудал болно гэж үзсэн. Ингээд шүүхээс бусад маргаантай асуудлыг авч хэлэлцэлгүйгээр төрөөс гаргасан нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэв.

Харин Дээд шүүхийн зүгээс 2019 оны 9 дүгээр сард загасны

аж ахуй эрхлэх эрх нь тусгай зөвшөөрөл сунгагдсаны дараа ч үргэлжилж буй гэж үзэх тул давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг “зөвтгөх” боломжгүй юм. Ариаке тэнгис, Исахая булангийн байгаль орчны өөрчлөлт зэрэг загасны аж ахуй эрхлэх эрхээс (тусгай зөвшөөрөл) бусад маргаантай асуудлын талаар мөн 2010 оны шүүхийн шийдвэрийн дагуу шууд бус албадлагын арга хэмжээг хэрэгжүүлж буй нь зохистой эсэх талаар шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дахин явуулах шаардлагатай гэж үзэж хэргийг дахин хэлэлцүүлэхээр давж заалдах шатны шүүх рүү буцааж шийдвэрлэсэн байна.

Шууд бус албадлагын арга хэмжээний эрх зүйн мөн чанартай холбоотой онолын тайлбар

Дээрх кэйсийн дагуу 2018 онд Фүкүока мужийн давж заалдах шатны шүүх нь төрөөс далангийн хаалгыг нээх эсэхтэй холбоотой маргааныг эцэслэн шийдсэн өмнөх шүүхийн шийдвэрүүдэд гомдол гаргасныг хангаж шийдвэрлэсэн бөгөөд өмнөх шүүхийн шийдвэрүүдийн дагуу хэрэгжиж буй шууд бус албадлагын арга хэмжээг зогсоох тухай шийдвэр гаргасан. Хэрвээ энэхүү шүүхийн шийдвэр эцэслэн батлагдсан тохиолдолд өмнөх шүүхийн шийдвэрүүдийн дагуу нэхэмжлэгч талд төлж байсан шууд бус албадлагын арга хэмжээний мөнгөн төлбөрийг төрийн зүгээс нэхэмжлэгч талыг үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн гэдэг үндэслэлээр буцаан шаардаж болох тухай асуудал үүсэх юм.⁴⁶

Шууд бус албадлагын арга хэмжээний эрх зүйн мөн чанарын талаар авч үзэхийн тулд ИХШШГТХ батлагдахын өмнө болон дараа өрнөж байсан онолын тайлбаруудыг судлах шаардлагатай.

⁴⁶ 宮澤俊昭「間接強制金の法的性質についての一考察」-諫早湾干拓紛争におけるいくつかの問題をきっかけとして-Миязава Тошиаки “Шууд бус албадлагын арга хэмжээний эрх зүйн мөн чанарын талаарх эргэцүүлэл дүн шинжилгээ” Исахая тэнгисийн буланг газар тариалангийн зориулалттай газар болгохтой холбоотой үүссэн маргаан дахь хэд хэдэн асуудлыг үндэслэх нь эрдэм шинжилгээний өгүүлэл, 2020 оны 3 дугаар сар, 91-92 дахь тал.

Хууль батлагдахын өмнө шууд бус албадлагын арга хэмжээг хохирол барагдуулах нөхөн төлбөр гэж тайлбарлах нь түгээмэл байв. Мөн уг арга хэмжээний мөнгөн дүнг тогтоохдоо бодитоор учирсан хохирлоос гадна сэтгэл санааны хохирол, үүргийн агуулга, шинж чанар, үүрэг гүйцэтгэгчийн хандлага зэрэг холбогдох бүхий л нөхцөл байдлыг харгалзан үзэж шүүхийн шийдвэрийн биелэлтийг баталгаажуулахад хангалттай хэмжээний мөнгөн дүнг шүүхээс тогтооно гэсэн байр суурь (тайлбар) хүчтэй байв.⁴⁷

Үүнээс хойш ИХШШГТХ батлагдсаны дараа тус хуулийн 172.1-т “Үйлдэл, эс үйлдэхүйг шаардсан үүргийн гүйцэтгэлийн хувьд шүүхийн шийдвэр гүйцэтгэх шүүхээс шүүхийн шийдвэрийн биелэлтийг хойшлуулсан хугацаанд нь нийцүүлж, эсхүл зохистой гэж үзсэн тодорхой хугацааны дотор үүрэг гүйцэтгэгч шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй бол тэр даруй үүргийн гүйцэтгэлийг баталгаажуулах зорилгоор зохистой гэж үзэхүйц тодорхой хэмжээний мөнгөн дүнг үүрэг гүйцэтгүүлэгч талд төлүүлэхээр захирамжилж болно” гэж заасан. Энэхүү хуулийн заалтаас үүдэн шууд бус албадлагын арга хэмжээний эрх зүйн мөн чанарыг 1. Хохирол барагдуулах нөхөн төлбөр, 2. Шийтгэлийн мөнгөн төлбөр, 3. Холимог хэлбэр гэсэн гурван янзаар тайлбарладаг байна. Эдгээрийг дор товч авч үзье.⁴⁸

Хохирол барагдуулах нөхөн төлбөр

Шууд бус албадлагын арга хэмжээний эрх зүйн мөн чанарыг үүргийн зөрчилд оногдуулж буй төлбөр (торгуультай төстэй) гэж тайлбарладаг. Үүний үндэслэл нь ИХШШГТХ-ийн 172.4-т “Үүргийн гүйцэтгэлийг үл биелүүлсний улмаас учирсан хохирлын хэмжээ нь үүрэг гүйцэтгэгчийн төлбөл зохих мөнгөн дүнгээс (шууд бус албадлагын арга хэмжээний төлбөл зохих мөнгөн дүн) хэтэрсэн тохиолдолд үүрэг гүйцэтгүүлэгч нь мөнгөн

⁴⁷ Мөн тэнд, 93 дахь тал.

⁴⁸ Мөн тэнд, 94 дэх тал.

дүнгийн зөрүүнээс үүсэх хохирлыг барагдуулахаар шаардаж болохоос гадна энэхүү заалтыг тайлбарлан хэрэглэж, үүрэг гүйцэтгүүлэгч шууд бус албадлагын арга хэмжээний мөнгөн дүнг хүлээн авч буй тохиолдолд тухайн мөнгөн дүнг учирсан хохирлын хэмжээнээс хасаж тооцож болох юм.⁴⁹

Шийтгэлийн мөнгөн төлбөр

Шийтгэлийн мөнгөн төлбөр гэж үздэг байр суурь нь шууд бус албадлагын арга хэмжээг хохирол барагдуулах нөхөн төлбөр гэдэг ойлголтоос салган авч үзэж, гүйцэтгэх хуудаст заасан захирамж, эсхүл шууд бус албадлага хэрэгжүүлэхийг захирамжилсан шүүхийн шийдвэрийг үл биелүүлсний төлөө оногдуулж буй шийтгэл гэж тайлбарладаг. Үүний үндэслэл нь 1. Хохирлын хэмжээ бус шүүхийн шийдвэрийг биелүүлэх сэтгэл зүйг албадахад шаардлагатай хэмжээгээр шууд бус албадлагын арга хэмжээний мөнгөн дүнг тогтоох, 2. Хохирлын хэмжээг хэмжигдэхүүн болговол шүүхийн шийдвэрийг биелүүлэхэд үүсэх нөхцөл байдлыг уян хатнаар авч үзэх боломжгүй болох, үнийн дүн нь багасах эрсдэлтэй бөгөөд шууд бус албадлагын арга хэмжээний үр нөлөөг бууруулах магадлалтай гэж үздэг байна.⁵⁰

Холимог хувилбар

Шууд бус албадлагын арга хэмжээ нь дээрх хоёр үзэл баримтлалын аль алиных нь шинж чанарыг агуулсан гэж тайлбарладаг байр суурь юм.⁵¹ Гэвч шууд бус албадлагын арга хэмжээг дээрх байдлаар тайлбарлах нь алдаа дутагдалтай байсан тул сүүлийн жилүүдэд эдгээр онолын тайлбаруудыг дахин авч үзэх шаардлага үүссэн байна. Ингээд шууд бус албадлагын арга хэмжээг 1. Хохирол барагдуулах нөхөн төлбөр, 2. Хувийн эрх зүйн үүргийн зөрчилд оногдуулах мөнгөн төлбөр, 3.

⁴⁹ Мөн тэнд, 94 дэх тал.

⁵⁰ Мөн тэнд, 95 дахь тал.

⁵¹ Мөн тэнд, 96 дахь тал.

Нийтийн эрх зүйн албадлагын арга хэмжээ (Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хуудаст заасан албадлагыг хэрэгжүүлэх зорилготой), 4. Нийтийн эрх зүйн албадлагын арга хэмжээ (Шууд бус албадлага хэрэгжүүлэхийг захирамжилсан шүүхийн шийдвэрийг биелүүлэх зорилготой) гэсэн дөрвөн янзаар авч үзэх болсон.⁵²

Хохирол барагдуулах нөхөн төлбөр

Энэхүү тайлбар нь шууд бус албадлагын арга хэмжээг хохирол барагдуулах нөхөн төлбөр гэж үздэг бөгөөд материаллаг хуульд заасан үүргийн гүйцэтгэлийг баталгаажуулахын тулд хохирлын хэмжээнээс гадна харгалзан үзвэл зохистой хүчин зүйлд үндэслэж мөнгөн дүн тогтоохыг хуулиар хүлээн зөвшөөрсөн гэж тайлбарладаг байр суурь юм.⁵³

Хувийн эрх зүйд заасан үүргийн зөрчилд оногдуулах мөнгөн төлбөр

Шууд бус албадлагын арга хэмжээг хувийн эрх зүйд заасан үүрэг зөрчсөний мөнгөн төлбөр гэж тайлбарладаг. Иргэний эрх зүйн үүднээс хувийн эрх зүйд заасан үүргийг зөрчсөний мөнгөн төлбөр гэдэг нь талуудын хүсэл зоригийн үндсэн дээр тогтоогддог. Тэгвэл энэхүү тайлбар нь шууд бус албадлагын арга хэмжээг талуудын хүсэл зоригоор тогтоогддог байдлыг хуулиар тодорхой заасан гэж тайлбарладаг байна.⁵⁴

Нийтийн эрх зүйн албадлагын арга хэмжээ (Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хуудаст заасан албадлагыг хэрэгжүүлэх зорилготой)

Шууд бус албадлагын арга хэмжээг шүүхийн шийдвэр гүйцэтгэх захирамжид (гүйцэтгэх хуудас) заасан албадлагыг биелүүлэхээс татгалзсан, түүнийг зөрчсөн үйлдэлд оногдуулах

⁵² Мөн тэнд, 108 дахь тал.

⁵³ Мөн тэнд, 108 дахь тал.

⁵⁴ Мөн тэнд, 110 дахь тал.

нийтийн эрх зүйн шинжтэй албадлага гэж тайлбарладаг. Энэхүү байр суурь нь шууд бус албадлагын арга хэмжээг зөвтгөх үндэслэлийг материаллаг хуульд заасан шаардах эрх бус Нийтийн эрх зүйн=Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан гүйцэтгэх хуудсаар шүүхийн шийдвэр гүйцэтгэлийг албадах явдал юм гэж үздэг.⁵⁵

Нийтийн эрх зүйн албадлагын арга хэмжээ (Шууд бус албадлага хэрэгжүүлэхийг захирамжилсан шүүхийн шийдвэрийг биелүүлэх зорилготой)

Шууд бус албадлагын арга хэмжээг шүүхийн шийдвэр биелүүлэх захирамжийг зөрчсөн тохиолдолд оногдуулах нийтийн эрх зүйн албадлагын арга хэмжээ гэж тайлбарладаг ба шууд бус албадлагыг хэрэгжүүлэхийг захирамжилсан шүүхийн шийдвэр нь шүүхийн шийдвэрийг биелүүлэх захирамжид тооцогддог.⁵⁶ Дээрх тайлбаруудаас гурав дахь тайлбарыг дэмжих нь зохимжтой гэсэн судалгааны дүгнэлт гарчээ.⁵⁷

Исахая тэнгисийн буланг газар тариалангийн зориулалттай газар болгохтой холбоотой үүссэн маргаанаас дараах хоёр эргэлзээтэй асуудал урган гарсан бөгөөд дээрх тайлбаруудыг үндэслэн эргэлзээтэй асуудалд доорх байдлаар хариулт өгсөн байна.

Нэгдүгээрт, эцэслэн батлагдсан шүүхийн шийдвэрийг үндэслэж, шууд бус албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх захирамж гарсны дараа тухайн шүүхийн шийдвэрт холбогдох этгээдээс гомдол гаргаж, тус гомдлыг шүүхээс хангаж шийдвэрлэсэн тохиолдолд өмнөх захирамжийн дагуу төлөгдөж байсан шууд бус албадлагын арга хэмжээний мөнгөн дүнг үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн гэсэн үндэслэлээр буцаан шаардаж болох уу гэсэн асуудал үүснэ.⁵⁸

⁵⁵ Мөн 110-111 дэх тал.

⁵⁶ Мөн тэнд, 112 дахь тал.

⁵⁷ Мөн тэнд, 133 дахь тал.

⁵⁸ Мөн тэнд, 134 дэх тал.

Үүнд хариулахад шууд бус албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх тухай захирамжийн хууль зүйн хүчин чадал нь уг захирамжийн үндэслэл болох шүүхийн шийдвэрт гомдол гаргасныг шүүхээс хангаж шийдвэрлээд тус шүүхийн шийдвэр эцэслэн батлагдах хүртэл хэвээр хадгалагдана гэж үзнэ. Иймд тус шүүхийн шийдвэрийг эцэслэн батлагдах хүртэл үүрэг гүйцэтгүүлэгчийн хүлээн авч байсан шууд бус албадлагын арга хэмжээний мөнгөн дүнг хууль зүйн үндэслэлтэй байсан гэж үзэх боломжтой. Тэгэхээр энэ тохиолдолд үүрэг гүйцэтгүүлэгч шууд бус албадлагын арга хэмжээний мөнгөн дүнг үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн гэх үндэслэлээр буцаан төлөх шаардлагагүй гэсэн зарчмыг баримтална.⁵⁹

Хоёрдугаарт, эцэслэн батлагдсан шүүхийн шийдвэрийг үндэслэж, шууд бус албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх тухай захирамж гарсны дараа тус захирамжид гомдол гаргаж, шүүхэд хэрэг үүсгэсэн бөгөөд шүүхээс гомдлыг хангахын зэрэгцээ албадлагын арга хэмжээг зогсоох тухай шийдвэр гаргасан боловч Дээд шүүхээс тус шүүхийн шийдвэрийг хүчингүй болгосон тохиолдолд тухайн шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсноос хойш хүчингүй болох хүртэлх хугацааны хоорондох шууд бус албадлагын арга хэмжээний мөнгөн дүнг төлөхийг шаардах боломжтой юу гэсэн асуудал урган гарна. Гэвч энэ тохиолдолд мөн адил шууд бус албадлагын арга хэмжээний мөнгөн дүн төлөхийг шаардах боломжгүй гэж үзсэн байна.⁶⁰

⁵⁹ Мөн тэнд, 135 дахь тал.

⁶⁰ Мөн тэнд, 136 дахь тал.

4.6 ЗАХИРГААНЫ АКТЫГ ХҮЧИНГҮЙ БОЛГОСОН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХУУЛЬ ЗҮЙН ХҮЧИН ЧАДАЛ, ТҮҮНИЙ ҮР НӨЛӨӨ

Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиас гадна Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 33 дугаар зүйлд захиргааны актыг хүчингүй болгосон шүүхийн шийдвэрийн хууль зүйн хүчин чадал, түүний үр нөлөөний талаар зохицуулсан байдаг. Энэхүү зохицуулалтаар шүүхийн шийдвэрийн биелэлтийг баталгаажуулахын тулд захиргааны акт болон захиргааны байгууллагаас гаргасан бусад шийдвэрийг хууль бус гэж шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг хүндэтгэж, уг шүүхийн шийдвэрт заасныг даган мөрдөж, ажиллахыг захиргааны байгууллагад үүрэг болгосон юм. Зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх шүүхийн шийдвэрийн хууль зүйн хүчин чадлыг нэмэгдүүлэхийн тулд захиргааны байгууллагад шүүхийн шийдвэрийг даган биелүүлэхтэй холбоотой материаллаг хуульд заасан үүргийг оногдуулж буй утгатай зохицуулалт юм.

Тус хуулийн 33.1-т “Захиргааны акт, эсхүл захиргааны байгууллагын бусад шийдвэрийг хүчингүй болгосон шүүхийн шийдвэрийг тухайн захиргааны хэргийн хувьд захиргааны акт, эсхүл шийдвэр гаргасан захиргааны байгууллага болон бусад холбогдох бүх захиргааны байгууллага заавал дагаж мөрдөнө” гэж заажээ. Энэ нь захиргааны байгууллагын гаргасан захиргааны акт болон шийдвэрийг хүчингүй болгосон шүүхийн шийдвэрийг тухайн захиргааны байгууллага төдийгүй бусад холбогдох захиргааны байгууллага ч мөн адил ягштал дагаж мөрдөх үүрэгтэйг онцолжээ. Мөн уг зохицуулалтаар захиргааны байгууллага нь адил нөхцөл байдалд, адил үндэслэлээр, ижил агуулгатай захиргааны актыг дахин гаргаж болохгүй гэсэн хууль зүйн үр дагаврыг бий болгосон байна.

33.2 дахь хэсэгт “Өргөдөл, хүсэлтийг хүлээн авахаас

татгалзсан эсхүл өргөдөл, хүсэлтэд заасан шаардлагыг хангаагүй захиргааны акт, эсхүл захиргааны байгууллагын шийдвэр, үйл ажиллагаанд гаргасан гомдлыг хүлээн авахаас татгалзсан, эсхүл гомдлыг хангаагүй шийдвэр нь шүүхийн шийдвэрийн дагуу хүчингүй болсон тохиолдолд тухайн захиргааны акт, эсхүл шийдвэрийг гаргасан захиргааны байгууллага нь тухайн шүүхийн шийдвэрийг даган биелүүлж, дахин өргөдөл, хүсэлтийг шинээр хүлээн авч шийдвэрлэнэ” гэж заажээ. Энэ нь шүүхийн шийдвэрийн дагуу хууль зөрчсөн захиргааны акт болон шийдвэр хүчингүй болсноор өргөдөл, хүсэлт, гомдол гаргасан боловч захиргааны байгууллагаас хариу ирүүлээгүй байдалд шилжих бөгөөд захиргааны байгууллагын хувьд захиргааны актыг дахин залруулж гаргах үүрэгтэй болно гэсэн үг юм. Ингэхдээ захиргааны актыг хүчингүй болгосон шүүхийн шийдвэрийн үндэслэлд зааснаар нэхэмжлэгч талд захиргааны байгууллагаас хариу өгөх үүрэг бий болно гэсэн утгатай юм.

33.3 дахь хэсэгт “Өмнөх заалт нь өргөдөл, хүсэлтэд үндэслэж гарсан захиргааны акт, эсхүл захиргааны байгууллагын шийдвэр, үйл ажиллагаанд гаргасан гомдлыг хангаж шийдвэрлэсэн шийдвэр нь шүүхийн шийдвэрийн дагуу процесс ажиллагааны зөрчилтэй байсны улмаас хүчингүй болсон тохиолдолд мөн адил хамаарна” гэж заажээ. Энэ нь захиргааны байгууллага өргөдөл, хүсэлт гаргагчийн шаардлагыг хангасан шийдвэр гаргасан боловч тэрхүү шийдвэр нь процесс ажиллагааны зөрчилтэйн улмаас шүүхийн шийдвэрийн дагуу хүчингүй болсон ч өмнөх заалтын дагуу тухайн захиргааны байгууллага дахин шийдвэрээ залруулж гаргах үүрэгтэйг онцолсон байна.

Дээрх заалтын дагуу захиргааны акт, эсхүл аливаа шийдвэр гаргасан захиргааны байгууллага нь шүүхийн шийдвэрийг заавал даган биелүүлж, өмнөх гаргасан захиргааны акт,

шийдвэрээ дахин залруулж гаргах, ямарваа нэгэн байдлаар эс үйлдэхүй гаргаж, дахин нэхэмжлэгч талын эрхийг зөрчиж болохгүй талаар үүрэг болгон зохицуулсан нь харагдаж байна.

Мөн дээрх заалт нь захиргааны актыг хүчингүй болгохтой холбоотой нэхэмжлэлээс гадна эс үйлдэхүй хууль бус болохыг тогтоох болон даалгах нэхэмжлэл, үүрэгтэй эсэхийг тогтоох нэхэмжлэл, аливаа үйл ажиллагааг түр таслан зогсоох, түдгэлзүүлэх тухай нэхэмжлэл зэргийг хангаж шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн биелэлтийг баталгаажуулахад мөн адил хамаарна гэж өргөн хүрээнд зохицуулжээ (ЗХШХШтХ-ийн 38.1).

ДҮГНЭЛТ, САНАЛ

Дээрх судалгааны үр дүнг дараах байдлаар нэгтгэн дүгнэх боломжтой байна. Үүнд:

Нэгдүгээрт, иргэний хэргийн шүүх захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлтэй холбоотой маргааныг шийдвэрлэж буй байдалд тоон болон чанарын судалгааны арга зүйг ашиглан дүн шинжилгээ хийхэд захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн биелэлт тун хангалтгүй байгаа нь ажиглагдлаа.

Тодруулбал НШГА-аас гаргасан захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн талаарх сүүлийн гурван жилийн тоон мэдээнээс үзэхэд тус шүүхийн шийдвэрийн биелэлтийн хувь тогтмол буурсан дүнтэй байна. Сүүлийн хоёр жилийн байдлаар авч үзэхэд шүүхийн шийдвэрийн биелэлт 50-аас доош хувьтай байна.

Чанарын судалгааны хүрээнд иргэний хэргийн шүүх захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад үүссэн маргааныг хянан шийдвэрлэсэн нийт таван хэргийн холбогдох шүүхийн шийдвэр болон шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хувийн хэрэгтэй танилцах зэргээр дүн шинжилгээ хийхэд нэг нь газрын маргаан, гурав нь төрийн албан хаагчийг ажлаас үндэслэлгүй халсантай холбоотой, нэг нь нийтийн эзэмшлийн зориулалттай газарт барилга байгууламж барьсан холбоотой маргаан байв. Эдгээр маргааныг гол агуулгын

хувьд нь авч үзвэл газрын маргааны тухайд нэхэмжлэгчийн газар эзэмших эрхийн хугацааг сунгахдаа түүний эзэмшиж байсан газрын хэмжээг багасгасан, төрийн албан хаагчийг ажлаас үндэслэлгүй халсантай холбоотой гурван маргааны тухайд нэг дэх нь шүүхийн шийдвэрийн дагуу төрийн албан хаагчийг ажлаас нь үндэслэлгүйгээр чөлөөлсөн тушаалаа хүчингүй болгосон боловч удалгүй дахин ажлаас нь чөлөөлсөн тушаал гаргасан, хоёр дахь нь төрийн албан хаагчийн цол, зэргийг бууруулж ажилд томилсон, гурав дахь нь төрийн албан хаагчийг өмнөх албан тушаалаас нь бууруулж ажилд томилсон тохиолдлууд байв. Сүүлийн барилгын маргааны тухайд нийтийн эзэмшлийн газрыг чөлөөлж, тус газарт баригдсан барилга байгууламжийг нураах шүүхийн шийдвэр гарсан боловч шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, шийдвэр гүйцэтгэгч тус шүүхийн шийдвэр биелэгдсэн гэж үзсэн боловч нэхэмжлэгчийн талаас шийдвэр бүрэн гүйцэд биелэгдээгүй хэмээн маргасан ч эцэст нь нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсанаар хэрэг дуусгавар болсон агуулгатай байв.

Эдгээр маргаанд нийтлэг ажиглагдаж байгаа шинж нь захиргааны байгууллага шүүхийн шийдвэрийг бүрэн гүйцэд, хууль ёсны дагуу биелүүлэхгүй, нэхэмжлэгчийн эрх, ашгийг дахин зөрчиж буй явдал юм.

Хоёрдугаарт, захиргааны хэргийн шүүхийн шийдвэр биелэгдэхгүй байгаа шалтгаан, үндэслэлд дүгнэлт хийж үзэхэд а) Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо, түүний харьяаллын хувьд асуудалтай, б) Шүүхийн шийдвэрийг зохих ёсоор биелүүлэхгүй байгаа захиргааны байгууллагад оногдуулах хариуцлагын талаарх зохицуулалт хангалтгүй бөгөөд үр нөлөө бага байдагтай холбоотой гэж дүгнэж болно.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо, түүний харьяаллын хувьд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь гүйцэтгэх эрх мэдлийн харьяа, Хууль зүй, дотоод

хэргийн яамны харьяа агентлагийн статустай байдаг тул төрийн өндөр дээд албан тушаалтан болон төрийн захиргааны төв байгууллага зэрэг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас дээд шатны захиргааны байгууллагын эсрэг шаардлага хүргүүлж ажиллахад бэрхшээлтэй байдаг.

Нөгөө талаас шүүхийн шийдвэрийг зохих ёсоор биелүүлэхгүй байгаа захиргааны байгууллагад оногдуулах хариуцлагын талаарх зохицуулалт хангалтгүй бөгөөд үр нөлөө бага гэдэг нь ИШГТХ-ийн 132 дугаар зүйлд зааснаар шийдвэр гүйцэтгэгч нь захиргааны байгууллагад шүүхийн шийдвэрийг биелүүлэх тухай хугацаатай мэдэгдэл хүргүүлэхээс өөр арга хэмжээ авах боломжгүй юм. ЗтХ-д заасан “Шүүхийн шийдвэрийг үл биелүүлэх тухай” зөрчилд захиргааны байгууллага, албан тушаалтан шүүхийн шийдвэрийг үл биелүүлсэн, зохих ёсоор биелүүлэхгүй байгаа тохиолдолд хүлээлгэх хариуцлагын талаар зохицуулаагүй (ЗтХ-ийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Төрийн албан тушаалтны шийдвэрийг үл биелүүлэх, үйл ажиллагаанд нь саад учруулах” зөрчлийг хуульчилсан бөгөөд үүнд шүүхийн шийдвэр гүйцэтгэгч хамаарах тул шаардлагыг нь үл биелүүлсэн захиргааны байгууллага, албан тушаалтныг торгох боломжтой хэдий ч үнийн дүн бага, үр нөлөө багатай), мөн зөрчлийн хариуцлагаас төрийн албан хаагч чөлөөлөгддөг буюу хариуцлага хүлээхгүй байна. ЭХ-д захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлтэй холбоотой зохицуулалт байхгүй гэж үзэх үндэстэй. Харин өмнөх 2002 оны Эрүүгийн хууль, Захиргааны хариуцлагын хуульд өнөөгийн хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалтаас давуу талтай нь санаатайгаар шүүхийн шийдвэр биелүүлэхгүй байгаа, санаатайгаар зайлсхийдэг үйлдэлд хариуцлага хүлээлгэх зохицуулалт тусгагдсан явдал байв.

Захиргааны хэргийн шүүхээс алдаатай, хууль бус гэж тогтоогдсон актыг удаа дараа гаргаж, иргэд хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчдөг үйлдэл байгаа ч

тодорхой хариуцлага хүлээдэггүй. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас дахин гаргасан алдаатай захиргааны актыг шийдвэр биелсэнд тооцож шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгодог, иргэний хэргийн шүүхээс захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг биелэгдсэн эсэхэд бус хэлбэрийн төдий шийдвэр биелүүлсэн эсэхэд илүү анхаарч хэргийг шийдвэрлэж буй нь эцсийн үр дүндээ иргэд, хуулийн этгээдийн эрх, ашиг сонирхол зөрчигдөх, цаг хугацаа, эдийн засгаар хохирох олон эрсдэлийг дагуулдаг.

Дээрх нөхцөл байдлаас шалтгаалж Монгол Улсад захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн биелэлт тун хангалтгүй хэрэгжиж байна. Энэ нь иргэдийн зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд шүүхийн хяналтыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй дагнасан шүүхийн ач холбогдол, үр нөлөөг сулруулж байна. Иймд дээрх нөхцөл байдлаас гарах, захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн хэрэгжилт, үр нөлөөг дээшлүүлэхийн тулд дараах хэдэн саналыг дэвшүүлэх боломжтой. Үүнд:

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагыг шүүх эрх мэдлийн дор харьяалуулах. Ингэснээр шүүх гаргасан шийдвэрийнхээ биелэлтэд шууд хяналт тавьж ажиллах боломжтой болно. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийг Засгийн газрын харьяа агентлаг хариуцаж байгаа нь төрийн эрх мэдэл хуваарилах талаасаа ч, практикт үүсэж буй хүндрэлүүдээс харахад шүүхийн шийдвэр биелэгдэхгүй байгаа үндсэн шалтгаан болж байна. Гүйцэтгэх эрх мэдэл өөрөө өөртөө шаардлага тавьж, шүүхийн шийдвэрийг биелүүлнэ гэдэг нь өнөөгийн Монгол Улсын төрийн алба, захиргааны байгууллагуудын эрх зүйн соёл, ухамсар, төлөвшилд нийцэхээргүй байна.
2. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад үүссэн маргааныг харьяаллын асуудлыг

судалж тодорхой болгох, шаардлагатай нөхцөлд захиргааны хэргийн шүүхэд харьяалан шийдвэрлүүлэх. Учир нь захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг биелсэн эсэхийг иргэний хэргийн шүүх хянаж байгаа нь зохимжгүй, мөн зарим талаараа иргэний хэргийн шүүх захиргааны хэргийн хүчин төгөлдөр шийдвэрийг үгүйсгэсэн, өөр шийдэл бүхий шийдвэр гаргах боломжтой нь энэхүү судалгааны хүрээнд дүн шинжилгээ хийсэн кейсээс тодорхой харагдсан. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад шинээр буюу дахин гаргасан захиргааны актын хууль ёсны байдлыг хянах, түүнийг хүчингүй болгох, захиргааны байгууллагын эс үйлдэхүйг хянаж, захиргааны акт гаргахыг даалгах зэрэг нь захиргааны хэргийн шүүхийн харьяалалд хамаарна.

3. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг үл биелүүлсэн, зохих ёсоор биелүүлэхгүй байгаа этгээдэд хүлээлгэх хариуцлагын арга хэмжээг чангатгах шаардлагатай. Тухайлбал харьцуулсан эрх зүйн судалгааны хэсэгт дурдагдсанаар анхан шатны шүүхээс шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй хожимдуулсан хугацаанд нь тохируулж, үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар тодорхой хэмжээний мөнгөн дүнг үүрэг гүйцэтгэгчээр төлүүлэхээр захирамжлах арга хэмжээ буюу шууд бус албадлагын арга хэмжээг хуульчлах нь зохимжтой. Ингэснээр захиргааны байгууллагын шүүхийн шийдвэрийг биелүүлэх сэдлийг нэмэгдүүлэх, хариуцлагыг өндөржүүлэх боломжтой.
4. ЗтХ-ийн 2.3-т шийтгэлээс чөлөөлөх үндэслэлийн дөрөв дэх хэсэгт тусгагдсан төрийн албан хаагчийг хариуцлагаас чөлөөлөх зохицуулалтыг хүчингүй болгох. Энэхүү зохицуулалт нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан тэгш байдлын зарчмыг зөрчсөн агуулгатай зохицуулалт юм.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Монгол Улсын хууль, тогтоомж

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992.
2. Хүний эрхийн түгээмэл тунхаглал (олон улсын гэрээ, хэлэлцээр)
3. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2002.
4. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2016.
5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, 2002.
6. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, 2017.
7. Зөрчлийн хууль, 2017.
8. Захиргааны хариуцлагын тухай хууль, 1992.
9. Эрүүгийн хууль, 2002.
10. Эрүүгийн хууль, 2017.
11. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2002.
12. Монгол Улсын Шүүхийн тухай хууль, 2021.

УДШ-ийн хууль тайлбарласан тогтоол

1. УДШ-ийн 2003.05.05-ны өдрийн 11 дүгээр “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг тайлбарлах тухай” тогтоол
2. УДШ-ийн 2007.11.29-ний өдрийн 43 дугаар “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг тайлбарлах тухай” тогтоол
3. УДШ-ээс 2006.07.03-ний өдрийн 37 дугаар “Захиргааны хэрэг

хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл, заалтыг
тайлбарлах тухай” тогтоол

Эрдэм шинжилгээний өгүүлэл, ном сурах бичиг

1. Г.Банзрагч, Эрх зүйт төр буюу захиргааны шүүх, Шүүх эрх мэдэл сэтгүүл, УБ., 2014/02.
2. Дэлхийн банк, ХЗҮХ, “Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны төлөвшил /судалгааны тайлан/” хүрээнд, УБ., 2008.
3. Ц.Цогт, Монгол Улсын Захиргааны хэргийн шүүхийн эрх зүйн орчин, дүн шинжилгээ, УБ., 2017.
4. Ц.Цогт, Захиргааны шинэтгэл ба захиргааны хэргийн шүүх, Хүний эрх сэтгүүл, УБ., 2012.01.
5. А.Эрдэнэцогт, Монгол Улсын Захиргааны процессын эрх зүй, УБ., 2006.
6. Д.Сандаг, ИШШГЕГ-ын албан сургалт, дадлагын хэлтсийн мэргэжилтэн, дэслэгч “Газартай холбоотой шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт” Газартай холбоотой хүний эрхийн асуудал онол, практикийн бага хурлын илтгэлүүдийн эмхэтгэл, УБ., 2015. https://www.amnesty.mn/~amnestym/images/2020/05/AIM_online_book_final.pdf
7. ХЗҮХ, ШЭЗШ төсөл, Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн үр дагавар, УБ., 2005.
8. Шүүгч Д.Батбаатарын танилцуулга, Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх ажиллагаа, <http://resource3.sodonvision.com/>
9. Д.Лхагвасүрэн, Д.Энхтуяа, Захиргааны хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, УБ., 2016.
10. ИШШГЕГ-ын Шийдвэр гүйцэтгэлийн албаны статистик мэдээ.
11. НШГА-ны Захиргааны хэргийн шийдвэр гүйцэтгэлийн статистик мэдээ.
12. Б.Эрдэнэ-Очир, ХСИС-ийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн

- процессын эрх зүйн тэнхимийн багш, ахмад “Захиргааны шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд тулгамдаж буй асуудал” Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлал, УБ., 2013.
13. Э.Мөнхдаваа, МУИС-ийн ХЗС-ийн Нийтийн эрх зүйн тэнхимийн багш “Захиргааны шүүхийн шийдвэр гүйцэтгэлд анхаарах асуудал” Шүүх эрх мэдэл, УБ., 2017/03.
 14. Л.Өлзийжаргал, Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн хэрэгжилт, тулгамдсан асуудал, <http://www.niislel.cd.gov.mn/content/9100.shtml?sel=257>
 15. Т.Азжаргал, Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэл, тулгамдсан асуудал, УБ., 2019, <https://legaldata.mn/buteel/pdf?id=1131>
 16. 和田吉弘『基礎からわかる民事執行法・民事保全法【第2版】』（弘文堂、2010年, Вада Ёсихиро, Үндэс сууриас нь ойлгох Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тухай хууль, Иргэний хэргийн шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээний тухай хууль, 2 дахь хэвлэл, 2010.
 17. Япон Улсын “Эдийн засаг” сонины 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн “Исахая тэнгисийн буланг газар тариалангийн зориулалттай газар болгохтой холбоотой үүссэн маргааныг эхнээс нь сайн ойлгох нь” гарчигтай нийтлэлээс хураангуйлан оруулав.
 18. 宮澤俊昭「間接強制金の法的性質についての一考察」—諫早湾干拓紛争におけるいくつかの問題をきっかけとして—Миязава Тошиаки “Шууд бус албадлагын арга хэмжээний эрх зүйн мөн чанарын талаарх эргэцүүлэл дүн шинжилгээ” Исакхая тэнгисийн буланг газар тариалангийн зориулалттай газар болгохтой холбоотой үүссэн маргаан дахь хэд хэдэн асуудлыг үндэслэх нь эрдэм шинжилгээний өгүүлэл, 2020 оны 3 дугаар сар.

Шүүхийн шийдвэр

1. Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2010.04.16-ны өдрийн 180 дугаар шийдвэр
2. УДШ-ийн (захиргааны танхим) 2010.06.21-ний өдрийн 172 дугаар тогтоол
3. Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 101/ШШ2016/03595 дугаар шийдвэр
4. Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2016.06.20-ний өдрийн 1192 дугаар магадлал
5. Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүгчийн 2016.08.30-ны өдрийн 579 дугаар захирамж
6. Нийслэлийн Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2007.07.30-ны өдрийн 191 дүгээр шийдвэр
7. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2007.09.18-ны өдрийн 167 дугаар магадлал
8. УДШ-ийн (захиргааны танхим) 2007.11.12-ны өдрийн тогтоол
9. Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016.10.18-ны өдрийн 181/ШШ2016/01002 дугаар шийдвэр
10. Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017.01.27-ний өдрийн 290 дугаар магадлал
11. УДШ-ийн (иргэний танхим) 2017.04.18-ний өдрийн 461 дүгээр тогтоол
12. Захиргааны хэргийн анхан шатны 20 дугаар шүүхийн 2014.07.17-ны өдрийн 336 дугаар шийдвэр
13. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2014.09.25-ны өдрийн 388 дугаар магадлал
14. УДШ-ийн 2014.11.17-ны өдрийн 265 дугаар тогтоол
15. Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2015.11.17-ны өдрийн 7809 дугаар шийдвэр

16. Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018.03.30-ны өдрийн 628 дугаар шийдвэр,
17. Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018.06.08-ны өдрийн 1347 дугаар магадлал
18. УДШ-ийн 2018.11.01-ний өдрийн 1541 дүгээр тогтоол
19. Нийслэлийн Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2011.01.28-ны өдрийн 42 дугаар шийдвэр
20. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2011.03.23-ны өдрийн 110 дугаар магадлал
21. УДШ-ийн 2011.05.30-ны өдрийн 120 дугаар тогтоол
22. Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шүүхийн 2011.12.30-ны өдрийн 13 дугаар шийдвэр
23. Төв аймгийн Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2010.12.07-ны өдрийн 17А шийдвэр,
24. Улсын дээд шүүхийн 2011.02.17-ны өдрийн 47 дугаар магадлал
25. Улсын дээд шүүхийн 2011.04.18-ны өдрийн 78 дугаар тогтоол
26. Төв аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2019.10.15-ны өдрийн 1052 дугаар шийдвэр
27. Захиргааны хэргийн анхан шатны 20 дугаар шүүхийн 2015.05.05-ны өдрийн 0259 дүгээр шийдвэр
28. Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017.07.26-ны өдрийн 2030 дугаар шийдвэр
29. Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2021.01.26-ны өдрийн 62 дугаар шийдвэр
30. Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2017.11.29-ний өдрийн 887 дугаар шийдвэр
31. Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2019.07.22-ны өдрийн 1566 дугаар шийдвэр
32. Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2019.10.24-ний өдрийн 0724 дүгээр шийдвэр
33. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2019.12.31-ний өдрийн 21 дүгээр магадлал

2

ЗАХИРГААНЫ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХҮҮЛИЙН “ХАНГАЛТТАЙ СОНИРХОЛ ИЛЭРХИЙЛСЭН БАЙХ” ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭРЭГЛЭЭ

СУДЛААЧДЫН ТАНИЛЦУУЛГА



СҮХБААТАРЫН СҮХЧУЛУУН

2009-2014 онд МУИС-ийн Хууль зүйн сургуульд эрх зүйн бакалавр, 2015-2017 онд Япон Улсын Нагояагийн Их сургуульд “Байгаль орчны бохирдолтой хэрэг дээр эрх зөрчсөн үйлдлийг таслан зогсоох нэхэмжлэл гаргах боломж, шаардлага” сэдвээр магистрын зэрэг хамгаалсан. 2014-2015 онд МУ-ын Үндсэн хуулийн цэцийн Тамгын газарт шинжээч, Судалгааны төвийн судлаачаар ажиллаж байсан туршлагатай. Одоогоор Нагояагийн Их сургуульд хүрээлэн буй орчны эрх зүй, захиргааны процессын эрх зүйн чиглэлээр докторын судалгааны ажил бичиж буй.

Судлаач:

С.Сүхчулуун (LL.M)

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	89
УДИРТГАЛ.....	90
НЭГ. ХУУЛЬ ТОГТООГЧИЙН ҮЗЭЛ САНАА	92
ХОЁР. ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ	97
2.1. Шүүхийн шийдвэрийн төлөөлөх чадвар.....	97
2.2. Шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ.....	98
Дүн шинжилгээ 1. Иргэн нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй эсэхийг шийдвэрлэсэн хэрэг	98
Дүн шинжилгээ 2. “Хангалттай сонирхол илэрхийлсэн байх” зохицуулалтыг хэлбэрийн төдий үнэлсэн хэрэг .	104
Дүн шинжилгээ 3. “Хангалттай сонирхол илэрхийлсэн байх” зохицуулалтыг “нийтийн ямар ашиг сонирхол хэрхэн зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй” гэсэнтэй хамтад нь үнэлж буй хэрэг	109
Дүн шинжилгээ 4. “Хангалттай сонирхол илэрхийлсэн байх” зохицуулалтыг үнэлэхгүй байгаа хэрэг.....	113
НЭГДСЭН ДҮГНЭЛТ	118
АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ.....	120
ХАВСРАЛТ	125

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АМГТТГКХ	Ашигт малтмал газрын тосны газрын Кадастрын хэлтэс
ДГА	Дорноговь аймаг
ЗД	Засаг дарга
ЗХХШтХ	Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (2002.12.26)
ЗХШХШтХ	Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (2016.02.04)
НҮТББ	Нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага
ТББ	Төрийн бус байгууллага
УДШ	Улсын Дээд шүүх
УИХ	Улсын Их Хурал
ХЗБХ	Хууль зүйн байнгын хороо

УДИРТГАЛ

2016 оны 2 дугаар сарын 4-ний өдөр Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (цаашид ЗХШХШтХ гэх)-ийн шинэчилсэн найруулга батлагдаж, мөн оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс мөрдөгдөж байна. Тус хуулийн 52 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт “Энэ хуулийн 52.2.4-т заасан нэхэмжлэлийн шаардлага, түүний үндэслэлд дараах зүйл хамаарна: 52.5.5 нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргаж байгаа этгээдийн хувьд маргаж буй асуудлын талаар хангалттай сонирхол илэрхийлсэн байх бөгөөд нийтийн ямар ашиг сонирхол хэрхэн зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй” гэж заажээ.

Энэхүү судалгаа нь дээрх “хангалттай сонирхол илэрхийлсэн байх” зохицуулалтын талаарх хууль тогтоогчийн үзэл санаа¹ болон шүүхийн шийдвэр дэх тус зохицуулалтын хэрэглээ хоорондын харилцан хамаарлыг илрүүлэх зорилготой юм.

ЗХШХШтХ-ийн 18 дугаар зүйлд зааснаар хуулиар тусгайлан эрх олгогдсоноос бусад нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд нь хүрээлэн байгаа орчин, хүүхдийн эрх, нийтийн эрүүл мэнд, нийтийн өмчийг хамгаалах асуудлаар

¹ Энд “хууль тогтоогчийн үзэл санаа” гэдэгт хуулийн төсөл хэлэлцүүлэх үе шатанд гарч байсан зарчмын зөрүүтэй санал зэргийг судалж, хууль тогтоогч ямар агуулгаар “хангалттай сонирхол илэрхийлсэн байх” гэсэн томъёололд хүрсэн талаарх үндэслэл, тайлбар зэргийг багтаасан болно.

шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй. Энэ нь мөн хуулийн 52.5.5 дахь заалтын “хангалттай сонирхол илэрхийлсэн байх” зохицуулалттай салшгүй холбоотой. Энэ чиглэлээр цөөнгүй судалгааны бүтээл гарсан байдаг (Хавсралт 1-ийг үзнэ үү). Захиргааны эрх зүйн сурах бичигт “хангалттай сонирхол илэрхийлсэн байх” зохицуулалтын тухайд зөвхөн дурдагдах төдий байдлаар хязгаарлагдаж байна.²

Дээрх судалгааны бүтээлийн ихэнх нь нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргахтай холбоотой онолын үзэл санаа болон шүүхийн практикийг илрүүлэх чиглэлээр хийгджээ. Харин “хангалттай сонирхол илэрхийлсэн байх” зохицуулалтын талаарх хууль тогтоогчийн үзэл санаа болон шүүхийн шийдвэрт хэрэглэгдэж буй байдал, тэдгээрийн харилцан холбоог тухайлан судалсан судалгааны бүтээл хараахан байхгүй байна.

² Г.Банзрагч бүтээлдээ нийтийн эрх ашгийг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхтэй этгээдийн нэхэмжлэлийн шаардлагын хүрээ нь хүрээлэн буй орчин, хүүхдийн эрх, нийтийн эрүүл мэнд, нийтийн өмчийг хамгаалах асуудлын аль нэг нь байхыг тэмдэглэжээ. Мөн ЗХШХШТХ-ийн 106.3.10-д нийтийн эрх ашгийг төлөөлөн нэхэмжлэл гаргах харилцаанд нэхэмжлэлийн төрлөөр хязгаарлалт тогтоосон нь оновчгүй гэж дүгнэжээ. Г.Банзрагч, Захиргааны процессын эрх зүй, УБ., 2019, 226-227 дахь тал (ISBN 978-9919-22-620-6). Тус бүтээлийн 227 дахь талд “... хангалттай ашиг сонирхол илэрхийлсэн байх...” гэж бичсэн нь бичиглэлийн алдаатай болжээ. Засах хувилбар нь “...хангалттай сонирхол илэрхийлсэн байх...” юм.

НЭГ. ХУУЛЬ ТОГТООГЧИЙН ҮЗЭЛ САНАА

ЗХШХШТХ-ийн төслийг хэлэлцэх үе шатанд “хангалттай ашиг сонирхлыг илэрхийлсэн байх”; “хангалттай сонирхолтойгоо илэрхийлсэн байх” зэрэг томъёоллыг хэлэлцэж, эцэст нь “хангалттай сонирхол илэрхийлсэн байх” гэсэн томъёоллоор баталжээ. Хууль тогтоогчийн үзэл санааг тодруулахын тулд хуулийн төслийн хэлэлцүүлэгтэй холбоотой УИХ-ын нэгдсэн хуралдаан болон холбогдох байнгын хорооны хуралдааны тэмдэглэлд тулгуурлан судлав (Хавсралт 2-ыг үзнэ үү). Энэхүү асуудлыг хуулийн төслийг хэлэлцэх үе шатаар нь буюу 2.1) хуулийн төслийг хэлэлцэх эсэх; 2.2) хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг; 2.3) хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэг, батлах үе шатанд “хангалттай сонирхол илэрхийлсэн байх” зохицуулалтын талаарх зарчмын зөрүүтэй санал, хэлэлцэгдсэн тайлбар зэрэгт авч үзсэн болно.

1.1. ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ

Энэ үе шатанд “хангалттай сонирхол илэрхийлсэн байх” зохицуулалтын талаар тодорхой зарчмын зөрүүтэй санал, хэлэлцүүлэг өрнөөгүй билээ. Харин хуулийн төсөлд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхийг нээлттэй болгож буй шалтгаан, түүнчлэн уг эрхийг иргэнд бус, харин

төрийн бус байгууллагад хадгалагдахаар хууль санаачлагч тусгасан нь тухайн нийтийн эрх ашигтай холбоотой асуудлаар илүүтэй мэргэшсэн, боловсон хүчин, суурь мэдээллээр хангагдсан төрийн бус байгууллага гэх бүтцэд өгөх нь илүү ач холбогдолтой гэх үндэслэлээр оруулсан зэргийн талаар хэлэлцүүлэг өрнөжээ (Хавсралт 3; 4-ийг үзнэ үү).

1.2. ХУУЛИЙН ТӨСЛИЙН АНХНЫ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

ХЗБХ-ны хуулийн төслийн анхны хэлэлцүүлгээр төслийн 52 дугаар зүйлийн 52.5.5 дахь заалтын “хангалттай ашиг сонирхлыг илэрхийлсэн байх” гэснийг “маргаж буй асуудлын талаар хангалттай сонирхолтойгоо илэрхийлсэн байх” гэж өөрчилж, 14 гишүүний 13 нь буюу 92.9 хувиар дэмжжээ.³ Тус хэлэлцүүлгийн үеэр хуулийн төсөлд “хангалттай ашиг сонирхлыг илэрхийлсэн байх” гэсэн томъёоллыг “маргаж байгаа асуудлын талаар хангалттай сонирхолтойгоо илэрхийлсэн байх” болгон “ашиг” гэдэг үгийг хасаж, “сонирхолтойгоо” хэмээн хамаатуулах агуулгатайгаар өөрчилжээ.

Дээрх ХЗБХ-ны хуралдааны үеэр УИХ-ын гишүүн Р.Гончигдорж “сонирхолтойгоо” гэсэн томъёолол нь нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах төрийн бус байгууллагад тухайн маргаж буй асуудлаар өөрийнх нь эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн байхыг шаардах агуулгатай болох тул эсрэг байгаа болохоо илэрхийлжээ (Хавсралт 5-ыг үзнэ үү). Мөн Ц.Оюунгэрэл гишүүн нь нэхэмжлэгч ТББ нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргахад тухайн ТББ-ын

³ Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2016 оны 1 дүгээр сарын 20-ны өдөр (Лхагва гараг)-ийн хуралдааны тэмдэглэл, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай (шинэчилсэн найруулга) болон холбогдох бусад хуулийн төсөл (Засгийн газар 2015.12.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг), 43-44 дэх тал. <http://www.parliament.mn/n/dweo> 2022.04.27-ны өдрийн хандалт.

хувийн эрх ашиг заавал хөндөгдсөн байхыг шаардахгүй байх нь зүйтэй гэсэн байр суурийг илэрхийлжээ (Хавсралт 5-ыг үзнэ үү). Хэрэв “хангалттай сонирхолтойгоо илэрхийлэх” гэсэн томъёоллоор батлагдсан бол тухайн нэхэмжлэгч ТББ зөвхөн өөрт хамааралтай өөрийн ашиг сонирхолтой холбоо бүхий асуудлаар л нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхтэй гэж ойлгогдох магадлалтай байсан тул тус томъёолол дэмжигдээгүй гэж дүгнэхээр байна.

Мөн хуралдааны үеэр Ж.Батзандан гишүүний зүгээс нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрх бүхий этгээд нь тухайн нэхэмжлэл гаргахдаа хуульд заасан хоёр үндсэн шаардлагыг чухам хэрхэн хангаж буйгаа тодорхойлон нэхэмжлэлийн шаардлагадаа тодорхой дурдсан байх ёстой бөгөөд энэ нь “хангалттай сонирхол илэрхийлсэн байх” гэсэн шаардлагатай холбогдоно гэсэн байр суурийг илэрхийлжээ (Хавсралт 5-ыг үзнэ үү).

Хуулийн төслийн ажлын хэсгийн гишүүн хуульч Ц.Цогт (тухайн үед Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч) нийтийн эрх ашгийг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрх нь тусгай хуулиар олгогдоогүй этгээдийн хувьд хуульд заасан хоёр шаардлагыг хангасан байхыг шаардах бөгөөд энэ тохиолдолд нэхэмжлэгч нь нэхэмжилж буй асуудлаараа өөрөө үйл ажиллагаа явуулдаг байх зэргээр өөрт тодорхой хангалттай ашиг сонирхол буйгаа илэрхийлсэн байх ёстойг шаардана гэсэн агуулгатай болохыг дурджээ (Хавсралт 5-ыг үзнэ үү). Энэ нь хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсэгт заасан хуулиар тусгайлан эрх олгогдсоноос бусад нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд хуульд заасан хоёр үндсэн шаардлагыг хэрхэн хангаж буй талаар нэхэмжлэлдээ тодорхой дурдаж өгөх нь ЗХШХШТХ-ийн 52 дугаар зүйлийн 52.5.5 дахь заалтын “хангалттай сонирхол илэрхийлсэн байх” гэсэн шаардлагыг хангасан эсэхийг тогтооход үйлчлэх ёстой гэсэн санаа хэмээн дүгнэж болох юм.

Үүний дараа 2016 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн УИХ-ын нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг үргэлжилсэн бөгөөд хэлэлцүүлгийн төгсгөлд төслийн 52.5.5 дахь заалтын “хангалттай ашиг сонирхлыг илэрхийлсэн байх” гэснийг “маргаж буй асуудлын талаар хангалттай сонирхол илэрхийлсэн байх” гэж өөрчилж, 79.5 хувийн саналаар дэмжигджээ.⁴

Дүгнэвэл ЗХШХШТХ 52.5.5 дахь заалтын “хангалттай сонирхол илэрхийлсэн байх” зохицуулалтын хууль тогтоогчийн үзэл санааг дараах хоёр агуулгаар тодорхойлж болно.

Нэгдүгээрт, нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд буюу тус хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсэгт заасан хоёр үндсэн шаардлагыг хангасан төрийн бус байгууллага нь тухайн нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргаж буй асуудлын улмаас өөрийнх нь эрх, ашиг сонирхол зөрчигдсөн байхыг шаардахгүйгээр захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрх нь нээлттэй байх ёстой.

Хоёрдугаарт, тус хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсэгт заасан хоёр шаардлагыг нэхэмжлэгч төрийн бус байгууллага хэрхэн хангасан болон маргаж буй нийтийн ашиг сонирхлын асуудлаар тус нэхэмжлэлийг гаргах ямар ашиг сонирхол байгааг тодорхой дурдсан байх нь ЗХШХШТХ 52.5.5 дахь заалтын “хангалттай сонирхол илэрхийлсэн байх” шаардлагыг хангасан гэж үзэх үндэслэл болох боломжтой гэсэн санаа юм.

⁴ Улсын Их Хурлын 2015 оны намрын ээлжит чуулганы 2016 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн нэгдсэн хуралдааны тэмдэглэл, 10-11 дэх тал. <http://www.parliament.mn/n/saeo> 2022.04.27-ны өдрийн хандалт.

1.3. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ЭЦСИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ, БАТЛАХ

Хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэг, батлах үе шатанд Р.Гончигдорж гишүүний зүгээс хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг дээр дурдсан асуудал буюу 52.5.5 дахь заалтын “хангалттай сонирхол илэрхийлсэн байх” гэсэн томъёолол хэрхэн тусгагдаж буй талаар лавлажээ. Улсын Дээд шүүхийн шүүгч М.Батсуурь хариулахдаа анхны хэлэлцүүлэг дээрх Р.Гончигдорж гишүүний саналыг тусгаж, ашиг сонирхол гэдгийн “ашиг” гэдэг үгийг аваад “нийтийн асуудлаар сонирхолтойгоо илэрхийлсэн байх” гэсэн томъёолол болгон оруулсан болохоо дурджээ (Хавсралт 7-г үзнэ үү).

Дээрхийг нэгтгэн дүгнэвэл ЗХШХШтХ-ийн “хангалттай сонирхол илэрхийлсэн байх” гэсэн томъёолол нь тухайн асуудлаар нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргаж буй ТББ-ын өөрийнх нь эрх, ашиг сонирхол зөрчигдсөн байхыг шаардахгүйгээр нэхэмжлэл гаргах эрхийг нээлттэй болгох нь зүйтэй гэдэг дээр хууль тогтоогчийн үзэл санаа нэгджээ. Мөн хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсэгт заасан хоёр шаардлагыг нэхэмжлэгч төрийн бус байгууллага хэрхэн хангаж буйгаа нэхэмжлэлдээ тусгах, тус нэхэмжлэлийг гаргах ямар ашиг сонирхол байгааг тусгах нь ЗХШХШтХ 52.5.5 дахь заалтын “хангалттай сонирхол илэрхийлсэн байх” зохицуулалттай холбогдоно гэсэн санааг хууль тогтоогч илэрхийлжээ.

ХОЁР. ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ

2.1. ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ТӨЛӨӨЛӨХ ЧАДВАР

Энэ хэсэгт “хангалттай сонирхол илэрхийлсэн байх” зохицуулалтыг шүүхийн шийдвэрт хэрхэн хэрэглэж буйг судлав. Дүн шинжилгээ хийх шүүхийн шийдвэрийг сонгохын тулд Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан (<https://shuukh.mn/>) түлхүүр үгээр хайх хэсэгт дараах хайлтыг хийсэн болно: “хангалттай сонирхол” түлхүүр үгээр нийт 2120 илэрц илэрсний ес, “нийтийн ашиг сонирхлыг” түлхүүр үгээр нийт 3480 илэрц байсны зургаан илэрц (дээрх есөн илэрцтэй давхардсан) нь ЗХШХШТХ-ийн “хангалттай сонирхол илэрхийлсэн байх” зохицуулалттай хамааралтай илэрц байв (Хавсралт 7-г үзнэ үү).⁵ Тус есөн илэрц нь тухайлбал нэг хэрэгт хамаарах бусад шатны шүүхийн шийдвэр тус тусдаа гарч ирсэн илэрц тул нийт таван хэргийн шүүхийн шийдвэрт хамаарна. Түүний дөрвөн хэргийн шүүхийн шийдвэрт шүүхээс “хангалттай сонирхол илэрхийлсэн байх” зохицуулалтыг хэрхэн хэрэглэж буй талаар дүн шинжилгээ хийлээ. Харин дүн шинжилгээнд багтаагүй нэг хэргийн шүүхийн шийдвэрийн хувьд “хангалттай сонирхол илэрхийлсэн байх” хуулийн зохицуулалтыг бичих төдийхнөөр хязгаарлагдсан байсан тул ач холбогдол багатай гэж үзсэн болно.

⁵ Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан <https://shuukh.mn>. Тус түлхүүр үгийн хайлтыг эцсийн байдлаар 2022.04.24-ний өдөр хийсэн болно.

2.2. ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ

ДҮН ШИНЖИЛГЭЭ 1. Иргэн нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй эсэхийг шийдвэрлэсэн хэрэг

а. Хэргийн агуулга

Нэхэмжлэгч нэр бүхий гурван иргэнээс Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2018 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 05 дугаар тогтоол, мөн сумын Засаг даргын 2018 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн А/70 дугаар захирамжийн зарим хэсэг болон 2018 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн А/95 дугаар захирамжийг тус тус хүчингүй болгуулах шаардлага бүхий нэхэмжлэл гаргажээ.

Нэхэмжлэгч нар нь хариуцагч захиргааны байгууллагын гаргасан маргаан бүхий шийдвэрүүд нь 2018 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй, иргэдийн оролцоог хангаж, санал, асуулга аваагүй газрыг “С” ХХК-ийн саналаар шуурхай хуралдан, үйлдвэрлэлийн зориулалтаар газар эзэмшүүлэх тогтоол гаргахдаа Монгол Улсын Үндсэн хууль, Газрын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Нийтийн сонсголын тухай хуулиуд болон бусад холбогдох тогтоомжийг судлах үүргээ бүрэн биелүүлээгүйгээс нийтлэг эрх ашиг болох эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх, түүнийг хамгаалуулах эрхүүд зөрчигдөхөд хүрээд байгаа тухайд нэхэмжлэлдээ тусгажээ.

б. Шүүхийн шийдвэрийн агуулга

Анхан шатны шүүхийн шийдвэр, агуулга

Анхан шатны шүүхээс нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ. Тодруулбал, “Монгол Улсын Засаг захиргаа,

нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.3, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2, 21 дүгээр зүйлийн 21.4.3, 33 дугаар зүйлийн 33.1.2, 33.4-т заасныг баримтлан А.Б, Т.Г, Г.Д нарын гаргасан “Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2018 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн 05 дугаар тогтоол, Шивээговь сумын Засаг даргын 2018 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн А/70 дугаар захирамжийн 1 дэх заалтын ... 2 дугаар багт 21 дүгээр зөрлөгийн баруун урд талд 22.5 га газрыг үйлдвэрлэлийн зориулалтаар эзэмшүүлэх ... хэсэг болон 2018 оны 7 дугаар сарын 02-ны өдрийн А/95 дугаар захирамжийг тус тус хүчингүй болгуулах” тухай шаардлага бүхий нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосугай” гэж шийдвэрлэжээ.

Давж заалдах шатны шүүхийн магадлал, агуулга

Давж заалдах шатны шүүхээс нэхэмжлэгч иргэдийн ямар эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн талаар тодруулахын зэрэгцээ уг зөрчигдсөн гэх эрх, ашиг сонирхолд хууль зөрчиж баталсан газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд оруулсан нэмэлт өөрчлөлт, түүнийг үндэслэн олгосон газар эзэмшүүлэх шийдвэрийн улмаас зөрчигдөх эсэх талаар холбогдох баримтыг цуглуулж, дүгнэлт хийж, хэргийг шийдвэрлэх шаардлагатай байх тул шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, хэргийн дахин хэлэлцүүлэхээр буцаасан байна⁷.

⁶ Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоол болон мөн сумын Засаг даргын захирамжийг тус тус хүчингүй болгуулах тухай Говьсүмбэр аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2019.01.08-ны өдрийн 113 ШШ2019/0001 дүгээршийдвэр (113/2018/0013/3), 12-13 дахь тал. Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан, https://shuukh.mn/single_case/4876?start_date=&end_date=&id=1&court_cat=3&bb=1 2022.04.27-ны өдрийн хандалт.

⁷ Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоол болон мөн сумын Засаг даргын захирамжийг тус тус хүчингүй болгуулах тухай Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2019.04.04-ний өдрийн 221/МА2019/0194 дугаар магадлал (113/2018/0013/3), 4 дэх тал. Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан, https://shuukh.mn/single_case/2729?start_date=&end_date=&id=2&court_cat=3&bb=1 2022.04.27-ны өдрийн хандалт.

Улсын Дээд шүүхийн тогтоол, агуулга

Улсын Дээд шүүхээс Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2019 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн 221/МА2019/0194 дүгээр магадлалыг хүчингүй болгож, Говьсүмбэр аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн 113/ШШ2019/0001 дүгээр шийдвэрийг хэвээр үлдээхээр шийдвэрлэжээ⁸.

в. Дүн шинжилгээ

Энэ хэргийн хувьд ЗХШХШТХ-ийн дагуу нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд нь иргэн байж болох эсэх маргаан үүссэн байдаг.

Анхан шатны шүүхийн шийдвэрт “нийтийн эрх ашгийг төлөөлөх эрх бүхий этгээд гэдэгт Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3, 18.3.1, 18.3.2-т зааснаар “нэхэмжлэлийн шаардлага нь тухайн байгууллагын дүрмийн зорилгод нийцсэн, дүрмийн дагуу сүүлийн гурваас доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан” төрийн бус байгууллагыг ойлгох тул нэхэмжлэл гаргасан иргэд энд хамаарахгүй” гэж дүгнэсэн.⁹ Мөн нэхэмжлэгч нарын хувьд “сумын иргэдийг төлөөлөх эрхийг илэрхийлсэн итгэмжлэлийг ирүүлээгүй тул тэдний нэрийн өмнөөс нэхэмжлэл гаргах боломжгүй”, “маргаан бүхий газартай эзэмшиж буй газар нь давхацсан зэргээр газар эзэмшигчийн эрх зөрчигдөөгүй, ... А.Б, Г.Д нарын маргаан бүхий газар байрлах Шивээговь сумын 2 дугаар багт оршин суудаггүй зэрэг үйл баримт хэрэгт цутлуулсан

⁸ Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоол болон мөн сумын Засаг даргын захирамжийг тус тус хүчингүй болгуулах тухай Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны 2019.06.19-ний өдрийн 221 дугаар тогтоол (113/2018/0013/3), тал 7. Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан, https://shuukh.mn/single_case/1949?start_date=&end_date=&id=3&court_cat=3&bb=1 2022.04.27-ны өдрийн хандалт.

⁹ Өмнөх эшлэл (6) 10 дахь тал.

бичгийн нотлох баримтаар тогтоогдсон¹⁰” гэж заажээ.

Харин давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн шийдвэртэй эсрэг байр суурьтай байв. Магадлалд “Шүүх нэхэмжлэгч нарыг нийтийн эрх ашгийг хамгаалах эрхгүй, бусдыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхгүй гэж үзэж, иргэнийх нь хувьд эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдөөгүй гэж дүгнэсэн нь үндэслэл муутай болжээ”; “... сумын иргэнийхээ хувьд эрүүл аюулгүй орчинд амьдрах, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхээ заавал бусад иргэнтэй нэгдэж нийтийн эрх ашгийг хамгаалах эрх бүхий этгээдээр нэхэмжлэл гаргуулан хамгаалах хязгаарлалт хуульд байхгүй”¹¹ гэж үзжээ.

Давж заалдах шатны шүүхийн магадлалын дээрх үндэслэлтэй Улсын Дээд шүүх санал нийлээгүй юм. Ингэхдээ, “Учир нь, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нэхэмжлэгч нар нь “нийт сумын иргэдийг төлөөлөн нэхэмжлэл гаргаж байна” гэж тайлбарлаж байжээ”¹² гэдгийг голлох үндэслэл болгожээ. Мөн тогтоолд “Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3-т “Хуулиар тусгайлан эрх олгогдсоноос бусад нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд нь хүрээлэн байгаа орчин, хүүхдийн эрх, нийтийн эрүүл мэнд, нийтийн өмчийг хамгаалах асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй бөгөөд уг этгээд дараах шаардлагыг хангасан байна” гэж, 52 дугаар зүйлийн 52.5.5-д “нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргаж байгаа этгээдийн хувьд маргаж байгаа асуудлын талаар хангалттай сонирхол илэрхийлсэн байх бөгөөд нийтийн ямар ашиг сонирхол хэрхэн зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй” гэж нийтийн эрх ашгийг төлөөлөн нэхэмжлэл гаргах харилцааг тусгайлан зохицуулсан бөгөөд нэхэмжлэгчийн “сумын иргэдийн

¹⁰ Өмнөх эшлэл (6) 12 дахь тал.

¹¹ Өмнөх эшлэл (7) 3 дахь тал.

¹² Өмнөх эшлэл (8) 5 дахь тал.

эрхийг төлөөлөн нэхэмжлэл гаргаж байгаа” гэх тайлбар нь хуулийн дээрх заалтад нийцэхгүй, энэ талаарх анхан шатны шүүхийн дүгнэлт үндэслэл бүхий болжээ”¹³ гэсэн байна.

Ийнхүү дүгнэвэл, анхан шатны шүүх болон УДШ-ээс ЗХШХШТХ-ийн дагуу захиргааны хэргийн шүүхэд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд гэдэгт иргэн хамаарахгүй гэсэн байр суурийг илэрхийлжээ. Харин давж заалдах шатны шүүхээс тус хэргийн хувьд нэхэмжлэгч иргэд хувь иргэнийхээ зүгээс нийтийн ашиг сонирхолтой холбоотой асуудлаар нэхэмжлэл гаргах хязгаарлалт хуульд тусгагдаагүй тул нэхэмжлэл гаргах эрхтэй гэж үзсэн байна.

Хүчин төгөлдөр үйлчилж буй ЗХШХШТХ-ийн 3.1.9-д ““захиргааны хэргийн шүүхэд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд” гэж хуулиар эрх олгогдсон этгээд, энэ хуулийн 18.3-т заасан шаардлага хангасан төрийн бус байгууллагыг” ойлгохоор тусгажээ. Хуулийн зохицуулалтаас үзвэл нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд гэдэгт иргэн хамаарахгүй. Хууль тогтоогч нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээдээр иргэн бус, төрийн бус мэргэжлийн байгууллагад олгож буй шалтгаан нь түүний мэдээлэлтэй, туршлагатай, мэргэшсэн байдал зэргийг чухалчилсанд оршино (Хавсралт 3-ыг үзнэ үү).

Гэвч судлаач суурь тус хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлалд тэмдэглэсэн үндэслэлийг анхааралтай авч үзэх ёстой гэж үзэж байна. Магадлалд нэхэмжлэгч нэр бүхий иргэд “сумын иргэнийхээ хувьд эрүүл аюулгүй орчинд амьдрах, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхээ заавал бусад иргэнтэй нэгдэж нийтийн эрх ашгийг хамгаалах эрх бүхий этгээдээр нэхэмжлэл гарган хамгаалуулах хязгаарлалт хуульд байхгүй” гэсэн чухал дүгнэлт хийжээ.

ЗХШХШТХ-ийн дагуу нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх

¹³ Өмнөх эшлэл (8) 5 дахь тал.

эрх бүхий этгээд гэдэгт 1) хуулиар эрх олгогдсон этгээд, 2) хуулийн шаардлага хангасан төрийн бус байгууллага байхаар хуульчилжээ. Иргэн нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд биш болох нь хуульд тодорхой тусгагдсан гэж дүгнэж болно. Гэхдээ тухайн маргаан дээр хөндөгдөж буй ашиг сонирхол нь үнэхээр нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах зохицуулалтад хамаарах уу, эсхүл иргэн тухайн асуудлаар өөрийн эрх, ашиг сонирхолд хамааралтай байдлаар нэхэмжлэл гаргах боломжтой ашиг сонирхол уу гэдгийг шүүхээс нарийвчлан үнэлэх ёстой. Тухайн хэргийн маргааны зүйл нь нэг талаас нэхэмжлэгч иргэний эрх, ашиг сонирхлыг зөрчсөн, эсхүл зөрчих эрсдэл бүхий нөгөө талаас нийтийн ашиг сонирхолтой хамааралтай байж болох маргаан дээр тухайн асуудлаар нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх нь зөвхөн төрийн бус байгууллагад олгогдсон гэсэн үндэслэлээр иргэний нэхэмжлэлийг хүлээн авахгүй байх нь зохимжгүй юм.

Тухайн хэрэг дээр хөндөгдөж буй ашиг сонирхол нь үнэхээр нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах асуудалд хамаарах уу, эсхүл иргэн өөрийн эрх, ашиг сонирхлыг зөрчсөн гэх үндэслэлээр шүүхэд хандах боломжтой асуудал уу гэдгийг шүүхээс нарийвчлан үнэлэх нь нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах болон иргэний субъектив эрхийн зөрчлийг арилгахад чиглэсэн нэхэмжлэл хоорондын тэнцлийг хангахад чухал ач холбогдолтой.

г. Дүгнэлт

Тус хэргийн шүүхийн шийдвэр нь ЗХШХШтХ-ийн хүрээнд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд гэдэгт зөвхөн хуульд заасан шаардлага хангасан төрийн бус байгууллагыг ойлгох уу, эсхүл иргэн хамаарах уу гэсэн асуултад хариулт өгсөн ач холбогдолтой юм.

ЗХШХШтХ-ийн зохицуулалтаас харахад нийтийн ашиг

сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд гэдэгт хуульд заасан шаардлага хангасан төрийн бус байгууллагыг хэлэх бөгөөд иргэн хамаарахгүй. Гэвч тухайн хэрэг дээрх хөндөгдөж буй ашиг сонирхол нь үнэхээр нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхэд хамаарах асуудал уу, эсхүл иргэн өөрийн эрх, ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхэд хамаарах асуудал уу гэдгийг шүүх нарийвчлан шалгавал хэдийгээр нийтийн ашиг сонирхолд хамаарах шинжтэй боловч иргэн өөрийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах үүднээс гаргасан нэхэмжлэл гэж үзэн нэхэмжлэл гаргах эрхийг зөвшөөрөх боломжтой юм. Нийтийн ашиг сонирхол болон иргэний өөрийн эрх, ашиг сонирхлыг нарийвчлан зааглах нь хүндрэлтэй асуудал боловч цаашид уг асуудал чухлаар тавигдахаар байна.

Иргэн өөрийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах, сэргээн тогтоох улмаар түүний үр дүнд нийтийн ашиг сонирхол давхар хамгаалагдах шинжтэй маргааны тохиолдолд захиргааны хэргийн шүүхээс түүнийг дан ганц нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхийн хүрээнд хамаарах асуудал гэсэн үндэслэлээр иргэний нэхэмжлэл гаргах эрхийг зөвшөөрөхгүй байх хандлага тогтохоос зайлсхийх нь зүйтэй.

ДҮН ШИНЖИЛГЭЭ 2. “Хангалттай сонирхол илэрхийлсэн байх” зохицуулалтыг хэлбэрийн төдий үнэлсэн хэрэг

а. Хэргийн агуулга

Энэхүү хэрэг нь нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд НҮТББ-аас хариуцагч захиргааны байгууллага болон холбогдох гуравдагч этгээд хооронд байгуулсан захиргааны гэрээг илт хууль бус болохыг тогтоолгох шаардлага бүхий нэхэмжлэлд хамаарах юм. Нэхэмжлэгч “ХХАТ” НҮТББ-аас захиргааны хэргийн шүүхэд гаргасан нэхэмжлэлдээ Дорноговь

аймгийн (цаашид “ДГА” гэх) Д сумын Засаг дарга (цаашид “ЗД” гэх), “Ф Р” ХХК-ийн хооронд 2019.03.06-ны өдөр байгуулагдсан “Хамтран ажиллах гэрээ”-г илт хууль бус болгохыг тогтоолгох шаардлага тавьжээ.

6. Шүүхийн шийдвэр

Анхан шатны шүүхийн шийдвэр, агуулга

Анхан шатны шүүх нэхэмжлэгч НҮТББ-ын нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж шийдвэрлэжээ. Ингэхдээ “Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.6, 26 дугаар зүйлийн 26.1, 55 дугаар зүйлийн 55.1.1-д заасныг баримтлан нэхэмжлэгч “ХХАТ” НҮТББ-ын нэхэмжлэлийг бүхэлд нь хангаж, ДГА-ийн Д сумын ЗД, “Ф Р” ХХК-ийн хооронд 2019 оны 3 дугаар сарын 6-ны өдөр байгуулагдсан 15/2019 дугаартай “Хамтран ажиллах гэрээ”-г илт хууль бус болохыг тогтоосугай”¹⁴ гэж шийдвэрлэжээ.

Давж заалдах шатны шүүхийн магадлал, агуулга

Давж заалдах шатны шүүхээс дээрх ДГА дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн шийдвэрийг хэвээр үлдээж, гуравдагч этгээдийн төлөөлөгчийн давж заалдах гомдлыг хангахгүй шийдвэрлэжээ.¹⁵

¹⁴ Дорноговь аймгийн Д сумын Засаг дарга, нэр бүхий ХХК-ийн хооронд байгуулагдсан захиргааны гэрээг илт хууль бус болохыг тогтоолгох тухай Дорноговь аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2020.05.22-ны өдрийн 115/ШШ2020/0008 дугаар шийдвэр (115/2020/0002/3), 20-21 дэх тал, Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан, https://shuukh.mn/single_case/6485?daterange=2020-01-01%20-%202021-08-15&id=1&court_cat=3&bb=1 2022.04.27-ны өдрийн хандалт.

¹⁵ Дорноговь аймгийн Д сумын Засаг дарга, нэр бүхий ХХК-ийн хооронд байгуулагдсан захиргааны гэрээг илт хууль бус болохыг тогтоолгох тухай Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020.08.11-ний өдрийн 221/МА2020/0478 дугаар магадлал (115/2020/0002/3), 11 дэх тал, Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан, https://shuukh.mn/single_case/3760?start_date=&end_date=&id=2&court_cat=3&bb=1 2022.04.27-ны өдрийн хандалт.

Улсын Дээд шүүхийн тогтоол, агуулга

УДШ-ээс дээрх анхан шатны шүүхийн шийдвэр болон давж заалдах шатны шүүхийн магадлалыг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцаажээ. Ингэхдээ “анхан шатны шүүх нэхэмжлэлийн шаардлага түүний үндэслэлийг тодруулж, маргаан бүхий захиргааны актын үндэслэлд хууль зүйн дүгнэлт өгч, нэхэмжлэлийн шаардлага, түүний үндэслэл нь зөрчигдөж болзошгүй нийтийн ямар ашиг сонирхолтой уялдаж, нэхэмжлэгчийн хуулиар хамгаалагдсан эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хэрхэн зөрчсөнийг дүгнэн хэргийг шийдвэрлэх шаардлагатай тул шийдвэр, магадлалыг хүчингүй болгон, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцааж шийдвэрлэв”¹⁶ гэж тэмдэглэжээ.

в. Дүн шинжилгээ

Тус хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрт нэхэмжлэгч НҮТББ нь ЗХШХШтХ-ийн 52.5.5 дахь “хангалттай сонирхол илэрхийлсэн байх” зохицуулалтыг хэрхэн хангаж буйд дүгнэлт хийжээ. Тодруулбал, тус шийдвэрт “...Нэхэмжлэгч ТББ нь “хүрээлэн байгаа орчныг хамгаалах” асуудлаар нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн гаргаж буй нэхэмжлэлийн шаардлагын үндэслэлийг “...сонсох ажиллагаа явуулалгүй байгуулсан захиргааны гэрээ илт хууль бус болохыг тогтоолгож, цаашид энэ төрлийн захиргааны гэрээ байгуулахад сонсох ажиллагаа явуулан байгаль орчныг хамгаалах чиглэлээр иргэдийн зүгээс хяналтыг хэрэгжүүлэх, уурхай ашиглах дэд бүтэц нь сумын иргэдийн эрхэлж буй аж ахуйн үйл ажиллагаа, хүрээлэн буй орчинд хэрхэн нөлөөлөх талаар иргэдийн тайлбарыг сонсож,

¹⁶ Дорноговь аймгийн Д сумын Засаг дарга, нэр бүхий ХХК-ийн хооронд байгуулагдсан захиргааны гэрээг илт хууль бус болохыг тогтоолгох тухай Улсын Дээд шүүхийн 2020.12.21-ний өдрийн 001/ХТ2020/0437 дугаар тогтоол (115/2020/0002/3), бдахь тал, Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан, https://shuukh.mn/single_case/2586?start_date=&end_date=&id=3&court_cat=3&bb=1 2022.04.27-ны өдрийн хандалт.

саналыг нь гэрээнд тусгаснаар иргэд хяналт тавих, сөрөг нөлөөлөл хамгийн бага байх хэлбэрээр уурхайн дэд бүтцийг хөгжүүлэх боломж бүрдэж, ингэснээр иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрх нь хэрэгжих, улмаар уул уурхайн үйл ажиллагаа орон нутагт үр ашиг өгөхөөр тусгасан дээрх хуулийн заалт бодит амьдрал дээр хэрэгжих, иргэдийн төлөөлөл хооронд орж ажиллах замаар уул уурхайн үйл ажиллагаанаас эдийн засгийн үр ашгийг бодитоор хүртэх эрх нь нээгдэнэ” гэх зэргээр тодорхойлсон нь маргаж буй асуудлаар хангалттай сонирхол илэрхийлсэн гэж үзнэ”¹⁷ хэмээн тусгажээ.

Дээрх анхан шатны шүүхийн шийдвэрт нэхэмжлэгч НҮТББ-ын нэхэмжлэлийн шаардлагын үндэслэлийг давтан бичиж, улмаар “хангалттай сонирхол илэрхийлсэн байх” зохицуулалтыг хангасан байна гэсэн нь хэт хэлбэрийн төдий хийсвэр үнэлэлт юм. Шүүхээс “хангалттай сонирхол илэрхийлсэн байх” зохицуулалтыг хэт хэлбэрийн төдий үнэлж буй шалтгаан нь ЗХШХШТХ-ийн 18.3 дахь заалт буюу нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээдэд тавигдах шаардлагыг хангасан гэдгээ нотолсон бол “хангалттай сонирхол илэрхийлсэн байх” зохицуулалтыг нарийвчлан үнэлэхгүй хандлага буйтай холбоотой. Тухайлбал, анхан шатны шүүхээс нэхэмжлэгч НҮТББ-ын нэхэмжлэл гаргах эрхтэй эсэхийг үнэлэхдээ тус НҮТББ-ын үйл ажиллагааны эрхэм зорилго хэсэгт “Уур амьсгалын өөрчлөлт, байгалийн нөөц ашиглалт, менежментийн нөлөөллөөс хүрээлэн буй орчин, хүний эрхийг хамгаалах, сайн засаглалыг бүтээх үйл явцад иргэдийн оролцооны эрхийг хангах, чадавхыг бэхжүүлэх, нийтийн эрх ашгийн төлөө тогтвортой ажиллах явдал” хэмээн тодорхойлсон, Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2019.12.06-ны өдрийн 6/9620 тоот албан бичигт “ХХАТ” НҮТББ 2016-2019 оныг хүртэлх хугацаанд үйл ажиллагааны тайлангаа тус газарт ирүүлсэн

¹⁷ Өмнөх эшлэл (14), 17 дахь тал.

талаар тодорхойлсон бөгөөд энэ нь хэрэгт нотлох баримтаар авагдсан тус ТББ-ын 2017, 2018, 2019 оны үйл ажиллагааны тайлангаар нотлогдож байгаагаас үзэхэд нэхэмжлэгч НҮТББ нь ЗХШХШТХ-ийн 18 дугаар зүйлийн 18.3-т заасан шаардлагуудыг хангасан нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй этгээд байна¹⁸” хэмээн шийдвэрлэжээ.

Тус хэргийн давж заалдах шатны шүүх хуралдааны магадлалд нэхэмжлэгч НҮТББ нь ЗХШХШТХ-ийн “хангалттай сонирхол илэрхийлсэн байх” зохицуулалтыг хэрхэн хангасан тухайд үнэлэлт өгөөгүй юм. Түүнчлэн УДШ-ийн тогтоолд ЗХШХШТХ-ийн “хангалттай сонирхол илэрхийлсэн байх” зохицуулалтыг дурдсанаас өөрөөр үнэлэлт өгөөгүй байна.¹⁹

г. Дүгнэлт

Хууль тогтоогч ЗХШХШТХ-ийн 52.5.5-д “хангалттай сонирхол илэрхийлсэн байх” гэсэн томъёолол дээр тогтсон гол үндэслэл нь нэхэмжлэгч НҮТББ-ын өөрийнх нь эрх, ашиг сонирхол зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй байдлыг заавал шаардахгүйгээр нэхэмжлэл гаргах эрхийг нээж өгөхөд оршино. Түүнчлэн нэхэмжлэгч нь ЗХШХШТХ-ийн 18.3-д заасан хоёр шаардлагыг хэрхэн хангасан тухайгаа тэмдэглэх нь “хангалттай сонирхол илэрхийлсэн байх” шаардлагад хамааралтай гэсэн санааг хууль тогтоогч илэрхийлсэн юм.

Шүүхээс тухайн хэрэг дээр нэхэмжлэгч НҮТББ “хангалттай сонирхол илэрхийлсэн байх” зохицуулалтыг хангасан эсэхийг шалгахдаа хэлбэрийн төдий үнэлж, хэргийг хүлээн авч шийдвэрлэсэн байна. Нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхийг аль болох нээлттэй хүлээн зөвшөөрөх гэдэг утгаараа шүүхээс нэхэмжлэгч НҮТББ-ын “хангалттай сонирхол илэрхийлсэн байх” зохицуулалтыг хатуу шаардлагаар

¹⁸ Өмнөх эшлэл (14), 19-20 дахь тал.

¹⁹ Өмнөх эшлэл (16), 5 дахь тал.

үнэлэхгүй байгаа нь сайн талтай байж болохыг үгүйсгэхгүй юм.

Гэвч ЗХШХШТХ-ийн 52.5.5 дахь “хангалттай сонирхол илэрхийлсэн байх” зохицуулалтыг шүүхээс хэрэглэхдээ дан ганц нэхэмжлэгч ТББ-ын нэхэмжлэлийн шаардлагын үндэслэлийг дахин бичих, улмаар уг шаардлагыг хангаж байна гэж үнэлэх нь хэт хийсвэр, бодит бус дүгнэлт гэж үзэж буй юм.

Цаашид шүүхээс ямар тохиолдолд нэхэмжлэгч нь “хангалттай сонирхол илэрхийлсэн байх” зохицуулалтыг хангасан гэж үзэх хэмжүүр болохыг тодорхойлох шаардлага үүсэхээр байна. Жишээлбэл, хариуцагч захиргааны байгууллагын гаргасан маргаан бүхий захиргааны шийдвэр, үйл ажиллагаа, шийдвэр гаргах үндэслэл болсон хууль, эрх зүйн хэм хэмжээнд тухайн асуудал нь нийтийн ашиг сонирхолтой холбогдох тул олон нийтийн оролцоог хангахыг шаардсан, шийдвэр гаргалтад олон нийтийн байгууллагын оролцоог тодорхой хуульчилж өгсөн зэрэг агуулга бүхий зохицуулалт байсан гэж төсөөлбөл энэ нь нэхэмжлэгч НҮТББ-ыг “хангалттай сонирхол илэрхийлсэн байх” зохицуулалтыг хангасан гэж үзэх хэмжүүрийн нэг шийдэл байж болох юм. Энэ тохиолдолд ЗХШХШТХ-ийн тус зохицуулалтыг хангасан эсэхийг үнэлэх шалгуур нь тухайн маргаан бүхий харилцааг зохицуулсан тусгай хуулийн хэм хэмжээ, зохицуулалтын агуулгаас илүүтэй хамааралтай болох юм. Салбарын хуулийн нарийвчилсан зохицуулалт боловсронгуй болгосноор ЗХШХШТХ-ийн “хангалттай сонирхол илэрхийлсэн байх” зохицуулалтыг шүүхээс тодорхой хэрэг маргаан дээр бодитоор үнэлэлт, дүгнэлт хийх боломж бүрдэх юм.

ДҮН ШИНЖИЛГЭЭ 3. “Хангалттай сонирхол илэрхийлсэн байх” зохицуулалтыг “нийтийн ямар ашиг сонирхол хэрхэн зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй” гэсэнтэй хамтад нь үнэлж буй хэрэг

а. Хэргийн агуулга

Нэхэмжлэгч “О ш” НҮТББ-аас дараах хоёр нэхэмжлэлийн шаардлага гаргажээ. Үүнд: 1) Хариуцагч Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2018 оны 1 дүгээр сарын 3-ны өдрийн “Журмын заалт хүчингүй болгох тухай” А-01 тоот тушаалаар “Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох төсөл сонгон шалгаруулах журам”-д оруулсан өөрчлөлт хууль бус байсан болохыг тогтоолгох; 2) Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2017 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн А/76 дугаар тушаалаар батлагдсан “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох төсөл сонгон шалгаруулах журам”-ын 6.7-ын доор хийсэн “Дээрх зохицуулалт нь энэхүү журам батлагдсанаас хойш шинээр зарлах төсөл сонгон шалгаруулалтад үйлчлэхгүй” гэх нэмэлт тайлбар заалт хууль бус байсан болохыг тогтоолгох тухай шаардлага юм.

б. Шүүхийн шийдвэр

Давж заалдах шатны шүүхийн шийдвэр, агуулга

Давж заалдах шатны шүүх тус хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн онцлогтой. Давж заалдах шатны шүүхээс нэхэмжлэгч “О ш” НҮТББ-ын нэхэмжлэлийн 1 дэх шаардлагыг хангаж шийдвэрлэсэн бол 2 дахь шаардлагын тухайд ЗХШХШтХ-ийн 54 дүгээр зүйлийн 54.1.5-д заасан үндэслэлээр хүлээн авахаас татгалзсан байна.²⁰

²⁰ “Онч шийдэл” НҮТББ-ын нэхэмжлэлтэй хэргийн хянан хэлэлцлээ, 2019.10.02-ны өдрийн мэдээлэл, Улсын Дээд шүүхийн албан ёсны цахим хуудас, <http://www.supremecourt.mn/news/475> 2022.04.27-ны өдрийн хандалт. Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын тушаал хууль бус байсан болохыг тогтоолгох тухай Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2019.06.10-ны өдрийн 221/ШШ2019/0008 дугаар шийдвэр (221/2019/0005/3) нь Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим санд байршигдаагүй.

Улсын Дээд шүүхийн тогтоол, агуулга

УДШ-ээс давж заалдах шатны шүүхийн магадлалыг хүчингүй болгож, “О ш” НҮТББ-ын гаргасан нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгожээ.²¹

в. Дүн шинжилгээ

Шүүхээс нэхэмжлэл нь ЗХШХШТХ-ийн “хангалттай сонирхол илэрхийлсэн байх” зохицуулалтыг хангасан эсэхийг үнэлэхдээ “нийтийн ямар ашиг сонирхол хэрхэн зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй” гэсэн нөхцөлтэй хамтад нь авч үзсэн гэж дүгнэж болно. Тухайлбал, тус хэргийн УДШ-ийн тогтоолд “Нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээдээс “нийтийн өмчийг хамгаалах асуудлаар” шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийг хэрэгжүүлэх үндэслэл нь “нийтийн өмч дэх нийтийн ашиг сонирхол” хөндөгдөж зөрчигдсөн байх явдал бөгөөд түүнийг нийтийн ашиг сонирхлын үүднээс хамгаалах шаардлага гарсан байх, уг харилцаанд нийтийн ашиг сонирхол хөндөгдөж, зөрчигдсөн тохиолдол үүссэн байх агуулгатай, харин эрх зүйн ерөнхий харилцаанд оролцогч этгээдүүдээс тодорхой этгээдийг нэрлэн зааж, түүний субъектив эрхийг хангуулах зорилгоор гаргасан нэхэмжлэл нь Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан “нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх” агуулгад хамааралгүй²²” гэж тэмдэглэжээ.

Мөн тогтоолд “...харин хөнгөлөлттэй зээл олгоогүйн улмаас хохирсон гэх нэхэмжлэлд дурдагдсан нэр бүхий иргэн, аж ахуйн нэгж нь захиргааны буруутай үйл ажиллагааны улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдсөн эсэх асуудал

²¹ Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын тушаал хууль бус байсан болохыг тогтоолгох тухай Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны шүүх хуралдааны 2019.10.02-ны өдрийн 295 дугаар тогтоол (221/2019/0005/3), 11-12 дахь тал. Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан, https://shuukh.mn/single_case/1965?start_date=&end_date=&id=3&court_cat=3&bb=1 2022.04.27-ны өдрийн хандалт.

²² Өмнөх эшлэл (21) 9 дэх тал.

нь субъектив эрх зөрчигдсөнтэй холбогдох маргаан бөгөөд, уг асуудлаар тухайн этгээд хуулиар тогтоосон журмын дагуу шүүхэд хандаж, гомдол нэхэмжлэл гаргах, хохирол төлбөрөө тогтоолгох, буруутай этгээдээр төлүүлэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд бусдаар өөрийгөө төлөөлүүлэх эрхийг хуулиар хязгаарлаагүй байна.”²³; “...нийтийн ямар ашиг сонирхол хэрхэн зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй нөхцөл байдал тогтоогдохгүй, энэ тохиолдолд нэхэмжлэгчийг “нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нийтийн өмчийг хамгаалах асуудлаар” шүүхэд нэхэмжлэл гаргасан гэж үзэх боломжгүй”²⁴ гэж дүгнэжээ.

Дээрхээс дүгнэвэл “хангалттай сонирхол илэрхийлсэн байх” зохицуулалтыг шүүх үнэлэхдээ “нийтийн ямар ашиг сонирхол хэрхэн зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй” гэсэн шаардлагыг тухайн маргаанд хэрхэн хангаж буйг үнэлэхдээ хамтад нь авч үзэж байгаа гэж харахаар байна. Тухайн маргааны зүйл нь үнэхээр нийтийн ашиг сонирхолд хамаарах асуудал уу, эсхүл тус ашиг сонирхол нь тодорхойлж болохуйц тухайн нэг этгээдэд хамаарах зүйл үү гэдгийг шүүх үнэлж буй явдал нь “хангалттай сонирхол илэрхийлсэн байх” зохицуулалтыг шалгахтай үр нөлөөний хувьд давхцаж болохоор байна. Цаашид тухайн тохиолдолд “нийтийн ашиг сонирхол”²⁵ ба “субъектив эрх”²⁶ гэсэн

²³ Өмнөх эшлэл (21) 9 дэх тал.

²⁴ Өмнөх эшлэл (21) 9-10 дахь тал.

²⁵ С.Нарангэрэл: “нийтийн ашиг сонирхол” гэдэгт “...нийтийн эрх зүйд төрөөс хүлээн зөвшөөрсөн ба эрх зүйгээр зохицуулагдсан нийгэмшлийн нийтлэгийн ашиг сонирхол, тэдгээрийн оршин тогтнох болон хөгжихийг хангах нөхцөл ба баталгаа;” гэж тодорхойлжээ. С.Нарангэрэл, Монголын эрх зүйн эх толь бичиг, дөрөв дэх хэвлэл, 2015 он, 278 дахь тал (ISBN 978-99973-0-698-2). Бусад бүтээлд “нийтийн ашиг сонирхол” гэх ойлголт нь хувьсан өөрчлөгдөж байдаг тул хуульд тогтсон тайлбар хийх нь зохимжгүй бөгөөд шүүх тухайн тохиолдолд ямар ашиг сонирхол “нийтийн ашиг сонирхол”-д хамаарахыг үнэлэхэд чухал үүрэгтэй болохыг тэмдэглэжээ. Эрх зүйн боловсрол академи, Ханнс-Зайделийн сан, Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ, УБ., 2018, 181 дэх тал. Хууль зүйн судалгааны бүтээлийн цахим сан <https://legaldata.mn/buteel/pdf?id=428> 2022.04.24-ний хандалт.

²⁶ С.Нарангэрэл: “субъектив эрх” гэдэгт “... тодорхой үйлдэл (зан үйл) бие даан үйлдэх боломж, түүнчлэн бусад этгээдээс тодорхой зан үйл (үйлдэл хийх буюу үйлдлээс түдгэлзэх) шаардах боломж багтана. ... зөрчигдсөн тохиолдолд түүнийг зөрчигчид

хоёр ойлголтын ялгааг хэрхэн тогтоох вэ гэдэг асуудал чухалд тавигдахаар байна.

г. Дүгнэлт

Шүүхээс нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргасан хэрэг дээр нэхэмжлэгч нь “хангалттай сонирхол илэрхийлсэн байх” зохицуулалтыг нарийвчлан үнэлэхийн ач холбогдол нь бүхий л асуудлыг нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудал гэж үзэн шүүхэд хийсвэр ачаалал үүсэхээс сэргийлэхэд орших юм. Тус хэрэг дээр шүүхээс нэхэмжлэгч НҮТББ нь “хангалттай сонирхол илэрхийлсэн байх” зохицуулалтыг тусад нь үнэлээгүй боловч “нийтийн ямар ашиг сонирхол хэрхэн зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй” гэсэн шаардлагыг үнэлэхдээ хамтад нь авч үзсэн гэж дүгнэхээр байна.

ДҮН ШИНЖИЛГЭЭ 4. “Хангалттай сонирхол илэрхийлсэн байх” зохицуулалтыг үнэлэхгүй байгаа хэрэг

а. Хэргийн агуулга

Нэхэмжлэгч “Нуах” НҮТББ-аас захиргааны хэргийн шүүхэд “СМ” ХХК-ийн эзэмшилд байх дугаар бүхий ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийг хүчингүй болгохыг хариуцагч Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтэст даалгах тухай нэхэмжлэлийн шаардлага гаргажээ.

гомдлын шаардлага гаргах замаар шүүх буюу хуулиар тогтоосон төрийн бусад байгууллагад хандаж, хуулиар албадан хамгаалуулна.” гэж бичжээ. С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг, хоёр дахь хэвлэл, УБ., 2008, 385 дахь тал (ISBN 978-99929-0-353-8). Ц.Цогт бүтээлдээ Монголын захиргааны эрх зүйд Standing question; Standing issue буюу тухайн этгээд нь захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргаж буй уг захиргааны шийдвэрийн талаар шүүхэд хянан шийдвэрлэхэд оролцогч болж маргах эрхтэй мөн эсхийг тогтооход “субъектив эрх”-ийн ойлголт дүйцэхээр байна гэж дүгнэжээ. Ц.Цогт, Захиргааны хэргийн шүүх, УБ., 2019, 76 дахь тал (ISBN:978-9919-22-619-0).

6. Шүүхийн шийдвэр

Энэхүү хэргийг эцэслэн шийдвэрлэсэн Улсын Дээд шүүхийн хяналтын шатны шүүх хуралдааны 2019.12.09-ний өдрийн тогтоол гарахаас өмнө нь тус хэрэг Улсын Дээд шүүхийн хяналтын шатны шүүх хуралдааны 2018.11.14-ний өдрийн тогтоолоор анхан шатны шүүх рүү дахин хэлэлцүүлэхээр буцаагдаж байжээ (Хавсралт 8-ыг үзнэ үү). Тухайн хэргийг хянан шийдвэрлэсэн сүүлийн шүүхийн шийдвэрийг дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 1. Шүүхээс хэргийг шийдвэрлэсэн байдал

Огноо, дугаар	Шүүхийн нэр	Шийдвэрийн товч
2019.03.15 Дугаар 180	Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх	Нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж шийдвэрлэсэн.
2019.09.10 Дугаар 221/МА2019/0473	Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх	Нийслэлийн Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн шийдвэрийн Тогтоох хэсгийн зарим хэсгийг өөрчлөн, шийдвэрийн бусад заалтыг хэвээр үлдээсэн.
2019.12.09 Дугаар 404	Улсын Дээд шүүх	Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2019.9.10-ны өдрийн магадлалыг хүчингүй болгож, нийслэл дэх Захиргааны хэргийн шүүхийн 2019.3.15-ны өдрийн шийдвэрийн Тогтоох хэсгийн зарим хэсгийг хасаж, зарим хэсгийг өөрчлөн, шийдвэрийн бусад хэсгийг хэвээр үлдээсэн.

Тус хэргийн шүүхийн шийдвэрт “хангалттай сонирхол илэрхийлсэн байх” зохицуулалтыг хэрхэн үнэлсэн болохыг дүн шинжилгээний хэсэгт авч үзье.

в. Дүн шинжилгээ

Энэхүү хэргийн Нийслэл дэх Захиргааны хэргийн шүүхийн 2018.06.07-ны өдрийн дугаар 128/ШШ2018/361 шийдвэрт урьд нь шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ хийгджээ. Тус дүн шинжилгээнд нэхэмжлэгч НҮТББ нь нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд мөн эсэхийг нотлох ажиллагааг шүүх хангалттай хийлгүйгээр захиргааны хэрэг үүсгэж хянан шийдвэрлэсэн гэсэн дүгнэлт хийсэн боловч “хангалттай сонирхол илэрхийлсэн байх” зохицуулалтын хүрээнд нарийвчлан авч үзээгүй байна.²⁷

Уг хэргийн нэхэмжлэгч НҮТББ-ын гаргасан нэхэмжлэл, түүний дагуу захиргааны хэрэг үүсгэсэн цаг хугацаа нь өмнөх 2002 оны ЗХХШТХ-ийн үйлчлэлд хамаарах бол тус хэргийг шүүхэд хянан шийдвэрлэсэн хугацаа нь 2016 онд батлагдсан ЗХШХШТХ-ийн үйлчлэлд хамаардаг. 2002 оны ЗХХШТХ-ийн үйлчлэл хамаарах үед нэхэмжлэгч НҮТББ-ын гаргасан нэхэмжлэлийн дагуу захиргааны хэрэг үүссэн байхад 2016 оны ЗХШХШТХ-д заасан “нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд” гэж үзэн мөн хуулийн 18.3 дахь хэсэгт заасан шаардлагыг хангасны үндсэн дээр нэхэмжлэл гаргах эрх нь зөвшөөрөгдсөн гэж үзэх нь зөрчилтэй юм.

Тухайлбал, тус хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрт “...Гэсэн хэдий ч уг нэхэмжлэл нь өнөөдрийн цаг хугацаа буюу шүүхийн шийдвэр гарах өдөр хүчин төгөлдөр үйлчилж

²⁷ Д.Баяр, Д.Бадамцэцэг, С.Билгүүн, Нийтийн ашиг сонирхлыг хамгаалахтай холбоотой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа: шүүхийн практик, УБ., 2020, 15-16; 75 дахь тал (ISBN 978-9919-9574-3-8) Нээлттэй Нийгэм Форум цахим хуудас, https://www.forum.mn/index.php?sel=resource&f=resone&obj_id=1139&menu_id=3&resmenu_id=2 2022.04.27-ны өдрийн хандалт.

байгаа ЗХШХШтХ (2016)-ийн 3 дугаар зүйлийн 3.1.3-д заасан нэхэмжлэлд тавигдах шаардлагыг хангасан, нэхэмжлэгчийг мөн хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дугаар зүйлд заасны дагуу нэхэмжлэл гаргах эрхтэй этгээд гэж дүгнэх үндэслэлтэй байна...²⁸” гэж тэмдэглэжээ. Тус хэргийн магадлалд “... нэхэмжлэгч нь анх 2016 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр нэхэмжлэл гаргасан байх ба тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан хуулиар нэхэмжлэл гаргах эрхтэй этгээд гэж үзэх боломжгүй ч шүүхийн шийдвэр гарсан хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулиар нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхтэй этгээдэд хамаарч байгаа нөхцөл байдлыг харьцуулан үзэж, “Нуах” НҮТББ-ыг нэхэмжлэл гаргах эрхтэй талаар дүгнэсэн шүүхийн дүгнэлтийг буруутгах боломжгүй...²⁹” гэж дүгнэжээ. Хэрэв энэ логикоор авч үзвэл нэхэмжлэгч “Нуах” НҮТББ-ны нэхэмжлэлийн шаардлага, үндэслэл нь ЗХШХШтХ-ийн 52.5.5-д заасан “хангалттай сонирхол илэрхийлсэн байх” гэснийг мөн адил хангасан байх ёстой, энэ тухайд шүүхээс үнэлэлт өгөх ёстой байсан гэж үзнэ.

Гэтэл тухайн хэргийн Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2019.03.15-ны өдрийн 180 дугаар шийдвэр; Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2019.09.10-ны өдрийн дугаар 221/МА2019/0473 магадлал; Улсын Дээд шүүхийн 2019.12.09-ний өдрийн дугаар 404 тогтоолд³⁰ нэхэмжлэгч НҮТББ-ын захиргааны хэргийн шүүхэд

²⁸ Нэр бүхий ХХК-ний эзэмшилд байх ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийг хүчингүй болгохыг АМГТГКХД-д даалгах тухай Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2019.03.15-ны өдрийн дугаар 180 шийдвэр (128/2016/0127/3), 19 дэх тал. Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан, https://shuukh.mn/single_case/6136?start_date=&end_date=&id=1&court_cat=3&bb=1 2022.04.27-ны өдрийн хандалт.

²⁹ Нэр бүхий ХХК-ний эзэмшилд байх ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийг хүчингүй болгохыг АМГТГКХД-д даалгах тухай Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2019.09.10-ны өдрийн дугаар 221/МА2019/0473 магадлал (128/2016/0127/3), 9 дэх тал. Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан, https://shuukh.mn/single_case/3024?start_date=&end_date=&id=2&court_cat=3&bb=1 2022.04.27-ны өдрийн хандалт.

³⁰ Нэр бүхий ХХК-ний эзэмшилд байх ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийг хүчингүй

нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрх бүхий этгээд мөн эсэх дээр үнэлэлт өгсөн байх боловч ЗХШХШТХ-ийн “хангалттай сонирхол илэрхийлсэн байх” зохицуулалтыг үнэлээгүй нийтлэг тал ажиглагдсан болно.

г. Дүгнэлт

Шүүх нэхэмжлэгч НҮТББ-ын нэхэмжлэл нь 2016 оны ЗХШХШТХ-д заасан нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах харилцааг зохицуулсан хууль үйлчилнэ гэж тайлбарласан атлаа тус хуульд заасан “хангалттай сонирхол илэрхийлсэн байх” зохицуулалтыг нэхэмжлэгч НҮТББ хэрхэн хангасан эсэхийг үнэлээгүй байна. Энэ нь шүүх нэхэмжлэгч НҮТББ нь ЗХШХШТХ-ийн 18.3 дугаар зүйлд заасан нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээдэд тавигдах шаардлагыг хэрхэн хангаж буйг үнэлсэн тохиолдолд тус хуулийн 52.5.5-д заасан “хангалттай сонирхол илэрхийлсэн байх” зохицуулалтыг нарийвчлан үнэлэхгүй байх хандлагатай байгааг давхар илтгэж байна. Түүнчлэн хууль тогтоогч “хангалттай сонирхол илэрхийлсэн байх” зохицуулалтын талаар хэлэлцэхдээ дээрх 18.3 дугаар зүйлд заасан нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээдэд тавигдах шаардлагыг хэрхэн хангаж буйг нэхэмжлэлдээ тодорхой тусгах нь “хангалттай сонирхол илэрхийлсэн байх” зохицуулалттай хамаарна гэсэн үзэл санааг илэрхийлсэн хэмээн судалгааны өмнөх хэсэгт дүгнэсэн билээ.

болгохыг АМГТГКХД-д даалгах тухай Монгол Улсын Дээд шүүхийн 2019.12.09-ний өдрийн дугаар 404 тогтоол (128/2016/0127/3). Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан, https://shuukh.mn/single_case/2129?start_date=&end_date=&id=3&court_cat=3&bb=1 2022.04.27-ны өдрийн хандалт.

НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Энэхүү судалгааны дүнд дараах таван дүгнэлтэд хүрлээ.

1. Хууль тогтоогч ЗХШХШТХ-ийн 52.5.5 дахь заалтад “хангалттай сонирхол илэрхийлсэн байх” томъёолол оруулсан нь тухайн нэхэмжлэгч ТББ-ын өөрийн эрх, ашиг сонирхол зөрчигдсөн байхыг шаардахгүйгээр нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхтэй байх ёстой гэж үзсэнд оршино. Мөн хуулийн 18.3 дахь хэсэгт заасан хоёр шаардлагыг нэхэмжлэгч ТББ хэрхэн хангаж буйгаа нэхэмжлэлдээ тусгах, тус нэхэмжлэлийг гаргах ямар ашиг сонирхол байгааг тусгах нь ЗХШХШТХ-ийн “хангалттай сонирхол илэрхийлсэн байх” зохицуулалттай холбогдоно гэсэн санааг хууль тогтоогч илэрхийлжээ.
2. ЗХШХШТХ-д зааснаар нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд гэдэгт иргэн хамаарахгүй. Цаашид шүүх тухайн маргаан дээр хөндөгдөж буй ашиг сонирхол нь үнэхээр нийтийн ашиг сонирхолд хамаарах уу, эсхүл нэхэмжлэгч иргэн өөрийн эрх, ашиг сонирхолд хамааруулах боломжтой ашиг сонирхол уу гэдгийг нарийвчлан үнэлэх шаардлага тулгарахаар байна. Иргэн өөрийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах, сэргээн тогтоох улмаар түүний үр дүнд нийтийн ашиг сонирхол давхар хамгаалагдах шинжтэй маргааны тохиолдолд түүнийг нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхийн хүрээн

дэх асуудал гэсэн үндэслэлээр иргэний нэхэмжлэл гаргах эрхийг зөвшөөрөхгүй байх хандлага тогтох эрсдэл байна.

3. Шүүхээс нэхэмжлэгч НҮТББ нь “хангалттай сонирхол илэрхийлсэн байх” зохицуулалтыг хэрхэн хангасан болохыг үнэлэхдээ нэхэмжлэгч НҮТББ-ын нэхэмжлэлийн шаардлага, үндэслэлийг давтан бичих замаар хэт хийсвэр, бодит бус үнэлэлт хийж байна. Энэ нь “хангалттай сонирхол илэрхийлсэн байх” зохицуулалтыг шүүх юуг хэмжүүр болгон үнэлэх вэ гэдэг нь тодорхойгүй байгаатай холбоотой. Жишээлбэл, маргаан бүхий захиргааны шийдвэр, үйл ажиллагааны үндэслэл болж буй хууль, эрх зүйн хэм хэмжээнд тус асуудлаар олон нийтийн байгууллагын оролцоог шаардсан агуулга бүхий зохицуулалт байгаа тохиолдолд шүүхээс нэхэмжлэгч НҮТББ нь “хангалттай сонирхол илэрхийлсэн байх” зохицуулалтыг хангасан гэж зөвшөөрөх хэмжүүрийн нэг болох зэрэг шийдэл байж болох юм.
4. Шүүх нэхэмжлэгч НҮТББ нь “хангалттай сонирхол илэрхийлсэн байх” шаардлагыг хангасан эсэхийг тусад нь үнэлэх бус “нийтийн ямар ашиг сонирхол хэрхэн зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй” гэсэн зохицуулалттай хамтад нь үнэлж буй хандлага байна.
5. Шүүх нэхэмжлэгч НҮТББ нь “хангалттай сонирхол илэрхийлсэн байх” шаардлагыг хангасан эсэхийг огт үнэлэхгүй байх хандлага байна. Учир нь шүүхээс нэхэмжлэгч НҮТББ нь ЗХШХШТХ-ийн 18.3 дугаар зүйлд заасан нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээдэд тавигдах шаардлагыг хэрхэн хангаж буйг үнэлсэн тохиолдолд “хангалттай сонирхол илэрхийлсэн байх” зохицуулалтыг тусад нь үнэлэхгүй байгаатай холбоотой. Энэхүү хандлага нь хууль тогтоогч “хангалттай сонирхол илэрхийлсэн байх” зохицуулалтыг хэлэлцэх үед гарч ирж байсан үзэл санаатай ижил гэж дүгнэхээр байна.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

УИХ-ын нэгдсэн хуралдаан болон ХЗБХ-ны хуралдааны тэмдэглэл:

- Улсын Их Хурлын 2015 оны намрын ээлжит чуулганы Хууль зүйн байнгын хорооны 12 дугаар сарын 22-ны өдөр (Мягмар гараг)-ийн хуралдааны гар тэмдэглэл. <http://www.parliament.mn/n/3ueu> 2022.04.27-ны өдрийн хандалт.
- Улсын Их Хурлын 2015 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сарын 24-ний өдөр (Пүрэв гараг)-ийн нэгдсэн хуралдааны гар тэмдэглэл, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны тухай (шинэчилсэн найруулга) болон холбогдох бусад хуулийн төслүүдийг (Засгийн газар 2015.12.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх). <http://www.parliament.mn/n/5hey> 2022.04.27-ны өдрийн хандалт.
- Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2016 оны 1 дүгээр сарын 20-ны өдөр (Лхагва гараг)-ийн хуралдааны тэмдэглэл, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай (шинэчилсэн найруулга) болон холбогдох бусад хуулийн төсөл (Засгийн газар 2015.12.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг). <http://www.parliament.mn/n/dweo> 2022.04.27-ны өдрийн хандалт.
- Улсын Их Хурлын 2015 оны намрын ээлжит чуулганы 2016 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн нэгдсэн хуралдааны тэмдэглэл, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай (шинэчилсэн

найруулга) болон холбогдох бусад хуулийн төсөл (анхны хэлэлцүүлэг) <http://www.parliament.mn/n/geeo> 2022.04.27-ны өдрийн хандалт.

- Улсын Их Хурлын 2015 оны намрын ээлжит чуулганы 2016 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн нэгдсэн хуралдааны тэмдэглэл, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай (шинэчилсэн найруулга) болон холбогдох бусад хуулийн төсөл (анхны хэлэлцүүлэг үргэлжилнэ) <http://www.parliament.mn/n/caeo> 2022.04.27-ны өдрийн хандалт.
- Хууль зүйн байнгын хорооны 2016 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр (Лхагва гараг)-ийн хуралдаан, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (шинэчилсэн найруулга) болон холбогдох хуулийн төсөл (эцсийн хэлэлцүүлэг) <http://www.parliament.mn/n/gyeo> 2022.04.27-ны өдрийн хандалт.
- Улсын Их Хурлын 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдөр (Пүрэв гараг)-ийн чуулганы нэгдсэн хуралдааны гар тэмдэглэл, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай (шинэчилсэн найруулга) болон Захиргааны ерөнхий хууль батлагдсантай холбогдуулан бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд эцсийн хэлэлцүүлэг <http://www.parliament.mn/n/oaео> 2022.04.27-ны өдрийн хандалт.

Шүүхийн шийдвэр:

Дүн шинжилгээ хэрэг 1.

- Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоол болон мөн сумын Засаг даргын захирамжийг тус тус хүчингүй болгуулах тухай Говьсүмбэр аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2019.01.08-ны өдрийн 113 ШШ2019/0001 дугаар шийдвэр (113/2018/0013/3). Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан, https://shuukh.mn/single_case/4876?start_date=&end_date=&id=1&court_cat=3&bb=1 2022.04.27-ны өдрийн хандалт.

- Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоол болон мөн сумын Засаг даргын захирамжийг тус тус хүчингүй болгуулах тухай Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2019.04.04-ний өдрийн 221/МА2019/0194 дугаар магадлал (113/2018/0013/3). Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан, https://shuukh.mn/single_case/2729?start_date=&end_date=&id=2&court_cat=3&bb=1 2022.04.27-ны өдрийн хандалт.
- Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоол болон мөн сумын Засаг даргын захирамжийг тус тус хүчингүй болгуулах тухай Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны 2019.06.19-ний өдрийн 221 дүгээр тогтоол (113/2018/0013/3). Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан, https://shuukh.mn/single_case/1949?start_date=&end_date=&id=3&court_cat=3&bb=1 2022.04.27-ны өдрийн хандалт.

Дүн шинжилгээ хэрэг 2.

- Дорноговь аймгийн Д сумын Засаг дарга, нэр бүхий ХХК-ийн хооронд байгуулагдсан захиргааны гэрээг илт хууль бус болохыг тогтоолгох тухай Дорноговь аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2020.05.22-ны өдрийн 115/ППП2020/0008 дугаар шийдвэр (115/2020/0002/3), Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан, https://shuukh.mn/single_case/6485?daterange=2020-01-01%20-%202021-08-15&id=1&court_cat=3&bb=1 2022.04.27-ны өдрийн хандалт.
- Дорноговь аймгийн Д сумын Засаг дарга, нэр бүхий ХХК-ийн хооронд байгуулагдсан захиргааны гэрээг илт хууль бус болохыг тогтоолгох тухай Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020.08.11-ний өдрийн 221/МА2020/0478 дугаар магадлал (115/2020/0002/3), Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан, https://shuukh.mn/single_case/3760?start_date=&end_date=&id=2&court_cat=3&bb=1 2022.04.27-ны өдрийн хандалт.
- Дорноговь аймгийн Д сумын Засаг дарга, нэр бүхий ХХК-

ийн хооронд байгуулагдсан захиргааны гэрээг илт хууль бус болохыг тогтоолгох тухай Улсын Дээд шүүхийн 2020.12.21-ний өдрийн 001/ХТ2020/0437 дугаар тогтоол (115/2020/0002/3), Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан, https://shuukh.mn/single_case/2586?start_date=&end_date=&id=3&court_cat=3&bb=1 2022.04.27-ны өдрийн хандалт.

Дүн шинжилгээ хэрэг 3.

- Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын тушаал хууль бус байсан болохыг тогтоолгох тухай Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны шүүх хуралдааны 2019.10.02-ны өдрийн 295 дугаар тогтоол (221/2019/0005/3). Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан, https://shuukh.mn/single_case/1965?start_date=&end_date=&id=3&court_cat=3&bb=1 2022.04.27-ны өдрийн хандалт.

Дүн шинжилгээ хэрэг 4.

- Нэр бүхий ХХК-ний эзэмшилд байх ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийг хүчингүй болгохыг АМГТГКХД-д даалгах тухай Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2019.03.15-ны өдрийн дугаар 180 шийдвэр (128/2016/0127/3). Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан, https://shuukh.mn/single_case/6136?start_date=&end_date=&id=1&court_cat=3&bb=1 2022.04.27-ны өдрийн хандалт.
- Нэр бүхий ХХК-ний эзэмшилд байх ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийг хүчингүй болгохыг АМГТГКХД-д даалгах тухай Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2019.09.10-ны өдрийн дугаар 221/МА2019/0473 магадлал (128/2016/0127/3). Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан, https://shuukh.mn/single_case/3024?start_date=&end_date=&id=2&court_cat=3&bb=1 2022.04.27-ны өдрийн хандалт.
- Нэр бүхий ХХК-ний эзэмшилд байх ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийг хүчингүй болгохыг АМГТГКХД-д даалгах тухай Монгол Улсын Дээд шүүхийн 2019.12.09-ний өдрийн дугаар 404 тогтоол (128/2016/0127/3). Монгол Улсын шүүхийн шийдвэрийн

цахим сан, https://shuukh.mn/single_case/2129?start_date=&end_date=&id=3&court_cat=3&bb=1 2022.04.27-ны өдрийн хандалт.

Бусад ашигласан материал:

- Г.Банзрагч, Захиргааны процессын эрх зүй, УБ., 2019, (ISBN 978-9919-22-620-6)
- Д.Баяр, Д.Бадамцэцэг, С.Билгүүн, Нийтийн ашиг сонирхлыг хамгаалахтай холбоотой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа: шүүхийн практик, УБ., 2020, (ISBN 978-9919-9574-3-8) Нээлттэй Нийгэм Форум цахим хуудас, https://www.forum.mn/index.php?sel=resource&f=resone&obj_id=1139&menu_id=3&resmenu_id=2 2022.04.27-ны өдрийн хандалт.
- Монгол Улсын Их Хурлын тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай, 2012 оны 9 дүгээр сарын 18-ны өдөр, дугаар 37. <https://legalinfo.mn/mn/detail/8722> 2022.04.27-ны өдрийн хандалт.
- “Онч шийдэл” НҮТББ-ын нэхэмжлэлтэй хэргийн хянан хэлэлцлээ, 2019.10.02-ны өдрийн мэдээлэл, Улсын Дээд шүүхийн албан ёсны цахим хуудас, <http://www.supremecourt.mn/news/475> 2022.04.27-ны өдрийн хандалт.
- С.Нарангэрэл, Монголын эрх зүйн эх толь бичиг, дөрөв дэх хэвлэл, УБ., 2015, (ISBN 978-99973-0-698-2)
- С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг, хоёр дахь хэвлэл, УБ., 2008, (ISBN 978-99929-0-353-8)
- Ц.Цогт, Захиргааны хэргийн шүүх, УБ., 2019, (ISBN:978-9919-22-619-0)
- Эрх зүйн боловсрол академи, Ханнс-Зайделийн сан, Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ, 2018. Хууль зүйн судалгааны бүтээлийн цахим сан <https://legalddata.mn/buteel/pdf?id=428> 2022.04.24-ний хандалт.

ХАВСРАЛТ

Хавсралт 1. Нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргахтай холбоотой хийгдсэн голлох судалгааны бүтээл.

№	Бүтээлийн нэр, огноо, татах холбоос
1	Хууль зүйн үндэсний хүрээлэн “Нийтийн эрх ашгийг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргах эрх” 2013. Хууль зүйн судалгааны бүтээлийн цахим сан http://legaldata.mn/buteel/pdf?id=215 2022.04.24-ний хандалт.
2	Хүний эрх хөгжил төв “Байгаль орчны хэргийг шүүхээр шийдүүлэх эрх” 2015. Нээлттэй Нийгэм Форум цахим хуудас http://forum.mn/res_mat/2015//UPR%20Env%20Mon.pdf 2022.04.24-ний хандалт.
3	Монголын хуульчдын холбоо, Захиргааны эрх зүйн хороо “Захиргааны хэргийн шүүхэд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх нь сэдэвт хэлэлцүүлгийн эмхэтгэл” 2017.
4	Хууль зүйн үндэсний хүрээлэн “Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ” 2018. Хууль зүйн үндэсний хүрээлэн цахим хуудас http://nli.gov.mn/?p=5022 2022.04.24-ний хандалт.

5	П.Баттулга, Т.Мөнх-Эрдэнэ “Нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрх” Нээлттэй Нийгэм Форум, Шүүхийн шийдвэрийн шинжилгээ эмхэтгэл 1, 2018. Нээлттэй Нийгэм Форум цахим хуудас http://forum.mn/res_mat/2018/Shuukhiin_shiidveriin_analiz.pdf 2022.04.24-ний хандалт.
6	Эрх зүйн боловсрол академи, Ханнс-Зайделийн сан “Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ” 2018. Хууль зүйн судалгааны бүтээлийн цахим сан https://legaldata.mn/buteel/pdf?id=428 2022.04.24-ний хандалт.
7	Д.Баяр, Д.Бадамцэцэг, С.Билгүүн, Нийтийн ашиг сонирхлыг хамгаалахтай холбоотой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа: шүүхийн практик, 2020. Нээлттэй Нийгэм Форум цахим хуудас https://www.forum.mn/index.php?sel=resource&f=resone&obj_id=1139&menu_id=3&resmenu_id=2 2022.04.24-ний хандалт.
8	С.Сүхчулуун, Л.Отгондорж “Байгаль орчны бохирдолтой холбоотой шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ” Нээлттэй Нийгэм Форум, Шүүхийн шинжилгээний эмхэтгэл-5, 2021. Нээлттэй Нийгэм Форум цахим хуудас https://www.forum.mn/index.php?sel=resource&f=resone&obj_id=1188&menu_id=3&resmenu_id=3 2022.04.24-ний хандалт.

Хавсралт 2. ЗХШХШТХ-ийн шинэчилсэн найруулга хуулийн төслийг хэлэлцсэн үе шат, холбогдох тэмдэглэл.

Төслийн хэлэлцүүлэг, үе шат	Холбогдох хуралдаан, огноо	Тэмдэглэл татах холбоос (2022.04.27-ны өдрийн хандалт)
Нэг. Хуулийн төслийг хэлэлцэх эсэх	Хууль зүйн байнгын хороо, 2015.12.22	http://www.parliament.mn/files/5900
	Нэгдсэн чуулган, 2015.12.24	http://www.parliament.mn/n/5hey
Хоёр. Хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг	Хууль зүйн байнгын хороо, 2016.01.20	http://www.parliament.mn/n/dweo
	Нэгдсэн чуулган, 2016.01.22	http://www.parliament.mn/n/geeo
	Нэгдсэн чуулган, 2016.01.26	http://www.parliament.mn/n/caeo
Гурав. Хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэг, батлах	Хууль зүйн байнгын хороо, 2016.01.27	http://www.parliament.mn/n/gyeo
	Нэгдсэн чуулган, 2016.02.04	http://www.parliament.mn/n/oaео

Хавсралт 3. Хуулийн төслийн хэлэлцүүлэх үе шатанд гарсан ач холбогдол бүхий санал

(Улсын Их Хурлын 2015 оны намрын ээлжит чуулганы Хууль зүйн байнгын хорооны 12 дугаар сарын 22-ны өдөр (Мягмар гараг)-ийн хуралдааны гар тэмдэглэл, <http://www.parliament.mn/files/5900>)

Тэмдэглэлд тусгагдсан санал, хуудасны тал

Хууль санаачлагчийн илтгэлийг З.Баянсэлэнгэ гишүүн танилцуулахдаа “...Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэлийн нэг нь нийтийн эрх ашгийг нэхэмжлэх, нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэх асуудлыг хуульчлах...” зэрэг шаардлагын дагуу холбогдох хуулийн төслийг боловсруулсан болохыг дурджээ. 30 дахь тал.

Ж.Батзандан гишүүн тус хуулийн төсөлд багтсан чухал ач холбогдол нь “нийтийн эрх ашгийн үүднээс төрийн бус байгууллагууд, иргэний нийгмийн байгууллагууд, иргэд захиргааны шүүхэд маргаан үүсгэх бололцоо боломжийг энэ хуулиар илүүтэй нээж өгч байна гэж ойлгож байна. Энэ бол НҮБ-аас Монгол Улсад тавьсан нэг шаардлага, энэ биеллээ олж байна гэж ойлгож байна...” хэмээн тодорхойлжээ. 27-28 дахь тал.

Х.Тэмүүжин гишүүн “...Нийтийн ашиг сонирхлыг итгэмжлэн шүүхэд гомдол гаргах эрхийг төрийн бус мэргэжлийн байгууллагад нь шилжүүлэх энэ бололцоог олгож ирж байгаагаар бидэнд илүү мэдээлэлтэй, илүү туршлагатай, асуудлыг ул суурьтайгаар харж чадах тэр хэсэг нь маргаанд оролцох боломжийг бий болгож байгаагаар нийтийн ашиг сонирхол өөрөө хамгаалагдах баталгааг нэлээн сайжруулж өгч байгаа юм...” гэжээ. 33 дахь тал.

Ц.Оюунгэрэл гишүүн “...Нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалах нэхэмжлэл гаргах субъектийн талаар яг хэн хэн гэдэг субъектүүд орж ирж байгаа вэ гэдэг дээр хариулт авахыг хүсэж байна. ... Жишээлбэл, Хөвсгөл нуурын эрх ашгийг хамгаалж шүүхэд хандахыг хүсэж байгаа төрийн бус байгууллагад бол Хөвсгөл нуурын эрэг орчим оффис нь заавал байх ёстой гэдэг шаардлагыг шүүхээс тавиад эхэлдэг юм билээ. ... Ийм ийм газар нутгийн харьяалал зааж өгч байж шүүх нь тэр нэхэмжлэгчийг тодорхойлдог юм билээ. Тэгэхээр манайх дээр нэхэмжлэгч нь хэн ч байж болохоор байна уу. Аль ч нутаг дэвсгэр дээр байж болохоор байна уу. Гадаадад амьдарч байснаа гэнэт Монголд орж ирээд шүүхийн үйл ажиллагаанд оролцоод байдаг субъект гарч ирэх нь үү, яах нь вэ гэдэг нь надад тодорхойгүй байна. Тиймээс энэ нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалах гэж нэхэмжлэл гаргах эрхтэй болж ирж байгаа субъектүүд нь хэн хэн байх вэ; тэр субъектүүд нь одоогийнхоо Засаг даргынхаа өчүүхэн жижиг хүрээнээс хальж, томорч чадсан уу; томорлоо гэхэд тэнд бас хэмжээ хязгааргүй, эцэс төгсгөлгүй нэхэмжлэлд шүүхэд дарагдахгүй, захиргааны шийдвэр бас эцэс төгсгөлгүй нэхэмжлэлд уягдахгүйн тулд ямар хүрээгээр үүнийг тогтоосон бэ гэдэг дээр асуулт асуух гэсэн юм. ...” гэж бичжээ. 30-31 дэх тал.

Улсын Дээд шүүхийн Захиргааны танхимын тэргүүн М.Батсуурь УИХ-ын гишүүн Ц.Оюунгэрэлийн асуултад хариулахдаа "...Засгийн газрын мөрийн хөтөлбөрт нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалах эрх зүйн орчныг сайжруулах гэж мөрийн хөтөлбөрт туссан юм билээ. Яг энэ мөрийн хөтөлбөрт яг ямар хүрээнд нийтийн эрх ашгийг хамгаалах юм бэ гэдгийг заасны дагуу хуулийн төсөлд тусгасан. Өөрөөр хэлбэл хүрээлэн байгаа орчин, хүүхдийн эрх, нийтийн эрүүл мэнд, нийтийн өмчийг хамгаалах гэсэн ийм дөрвөн үндсэн хүрээнд нийтийн эрх ашгийг хамгаалах ийм нэхэмжлэл гаргах юм байна гэдэг ийм мөрийн хөтөлбөрт заасан байна билээ. Харин хуулиар энэ асуудлаар нэхэмжлэл гаргах гэж байгаа төрийн бус байгууллагад хоёр шаардлагыг зааж өгсөн. Энэ нь ямар шаардлага вэ гэхээр, нэгдүгээрт, нэхэмжлэл гаргаж байгаа төрийн бус байгууллагын үндсэн зорилгод нь нийцсэн байх. Тухайлбал, хүрээлэн буй байгаль орчноор нэхэмжлэл гаргах гэж байгаа бол яг тэр зорилгоор үйл ажиллагаа явуулдаг дүрэмдээ заачихсан байх. Хоёрдугаарт, тэр дүрэмд заасан зорилгынхоо дагуу гурваас дээш жил тогтвортой ажилласан байх гэсэн ийм хоёр шаардлагыг хуульд хийж өгсөн. Тэгэхээр манайх үүгээрээ таны хэлж байгаа Америкийн гэдэг юм уу, Германд байхгүй, түүнээс илүү урагшаа алхсан ийм төсөл, зүйлийг тусгачихсан байгаа..." гэж дурджээ.

Дээрх М.Батсуурь шүүгчийн дурдсан Засгийн газрын мөрийн хөтөлбөр нь УИХ-ын 2012 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн “Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 36 дугаар тогтоол юм. Уг тогтоолын хавсралтад “нийтийн эрх ашгийг төлөөлөн нэхэмжлэх эрх зүйн орчныг бүрдүүлж, байгаль хамгаалал, хүүхдийн эрх, нийтийн эрүүл мэнд, нийтийн өмч, дэд бүтэцтэй холбоотой асуудлыг шүүхэд нэхэмжлэн хамгаалах стратегийн өмгөөлөл, бодлогын нөлөөллийг бүх талаар дэмжих” гэж тусгажээ.³¹ ЗХШХШТХ-ийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсэгт “Хуулиар тусгайлан эрх олгогдсоноос бусад нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд нь хүрээлэн байгаа орчин, хүүхдийн эрх, нийтийн эрүүл мэнд, нийтийн өмчийг хамгаалах асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй бөгөөд уг этгээд дараах шаардлагыг хангасан байна:...” гэж заажээ.

Дээрх Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсан байгаль хамгаалалтай холбоотой асуудлаар шүүхэд нэхэмжлэн хамгаалах стратегийн өмгөөлөл, бодлогын нөлөөллийг бүх талаар дэмжих тухай зорилт нь хуульд “хүрээлэн байгаа орчин” гэсэн агуулгаар тусгалаа олжээ гэж дүгнэхээр байна. Энэ нь хуульд заасан “хүрээлэн байгаа орчин” гэдэг нь дан ганцхан “байгаль хамгаалал” гэсэн явцуу хүрээнд бус хүний ажиллаж амьдрах ая тухтай орчин, нийгмийн орчныг мөн адил хамаарах илүүтэй өргөн хүрээнд тайлбарлаж хэрэглэх боломжтой байдлаар хуульд тусгагдсан гэж хувь судлаачийн үүднээс дүгнэхээр байна.

³¹ Монгол Улсын Их Хурлын тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай, 2012 оны 9 дүгээр сарын 18-ны өдөр, дугаар 37. <https://legalinfo.mn/mn/detail/8722> 2022.04.27-ны өдрийн хандалт.

Хавсралт 4. Хуулийн төслийн хэлэлцүүлэх үе шатанд гарсан ач холбогдол бүхий санал

(УИХ-ын 2015 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сарын 24-ний өдөр (Пүрэв гараг)-ийн нэгдсэн хуралдааны тэмдэглэл, <http://www.parliament.mn/n/5hey>)

Тэмдэглэлд тусгагдсан санал, хуудасны тал

Ж.Батзандан гишүүн “...өнөөдрийг хүртэл төрийн бус байгууллагууд, иргэд, олон нийтийн байгууллагууд нийтийн эрх ашгийг зөрчигдсөн гэж үзвэл шүүхэд нэхэмжлэл гаргах, гомдол гаргах эрх нь хязгаарлагдмал байсан. Энэ хуулиар нийтийн ашиг сонирхлын үүднээс шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийг илүү нээлттэй болгосон Засгийн газарт бас талархал илэрхийлэхийг хүсэж байна...” гэжээ. Түүнчлэн “...одоо хэрэгжиж байгаа хуулиар бол захиргааны байгууллагын хууль бус үйл ажиллагааны улмаас эрх нь зөрчигдсөн тохиолдолд, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар шүүхэд хандаж байна. Хуулийн төсөл дээрх эрх нь зөрчигдсөн бол зөрчигдөж болзошгүй эрхээ хамгаалуулахаар гэж ийн орж ирж буй. Үүнийг тодруулмаар байна. Зөрчигдөж болзошгүй эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар. Өөрөөр хэлбэл, урьдчилсан хамгаалалт хийлгэхээр шүүхэд хандаж байгаа нь хэр зохимжтой вэ? Шүүхийн ачаалал талаасаа тохирч байгаа юу гэдгийг надад тайлбарлаж өгмөөр байна...” хэмээн асуужээ. 93 дахь тал.

Ж.Батзандан гишүүний асуултад Д.Дорлигжав хариулахдаа “...Нэгдүгээрт, энэ хуулиар эрх нь зөрчигдсөн иргэн гомдол гаргана. Хоёрдугаарт, өөрийнх нь эрх зөрчигдөөгүй ч гэсэн аливаа нэг харилцааг зохицуулсан захиргааны хэм хэмжээний актууд тухайн үед өөрийнх нь эрхийг зөрчөөгүй ч гэсэн хэзээ нэгэн цагт одоо зөрчилдөж болох, харшилсан гэж үзвэл тэр одоо хууль бус байна гэдэг үндэслэлээр гомдол гаргаж болохыг заасан...” гэж хариулжээ. 95 дахь тал.

Хавсралт 5. Хуулийн төслийн хэлэлцүүлэх үе шатанд гарсан ач холбогдол бүхий санал

(Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2016 оны 1 дүгээр сарын 20-ны өдөр (Лхагва гараг)-ийн хуралдааны тэмдэглэл, <http://www.parliament.mn/n/dweo>)

Тэмдэглэлд тусгагдсан санал, хуудасны тал

Р.Гончигдорж гишүүн “...52.5.5 дахь заалт хангалттай ашиг сонирхлыг илэрхийлсэн байх гэсэн нь өөрөө нийтийн ашигт сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргахтай холбогдсон харилцаа шүү дээ, тийм үү? Үүнийг маргаж байгаа асуудлын талаар хангалттай ашиг сонирхолтойгоо илэрхийлсэн байх гэж. Сонирхолтойгоо гэдэг бол тэр гаргаж байгаа этгээд тийм сонирхолтой гэдгээ илэрхийлж буй илэрхийлэл болно шүү дээ, сонирхолтойгоо гэдэг чинь өөрт нь харьяалуулсан ашиг сонирхлын тухай асуудал болж байгаа юм. Гэтэл надад ямар ч ашиг сонирхлыг тийм зөрчлийн юм нь би хохирч байгаа асуудал байхгүй. Ингэснээр энэ асуудлаар нийтийн ашиг сонирхол ингэж хөндөгдөхөөр байна. Энд нийтийн ашиг сонирхол ингэж илэрхийлэгдэж байгаа гэдгээр илэрхийлсэн байх нь хангалттай шүү дээ. Түүнээс ашиг сонирхолтойгоо илэрхийлсэн байх гэдэг бол монгол хэлээр өөрөө ашиг сонирхолтойгоо илэрхийлж байгаа хэлбэр байхгүй юу. Болохгүй шүү дээ. Тийм учраас үүнийг нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргаж байгаа этгээдийн хувьд тэр хүн ашиг сонирхол өөрөө ашиг сонирхолгүй байх, хувьд гэдэг чинь тэр хүний хувьд гэсэн үг биш байхгүй юу. Түүнчлэн заасан нэхэмжлэлийн шаардлага түүний үндэслэл нь дараах зүйл хамаарна гэж 52.5-ын тэр хэсэг чинь тэр хэсэгт хамааруулж тэр этгээдийн хувьд гэдэг нь тэр хүн хангалттай ашиг сонирхлыг илэрхийлсэн байх ёстой гэж, нөгөө нийтийн ашиг сонирхлын байдлыг нь ингэж орж ирэх ёстой байхгүй юу...” гэж хэлжээ. 44 дэх тал.

Ц.Оюунгэрэл гишүүн "...52 дээр хангалттай ашиг сонирхлыг илэрхийлсэн байх гэдэг хуучин заалт нь зөв байхгүй юу. Хангалттай ашиг сонирхолтойгоо илэрхийлсэн байх гэдэг чинь шал өөр юм болоод явж байгаа юм. Хувь хүний сонирхол, нийтийн сонирхол хоёрыг холиод явж байгаа юм. Үүн дээр хуучин нь зөв. Дээр нь 52.5.3 дээр нийтийн эрх зүйн харилцаа байгаа эсэхийг тогтоолгох нэхэмжлэлийн хувьд эрх зүйн харилцаа байгаа эсэхийг тогтоолгосноор нэхэмжлэгчид ямар эрх, хууль ёсны ашиг сонирхол үүсэхийг гэдэг энэ хэсэг тун ойлгомжгүй байна. Саяын тэр сонирхолтойгоо гэдэгтээ уялдаад явчих шиг болох юм. Тэгэхээр үүнийгээ найруулахдаа эргэж тодруулаад нийтийн эрх ашгийг тодорхойлж байгаа хүн бол заавал хувийн эрх ашигтай байх албагүй гэдэг утгыг нэг мөр оруулж өгмөөр байна. Тэгэхгүй бол нийтийн эрх ашгийн төлөө нэхэмжлэл гаргаж байгаа этгээд заавал хувийн эрх ашигтай байх ёстой юм шиг ийм заалтууд давхар орж ирж болохгүй. Тэр хүн хувийн эрх ашиггүй болно тэр асуудал дээр. Яагаад вэ гэхээр нийтийн эрх ашгийг тодорхойлж байгаа учраас нийтийн эрх ашиг зөрчилдсөн эсэхийг тодорхойлж өгч чадаж байх хэрэгтэй. Түүнээс биш бүх юм дээр нэхэмжлэгчийн өөрийнх нь ямар эрх ашиг хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн болгоныг нийтийн эрх ашиг дээр тодорхойлох албагүй шүү дээ" гэж хэлжээ. 44 дэх тал

Ж.Батзандан гишүүн "Тэгэхээр нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд дөрвөн асуудлаар нэхэмжлэл гаргах эрхтэй. Байгаль орчин, хүүхдийн эрх, нийтийн эрүүл мэнд, нийтийн өмчийг хамгаалах асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй байгаа. Гэхдээ энэ нэхэмжлэл гаргах этгээд нь бас хуульд заасан хоёр шаардлагыг хангасан байх ёстой. Нэхэмжлэлийн шаардлага нь тухайн байгууллагын дүрмийн зорилгод нийцсэн байх.

Өөрөөр хэлбэл, тухайн төрийн бус байгууллага байлаа гэхэд тэр дүрэмд нь нэхэмжлэлийн шаардлага нийцсэн байх, орсон байх гэсэн үг. Хоёрдугаарт, дүрмийн зорилгын дагуу сүүлийн гурваас доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх. Тухайлбал, байгаль хамгаалах чиглэлийн байгууллагууд бол гурваас доошгүй жил энэ чиглэлээрээ үйл ажиллагаа явуулсан тухайн байгаль хамгаалах байгууллагын дүрэмд энэ зорилго нь тодорхой тусгагдсан байх ёстой гэж. Үүнтэйгээ уялдуулаад нэхэмжлэлийн шаардлагадаа үүнийгээ тодорхой дурдах ёстой гэдэг үүднээс оруулж өгсөн байх гэж би ойлгож байгаа...” гэж хэлжээ. *46 дахь тал.*

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч Ц.Цогт “...нийтийн эрх ашгийг төлөөлөх нэхэмжлэлийг нээхдээ бид хоёр этгээдэд эрх нээсэн байгаа энэ хуулиар анх удаа нээж байгаа. Нэгдүгээрт, хуулиар эрх олгогдсон этгээд ямар нэгэн шалгуургүйгээр нийтийн эрх ашгийн асуудлаа нэхэмжлээд явчих юм. Тухайлбал, Байгаль орчныг хамгаалах тухай хуульд байгаа байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага ч гэдэг юм уу, хуулиар эрх олгогдсон учраас. Нөгөө бусад этгээд буюу энэ хуулийн төслийн 3.1.9, 18.3 гэдэг зохицуулалтууд дээр бусад этгээд хуулиар эрх олгогдоогүй этгээдүүд нийтийн эрх ашгийн төлөө нэхэмжлэл гаргахаар бол тухайн нэхэмжилж байгаа асуудлаараа өөрөө үйл ажиллагаа явуулдаг, сая Батзандан гишүүний хэлснээр тодорхой мэргэжлийн тийм байгууллага байх ёстой гэсэн концепц, үзэл баримтлалаар нийт эрх ашгийг нэхэмжлэх асуудлыг оруулж ирсэн учраас саяын өөрт тодорхой хангалттай ашиг сонирхлоо илэрхийлсэн байх ёстой гэсэн тийм үгнүүд орж ирж байгаа юм. Тэрийг нь эргүүлээд арай өөр байдлаар өөрт нь хамааралтай гэдэг утгаар нь үйл ажиллагаа явуулдаг мэргэжлийн үйл ажиллагаа гэдгээр үү? Тэрийг нь бид ажлын хэсэг дээр буцаагаад найруулга дээр нь ярина, ойлголоо” гэж хариулжээ. *46 дахь тал.*

Хавсралт 6. Хуулийн төслийн хэлэлцүүлэх үе шатанд гарсан ач холбогдол бүхий санал

(Хууль зүйн байнгын хорооны 2016 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр (Лхагва гараг)-ийн хуралдааны тэмдэглэл, <http://www.parliament.mn/n/gyeo>)

Тэмдэглэлд тусгагдсан санал, хуудасны тал

Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын шүүгч М.Батсуурь "...нийтийн ашиг сонирхлыг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргаж байгаа төрийн бус байгууллагын хувьд хангалттай ашиг сонирхолтой буйгаа илэрхийлсэн байх гэдэг ийм шаардлагыг Гончигдорж гишүүн тухайн төрийн бус байгууллагад заавал тийм ашиг сонирхол нь хөндөгдсөн байх асуудал байх ёсгүй юм. Ийм учраас энэ нэр томъёогоо эргэж хараач гэсэн. Гончигдорж гишүүний саналыг аваад ажлын хэсэг дээр ашиг сонирхол гэдгийн ашиг гэдэг үгийг нь аваад нийтийн асуудлаар сонирхолтойгоо илэрхийлсэн байх гэсэн томъёолол болгож оруулсан байгаа..." гэж хэлжээ.

33 дахь тал.

Хавсралт 7. Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан дахь хайлтын илэрц

(Түлхүүр үгийн хайлтыг эцсийн байдлаар 2022.04.24-ний өдөр хийсэн болно.)

Түлхүүр үг	Нийт илэрц	“Хангалттай сонирхол илэрхийлсэн байх” зохицуулалттай хамааралтай илэрц
“Хангалттай сонирхол”	2120 илэрц.	Нийт 9 илэрц; - Дүн шинжилгээ хэрэг 1-д хамаарах илэрц https://shuukh.mn/single_case/1949?start_date=&end_date=&id=3&court_cat=3&bb=1 - Дүн шинжилгээ хэрэг 2-т хамаарах илэрц. https://shuukh.mn/single_case/2586?daterange=2020/01/01%20-%202021/01/26%20&id=3&court_cat=3&bb=1 - Дүн шинжилгээ хэрэг 3-т хамаарах илэрц. https://shuukh.mn/single_case/1965?start_date=&end_date=&id=3&court_cat=3&bb=1 - Дүн шинжилгээ хэрэг 4-д хамаарах илэрц. https://shuukh.mn/single_case/2129?start_date=&end_date=&id=3&court_cat=3&bb=1 - Дүн шинжилгээ хэрэг 4-д хамаарах илэрц. https://shuukh.mn/single_case/2463?start_date=&end_date=&id=2&court_cat=3&bb=1 - Дүн шинжилгээ хэрэг 4-д хамаарах илэрц. https://shuukh.mn/single_case/1663?start_date=&end_date=&id=3&court_cat=3&bb=1

		7. Дүн шинжилгээ хэрэг 4-д хамаарах илэрц. https://shuukh.mn/single_case/3024?start_date=&end_date=&id=2&court_cat=3&bb=1 8. Дүн шинжилгээ хэрэг 4-т хамаарах илэрц. https://shuukh.mn/single_case/6136?start_date=&end_date=&id=1&court_cat=3&bb=1 9. Дүн шинжилгээнд багтаагүй хэрэг. Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр. 2021.08.24-ний өдрийн Дугаар 128/ШШ2021/0548 (128/2018/1018/3). Нэхэмжлэгч “МБОТХХ” НҮТББ, хариуцагч Ашигт малтмал, газрын тосны газар. https://shuukh.mn/single_case/8607?start_date=&end_date=&id=1&court_cat=3&bb=1
“Нийтийн ашиг сонирхлыг”	3480 илэрц	Нийт 6 илэрц (Дээрх 9 илэрцтэй давхардсан): 1. Дүн шинжилгээ хэрэг 1-д хамаарах илэрц https://shuukh.mn/single_case/1949?start_date=&end_date=&id=3&court_cat=3&bb=1 2. Дүн шинжилгээ хэрэг 2-т хамаарах илэрц. https://shuukh.mn/single_case/2586?daterange=2020/01/01%20-%202021/01/26%20&id=3&court_cat=3&bb=1 3. Дүн шинжилгээ хэрэг 3-д хамаарах илэрц. https://shuukh.mn/single_case/1965?start_date=&end_date=&id=3&court_cat=3&bb=1

4. Дүн шинжилгээ хэрэг 4-д хамаарах илэрц. https://shuukh.mn/single_case/2129?start_date=&end_date=&id=3&court_cat=3&bb=1
5. Дүн шинжилгээ хэрэг 4-т хамаарах илэрц. https://shuukh.mn/single_case/3024?start_date=&end_date=&id=2&court_cat=3&bb=1.
6. Дүн шинжилгээ хэрэг 4-д хамаарах илэрц. https://shuukh.mn/single_case/2463?start_date=&end_date=&id=2&court_cat=3&bb=1

Хавсралт 8. Дүн шинжилгээ 4-д дурдсан хэргийн эхний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шат

Огноо, дугаар	Шүүхийн нэр	Шийдвэрийн товч, татах холбоос
2018.06.07 Дугаар 128/ ППП2018/361	Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх	Нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж, ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийг цуцлах тухай шийдвэр гаргахыг хариуцагч Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтэст даалгаж шийдвэрлэсэн.
2018.09.13 Дугаар 221/ МА2018/0510	Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх	Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн 128/ППП2018/361 дүгээр шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр мөн шүүхэд буцааж шийдвэрлэсэн. Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан, https://shuukh.mn/single_case/2463?start_date=&end_date=&id=2&court_cat=3&bb=1 2022.04.27-ны өдрийн хандалт.

2018.11.14 Дугаар 0458	Улсын дээд шүүх	Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018.09.13-ны өдрийн магадлалыг хэвээр үлдээж, нэхэмжлэгчийн өмгөөлөгчийн хяналтын журмаар гаргасан гомдлыг хангахгүй орхисон. Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан, https://shuukh.mn/single_case/1663?start_date=&end_date=&id=3&court_cat=3&bb=1 2022.04.27-ны өдрийн хандалт.
---------------------------	--------------------	---

ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН СУДАЛГАА ХАРИУЦСАН РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙН ТАНИЛЦУУЛГА

ДАШНЯМЫН ЗОЛЖАРГАЛ (LL.M, MBA)

Өмгөөллийн DB>S ХХН-ийн гишүүн хуульч



Өмгөөллийн DB>S ХХН-ийн Гүйцэтгэх захирал тэрээр Монголын санхүү, банк, хөрөнгийн зах зээлийн чадварлаг мэргэжилтний нэг бөгөөд компанийн эрх зүй, эрчим хүч, эрдэс баялгийн салбараар мэргэшсэн хуульч юм. Хуулийн зөвлөх үйлчилгээний хувийн салбарт 15 дахь жилдээ ажиллаж байгаа. Түүнээс өмнө Монголын томоохон арилжааны банканд хуульчаар ажиллахын зэрэгцээ МУИС-ийн Хууль зүйн сургууль, “Билиг” дээд сургуульд хичээл зааж байсан туршлагатай. МУИС-ийн Хууль зүйн сургуулийг олон улсын эрх зүйн бакалавр, АНУ-ын Оклахомагийн Их сургуулийг бизнесийн удирдлагын магистр, АНУ-ын Харвардын Их сургуулийн Хуулийн сургуулийг хууль зүйн магистр зэрэгтэй тус тус дүүргэсэн. Chambers & Partners, Legal500, IFLR зэрэг олон улсын хуульчдын зэрэглэл тогтоодог байгууллагаас Д.Золжаргал, түүний удирдаж ирсэн хуулийн фирмийг олон жилийн турш өндрөөр үнэлсэн байдаг.

АЛТАНГЭРЭЛИЙН БЯМБАЖАРГАЛ (S.J.D.)



МУИС-ийн Хууль зүйн сургуульд төрийн захиргаа, Монгол Улсын Үндсэн хуулийн эрх зүй, Үндсэн хуулийн процессын эрх зүй, харьцуулсан эрх зүйн хичээл заадаг. Хууль зүйн сургуулийн эрдэмтэн нарийн бичгийн даргын хувиар эрдэм шинжилгээний ажил, бүтээл түүрвил, улирал тутмын “Эрх зүй” сэтгүүлийг эрхлэн гаргах ажил хариуцан ажиллаж байв. 2021 оноос Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хууль зүйн бодлогын зөвлөхөөр томилогдон ажиллаж байна.

МУИС-ийн Хууль зүйн сургуулийг дүүргэж, БНСУ-ын Күүкманий Их сургуульд хууль зүйн докторын зэрэг хамгаалсан.

НАРАНЧУЛУУНЫ ОТГОНЧИМЭГ (LL.M.)



Захиргааны эрх зүйн чиглэлээр мэргэшсэн судлаач бөгөөд УДШ-ийн Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн захирал, УИХ-ын Тамгын газар, олон улсын хөгжлийн хөтөлбөрүүдэд зөвлөх зэргээр мэргэжлээрээ 23 жил ажилласан туршлагатай хуульч юм. 2021 оны 11 дүгээр сараас Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр ажиллаж байна. МУИС-ийн Хууль зүйн сургуулийг эрх зүйч мэргэжлээр, магистрын зэрэгтэй, Лондоны Kings college-ийг хууль зүйн магистр зэрэгтэй төгссөн.

ГАНЧУЛУУНЫ ОЮУНБОЛД (LL.M.)



Криминологи, эрүүгийн эрх зүй, эрүүгийн процессын чиглэлээр мэргэшин судалдаг ба практик болон судалгааны байгууллагад 20 жил ажилласан туршлагатай. Цагдаагийн академийг эрх зүйч, Хүмүүнлэгийн ухааны Их сургуулийг англи хэл-менежерийн бакалавр зэрэгтэй төгсөж, 2007 онд “Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны хугацаа” сэдвээр хууль зүйн магистрын зэрэг хамгаалсан. Түүнчлэн академик болон бодлогын судалгааны чиглэлээр дангаар, бусадтай хамтран 40 орчим судалгааны ажил, 20 гаруй сурах бичиг, гарын авлага боловсруулж нийтийн хүртээл болгосон. Хуульч, хууль сахиулагчийг чадавхжуулах хүрээнд 10 орчим жил сургагч багшаар ажиллаж байна.

СҮХЭЭГИЙН БИЛГҮҮН (LL.M.)



Тэрээр хууль зүйн судалгаа, сургалт, шүүхийн захиргааны чиглэлээр ажилладаг.

МУИС-ийн Хууль зүйн сургуульд суралцаж “Монгол Улсад эрх зүйн зайлшгүй процессыг төлөвшүүлэх нь” сэдвээр, Япон Улсын Кьюсюгийн Их сургуульд суралцаж “Монгол Улс дахь нийтийн ашиг сонирхлыг шүүхэд төлөөлөн хамгаалах тогтолцоог бэхжүүлэх нь” сэдвээр хууль зүйн магистрын зэрэг түс түс хамгаалсан. Харьцуулсан эрх зүй, хүний эрхийн чиглэлээр судалгаа хийдэг.

